



ОУХБ/АЙПЕК

**Албан бусаар алт,  
жонш олборлож  
байгаа хүүхэд,  
насанд хүрэгчдийн  
суурь судалгаа**

МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны  
ТӨВ

2006 он

## АГУУЛГА

	<i>Оооаай</i>
Хураангуй	vii
<b>БҮЛЭГ 1. Удиртгал</b>	<b>1</b>
<i>Баатаржавын Нарантулга</i>	
1.1 Үндэслэл	1
1.2 Судалгааны зорилго, судалсан асуудлууд	1
1.3 Илтгэлийн бүтэц	2
<b>БҮЛЭГ 2. Судалгааны аргачлал, арга зүй</b>	<b>3</b>
<i>Баатаржавын Нарантулга</i>	
2.1 Тоон судалгааны арга зүй	4
2.1.1 Түүвэрлэлтийн арга зүй	4
2.1.2 Түүврийн жин ба тооцооллын арга зүй	8
2.1.3 Асуулгын хуудас	9
2.1.4 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	10
2.1.5 Судалгааны хязгаарлагдмал байдал	10
2.2 Чанарын судалгааны арга зүй	11
<b>БҮЛЭГ 3. Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрх, хүн амын шинж байдал</b>	<b>12</b>
<i>Баатаржавын Нарантулга</i>	
3.1 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрхийн шинж байдал	12
3.2 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын шинж байдал	13
<b>БҮЛЭГ 4. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд</b>	<b>21</b>
<i>Баян-Өлзийн Эрдэнэсүвд</i>	
4.1 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн шинж байдал	21
4.1.1 Хүн ам зүйн шинж байдал	21
4.1.2 Шилжих хөдөлгөөн	22
4.1.3 Амьдралын нөхцөл, ар гэрийн байдал	25
4.1.4 Сургуульд хамрагдалт ба бичиг үсгийн мэдлэг	30
4.2 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт	33
4.2.1 Өнгөрсөн үеийн ажил эрхлэлт	34
4.2.2 Одоогийн ажил эрхлэлт	35
4.3 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн орлого ба зарцуулалт	44
4.4 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал	48
4.4.1 Хүүхдийн хооллолтын байдал	48
4.4.2 Эрүүл мэндийн байдал	49
4.4.3 Хөдөлмөр хамгааллын байдал	52
4.5 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн дадал зуршил ба чөлөөт цаг, ирээдүйн хүсэл эрмэлзлэл	56
4.5.1 Муу дадал зуршил	56
4.5.2 Мэдлэг, хандлага, чөлөөт цаг ба ирээдүйн хүсэл эрмэлзлэл	56
<b>БҮЛЭГ 5. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн эцэг/эх</b>	<b>62</b>
<i>Төмөртолгойн Навч</i>	
5.1 Өрхийн шинж байдал	62
5.2 Өрхийн ахуйн нөхцөл	65
5.3 Шилжих хөдөлгөөн	66
5.4 Өрхийн орлого ба амьжиргаа	68
5.5 Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх эцэг/эхийн бодол	73

<b>БҮЛЭГ 6.</b>	<b>Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдэд ажил олгогчид</b>	80
<i>Батцэнгэлийн Мөнхжаргал</i>		
6.1	Ажил олгогчдын шинж байдал	80
6.2	Хүүхдийн ажил эрхлэлт, ажлын нөхцөл дэх ажил олгогчийн хандлага	83
6.2.1	Хүүхдийн ажил эрхлэлтийг тодорхойлж буй байдал	83
6.2.2	Хүүхдийн хөдөлмөрийг үнэлж буй байдал	87
6.2.3	Хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл ба нийгмийн хамгааллын асуудалд хандаж буй байдал	88
6.3	Хүүхдийн хөдөлмөрийн талаарх ажил олгогчийн үзэл бодол ба мэдлэг	90
<b>БҮЛЭГ 7</b>	<b>Албан бусаар алт/жонш олборлож буй насанд хүрэгчдийн байдал</b>	94
<i>Алгаагийн Солонго</i>		
7.1	Насанд хүрэгчдийн шинж байдал	94
7.2	Албан бусаар алт/жонш олборлолт ба шилжих хөдөлгөөн	95
7.3	Албан бусаар алт/жонш олборлож буй насанд хүрэгчдийн амьдарч буй орчин	99
7.4	Ажлын зохион байгуулалт	101
7.5	Ажлын нөхцөл, хөдөлмөр хамгаалал	102
7.6	Эрүүл мэндийн зарим асуудлууд	106
7.7	Хүмүүсийн хоорондын зөрчилдөөн	107
7.8	Орлого ба амьжиргааны түвшний өөрчлөлт	108
7.9	Ажиллаж буй хүүхдийн талаарх насанд хүрэгчдийн үзэл бодол	109
7.10	Албан бусаар алт/жонш олборлогчдын цаашдын хандлага	110
<b>БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ</b>		112
<b>ХАВСРАЛТ</b>		114
1	Судалгаанд оролцогчдын нэрс	112
2	Өрхийн асуулга	115
3	Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдээс асуух асуулга	116
4	Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн эцэг/эхийн асуулга	130
5	Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн ажил олгогчоос асуух асуулга	138
6	Албан бусаар алт/жонш олборлож байгаа насанд хүрэгчдээс асуух асуулга	143

## ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 2.1</i>	Албан бусаар алт/жонш олборлодог сумууд, мужаар	5
<i>Хүснэгт 2.2</i>	Түүвэрлэлтийн нэгдүгээр шатанд сонгогдсон сумуудын тоо, мужаар	6
<i>Хүснэгт 2.3</i>	Түүвэрлэлтийн нэгдүгээр шатанд сонгогдсон сумууд	6
<i>Хүснэгт 2.4</i>	Судалгаанд хамрагдсан болон тооцоолсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхэд, насанд хүрэгчдийн тоо, сонгосон шинж байдлаар	9
<i>Хүснэгт 2.5</i>	Судалгаанд хамрагдалт	10
<i>Хүснэгт 3.1</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй өрхүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлт, байршлаар	12
<i>Хүснэгт 3.2</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын хувийн жин, түүвэрлэгдсэн аймаг, хүйсээр	13
<i>Хүснэгт 3.3</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын хувь, насны бүтцийг харуулах зарим үзүүлэлт болон хүйсээр	15
<i>Хүснэгт 3.4</i>	Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, алт/жонш олборлоход оролцдог эсэх, насны бүлгээр	17
<i>Хүснэгт 3.5</i>	6-17 насны хүүхдүүдийн хувийн жин, сургуульд сурдаг эсэх, сонгосон үзүүлэлтээр	18
<i>Хүснэгт 3.6</i>	Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, шилжих хөдөлгөөний үзүүлэлт ба алт/жонш олборлоход оролцдог эсэхээр	19
<i>Хүснэгт 4.1</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, насаар	21
<i>Хүснэгт 4.2</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, түүвэрлэгдсэн аймгаар	22
<i>Хүснэгт 4.3</i>	Шилжих хөдөлгөөнд оролцсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувь, олборлож буй ашигт малтмалын төрөл, нас, хамт ирсэн хүмүүсээр	24
<i>Хүснэгт 4.4</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	25
<i>Хүснэгт 4.5</i>	Уурхайн орчимд амьдардаг албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	27
<i>Хүснэгт 4.6</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, бичиг баримтын бүрдэл, сонгосон үзүүлэлтээр	29
<i>Хүснэгт 4.7</i>	Уншиж, бичиж чаддаггүй албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувь, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	30
<i>Хүснэгт 4.8</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, сургуульд суралцдаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	31
<i>Хүснэгт 4.9</i>	Сургуульд сурахгүй байгаа албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувь, суралцахгүй байгаа шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл, эцэг/эхтэйгээ хамт амьдардаг эсэхээр	33
<i>Хүснэгт 4.10</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувь, хамтран ажилладаг хүмүүс, олборлож буй ашигт малтмалын төрөл, насаар	38
<i>Хүснэгт 4.11</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, уурхайд хийдэг ажлууд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	38
<i>Хүснэгт 4.12</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ашигладаг багаж хэрэгслүүд болон олборлож буй ашигт малтмалын төрлөөр	39
<i>Хүснэгт 4.13</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ажилладаг нөхцөл, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	40
<i>Хүснэгт 4.14</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ажлын цагийн ногдол, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	42
<i>Хүснэгт 4.15</i>	Давхар хөдөлмөр эрхэлдэг албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, эрхэлдэг ажил, насаар	43
<i>Хүснэгт 4.16a</i>	Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, хүйс, сонгосон үзүүлэлтүүдээр	44
<i>Хүснэгт 4.16b</i>	Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, хүйс, сонгосон үзүүлэлтүүдээр	45
<i>Хүснэгт 4.17</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, сонгосон орлогын үзүүлэлтүүдээр	47

<i>Хүснэгт 4.18</i>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, өдөрт хэдэн удаа халуун хоол иддэг эсэх, сонгосон үзүүлэлтээр	49
<i>Хүснэгт 4.19</i>	Ажиллаж байхдаа өвдөж байсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, сонгосон үзүүлэлтээр	52
<i>Хүснэгт 4.20</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, ажлын хувцас, багаж хэрэгслийн хэрэглээний давтамжаар	53
<i>Хүснэгт 4.21</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, зөрчил, осол гардаг эсэхээр	54
<i>Хүснэгт 4.22</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, дараахь хэлбэрийн зөрчлийн талаар сонссон эсэх ба сонгосон үзүүлэлтээр	55
<i>Хүснэгт 4.23</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй ажилдаа дуртай хүүхдүүдийн хувийн жин, ажилдаа дуртай шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл ба хүйсээр	59
<i>Хүснэгт 4.24</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй ажилдаа дургүй хүүхдүүдийн хувийн жин, шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл ба хүйсээр	60
<i>Хүснэгт 4.25</i>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс ба хөдөлмөр эрхэлж болох хуулийн насны талаарх мэдлэгээр	60
<i>Хүснэгт 5.1</i>	Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхийн гишүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	63
<i>Хүснэгт 5.2</i>	Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	64
<i>Хүснэгт 5.3</i>	Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн албан бусаар ашигт малтмал олборлодог хүүхдийн тоо, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	64
<i>Хүснэгт 5.4</i>	Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	68
<i>Хүснэгт 5.5</i>	Судалгаанд хамрагдсан малтай өрхийн малын дундаж тоо, малын болон ашигт малтмалын төрлөөр	66
<i>Хүснэгт 5.6</i>	Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн орлого нь амьжиргаанд хүрэлцдэг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	70
<i>Хүснэгт 5.7</i>	Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн гишүүд нь хангалттай хооллож чаддаг эсэх, ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	71
<i>Хүснэгт 5.8</i>	Эцэг/эхчүүдийн хувийн жин, хүүхдийнхээ ажлын орчин, нөхцлийг үнэлж буй байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	75
<i>Хүснэгт 5.9</i>	Эцэг/эхчүүдийн хувийн жин, хүүхдийнхээ ажлын хөлсийг үнэлж буй байдал, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр	77
<i>Хүснэгт 5.10</i>	Эцэг/эхчүүдийн хувийн жин, ажил хийснээр хүүхдийн эрүүл мэндэд тулгарч болох эрсдлийг үнэлсэн байдал, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр	78
<i>Хүснэгт 6.1</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	81
<i>Хүснэгт 6.2</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувь, хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	83
<i>Хүснэгт 6.3</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувь, хүүхдээр хийлгэдэг нэмэлт ажлын төрөл, ажиллуулж буй хүүхдийн хүйс, насаар	84
<i>Хүснэгт 6.4</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, ажиллуулж буй хүүхдийн ажлын цаг/өдрийг тодорхойлсон байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	86
<i>Хүснэгт 6.5</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхдэд ажлын хөлс төлдөг хэлбэр, сонгосон үзүүлэлтүүдээр	87
<i>Хүснэгт 6.6</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн талаарх хандлага, насны бүлэг, олборлож буй	

	ашигт малтмалын төрлөөр	89
<i>Хүснэгт 6.7</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчийн хувь, хүүхдийн ажлын нөхцлийн бэрхшээл болон ажил эрхлэлттэй холбоотой тулгарч болох эрүүл мэндийн эрсдлийн талаарх үзэл бодол, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	91
<i>Хүснэгт 6.8</i>	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхэд ажил хийж эхлэх хуулиар зөвшөөрөгдсөн насны талаарх мэдлэг, сонгосон үзүүлэлтээр	93
<i>Хүснэгт 7.1</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, шинж байдлын сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	94
<i>Хүснэгт 7.2</i>	Шилжин ирэгчдийн хувь, шилжилтийн шинж байдал, шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	96
<i>Хүснэгт 7.3</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	97
<i>Хүснэгт 7.4</i>	Одоогийн ажиллаж байгаа газраас шилжихийг хүсэгчдийн хувийн жин, шилжихээр төлөвлөж буй хугацаа, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	98
<i>Хүснэгт 7.5</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	99
<i>Хүснэгт 7.6</i>	Насанд хүрэгчдийн хувь, уурхайн орчимд байдаг үйлчилгээ, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	101
<i>Хүснэгт 7.7</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, давхар ажил эрхлэлт, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	101
<i>Хүснэгт 7.8</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, ажлын үргэлжлэх хугацаа, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	103
<i>Хүснэгт 7.9</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн стандартыг мөрдөж буй байдал, зарим сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	104
<i>Хүснэгт 7.10</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, хамгаалах хэрэгслийн ашиглалтын байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	105
<i>Хүснэгт 7.11</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, ажлын нөхцөл байдлын талаарх үнэлэмж, зарим сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	105
<i>Хүснэгт 7.12</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, хүмүүсийн хоорондох зөрчил, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	107
<i>Хүснэгт 7.13</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, орлогын сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	108
<i>Хүснэгт 7.14</i>	Насанд хүрэгчдийн хувийн жин, цаашид ажлаа үргэлжлүүлэн хийх эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	110

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

<i>Зураг 2.1</i>	Судалгаанд хамрагдсан аймаг, сумуудын тойм зураглал	7
<i>Зураг 3.1</i>	Хүн амын нас-хүйсийн суварга	14
<i>Зураг 3.2</i>	Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, албан бусаар алт/жонш олборлоход оролцдог эсэх, хүйсээр	16
<i>Зураг 3.3а</i>	Албан бусаар алт олборлож буй хүн амын хувийн жин, насаар	16
<i>Зураг 3.3б</i>	Албан бусаар жонш олборлож буй хүн амын хувийн жин, насаар	16
<i>Зураг 3.4</i>	Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, тухайн газарт оршин сууж буй болон оршин суухаар төлөвлөж буй хугацаа, сумандаа бүртгэлтэй эсэхээр	20
<i>Зураг 4.1</i>	Шилжих хөдөлгөөн оролцсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгаан, хүйсээр	23
<i>Зураг 4.2</i>	Албан бусаар алт/жонш олборлогч хүүхдүүдийн хувийн жин, эцэг/эхтэйгээ хамт амьдардаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, шилжих хөдөлгөөний байдлаар	28
<i>Зураг 4.3</i>	Хоёр ба түүнээс дээш ангид сурдаг хүүхдүүдийн хувийн жин, өнгөрсөн жилийн суралцсан дүн, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	32
<i>Зураг 4.4</i>	Өмнө нь өөр ажил хийж байсан албан бусаар алт олборлож буй хөвгүүдийн хувийн жин, хийж эхэлсэн анхны ажил, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	34
<i>Зураг 4.5а</i>	Ажиллаж буй уурхайгаа сольсон алт олборлогч хүүхдүүдийн хувийн жин,	35

солих болсон шалтгаанаар

<b>Зураг 4.5б</b>	Ажиллаж буй уурхайгаа сольсон жонш олборлогч хүүхдүүдийн хувийн жин, солих болсон шалтгаанаар	35
<b>Зураг 4.6</b>	Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувь, хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	36
<b>Зураг 4.7</b>	Дарамт, шахалттай тулгарсан алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, тохиолддог дарамт, шахалтын төрлөөр	41
<b>Зураг 4.8</b>	Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлосон алт/жоншийг хэн борлуулдаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, насаар	46
<b>Зураг 4.9</b>	Ажил дээрээ осол гэмтэлд орж байсан хүүхдүүдийн хувь, гэмтлийн төрөл, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	50
<b>Зураг 4.10</b>	Ажил дээрээ осол гэмтэлд орж байсан хүүхдүүдийн хувь, насны бүлэг, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	51
<b>Зураг 4.11</b>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, сургуульд сурах, ажил хийх боломжийг сонгосон байдал, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	58
<b>Зураг 5.1</b>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхэдтэй шилжин ирсэн өрхийн хувийн жин, шилжин ирсэн шалтгаан, ашигт малтмалын төрлөөр	67
<b>Зураг 5.2</b>	Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдийн хувь, ирээдүйд шилжих шалтгаанаар	68
<b>Зураг 5.3</b>	Судалгаанд хамрагдсан өрхийн хувийн жин, өрхийн сарын дундаж орлогын түвшин, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	68
<b>Зураг 5.4</b>	Өрхийн сарын дундаж орлогын бүтцийн дундчилсан тооцоо, олборлож буй ашигт малтмалын төрөл, төгрөгөөр	69
<b>Зураг 5.5</b>	Эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн орлогын дийлэнхийг бүрдүүлэгч, ашигт малтмалын төрлөөр	70
<b>Зураг 5.6А</b>	Алт олборлодог бага насны хүүхэдтэй эцэг/эхийн хувийн жин, алт олборлоход оролцдог эсэхээр	72
<b>Зураг 5.6Б</b>	Жонш олборлодог бага насны хүүхэдтэй эцэг/эхийн хувийн жин, жонш олборлоход оролцдог эсэхээр	72
<b>Зураг 5.7</b>	Хүүхдээ алт/жонш олборлохыг хүлээн зөвшөөрдөг эцэг/эхийн хувь, ашигт малтмалын төрөл, шалтгаанаар	72
<b>Зураг 5.8</b>	Хүүхдээ алт/жонш олборлохыг хүлээн зөвшөөрдөггүй эцэг/эхийн хувь, ашигт малтмалын төрөл, шалтгаанаар	74
<b>Зураг 5.9</b>	Хүүхдийнхээ ажлын нөхцлийг хүнд гэж хариулсан эцэг/эхчүүдийн хувь, шалтгаан, ашигт малтмалын төрлөөр	76
<b>Зураг 6.1</b>	Ажил олгогчдын хувь, хүүхдүүдийг ажилд авсан байдал, ашигт малтмалын төрлөөр	82
<b>Зураг 6.2</b>	Хүүхдүүдэд ажлын ур чадвар эзэмшүүлсэн нэг ажил олгогчид ногдох ажлын ур чадвар эзэмшсэн хүүхдүүдийн дундаж тоо, хүүхдийн хүйс, насаар	85
<b>Зураг 6.3</b>	Ажил олгогчийн хувь, хүүхдүүдийг ажиллуулдаг улирал, ашигт малтмалын төрлөөр	85
<b>Зураг 6.4</b>	Ажиллуулж буй хүүхэд өвдөхөд тусламж үзүүлдэг ажил олгогчдын хувь, тусламжийн хэлбэр, ажил олгогчийн насны бүлгээр	90
<b>Зураг 6.5</b>	Ажил олгогчдын хувь, хүүхэд ажиллуулахын сул талыг үнэлсэн байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	92
<b>Зураг 6.6</b>	Ажил олгогчдын хувь, хүүхэд ажиллуулахын давуу талыг үнэлсэн байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	92
<b>Зураг 7.1</b>	Хоёр ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн хувь, хамт амьдарч буй хүмүүсийн хамаарал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр	95
<b>Зураг 7.2</b>	Одоогийн ажиллаж буй газраасаа шилжихийг хүсэгчдийн хувь, шалтгаанаар	98
<b>Зураг 7.3</b>	Шилжихийг хүсэхгүй байгаа насанд хүэргчдийн хувь, шалтгаанаар	98
<b>Зураг 7.4</b>	Албан бусаар алт/жонш олборлож буй уурхай орчимд үйлчилгээ байдаг эсэх	100
<b>Зураг 7.5</b>	Насанд хүрэгчдийн хувийн жин, хамтран ажилладаг хүний тоо, ашигт малтмалын төрлөөр	102
<b>Зураг 7.6</b>	Насанд хүрэгчдийн хувийн жин, эрүүл мэндийн даатгалтай эсэхээр	106
<b>Зураг 7.7</b>	Насанд хүрэгчдийн хувийн жин, согтууруулах ундаа хэрэглэдэг эсэх, насны бүлгээр	107

<b>Зураг 7.8</b>	Насанд хүрэгчдийн хувийн жин, амьжиргаанд гарсан өөрчлөлт, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр	109
<b>Зураг 7.9</b>	Насанд хүрэгчдийн хувийн жин, хамт амьдардаг хүүхдийн тоо, ашигт малтмалын төрөл, хүйсээр	110
<b>Зураг 7.10</b>	Алт, жонш олборлох ажлаа үргэлжлүүлэн хийх хүсэлтэй байгаа насанд хүрэгчдийн хувийн жин, цаашид ажиллах хугацаагаар	111



## ХУРААНГУЙ

“Албан бусаар алт/жонш олборлож буй ажиллах хүчний суурь судалгаа”-г Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (АЙПЕК)-ийн санхүүгийн дэмжлэг, тус хөтөлбөрийн Энэтхэг улсын Шинэ-Дели хот дахь бүсийн судалгааны мэргэжилтний техникийн туслалцаатайгаар явуулав.

Судалгааны гол зорилго нь албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн ажлын нөхцөл байдал, орлого, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудлаар холбогдох мэдээлэл цуглуулж, улсын хэмжээнд хичнээн хүн албан бусаар алт, жонш олборлож байгааг тодорхойлох явдал байлаа.

Энэхүү судалгаанд албан бусаар алт/жонш олборлож байгаа нийт 21 сум, эдгээр сумдаас 5-17 насны 348 хүүхэд, 18 ба түүнээс дээш насны 232 насанд хүрэгч хамрагдсан бөгөөд улсын хэмжээнд албан бусаар алт, жонш олборлож байгаа 5 ба түүнээс дээш насны нийт 45902 хүн байна гэсэн үр дүн гарчээ. Эдгээр ажиллах хүчний 90 гаруй хувь нь албан бусаар алт олборлож байна. Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүмүүсийг насны бүтцээр нь авч үзвэл, 17.4 хувь нь 5-17 насны хүүхдүүд байлаа.

Судалгааны бүлэг бүрийн товч үр дүнг дараахь байдлаар тодорхойлж байна.

### АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БАЙГАА ХҮҮХДҮҮДИЙН БАЙДАЛ

*Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн дунд шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүд тодорхой хувийг эзэлж байна.* Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 27.8 хувь, жонш олборлож буй таван хүүхэд тутмын нэг нь сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцсон эдгээр хүүхдүүдийн дунд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь өндөр байсны зэрэгцээ асран хамгаалагчийн хараа хяналтгүйгээр ганцаараа шилжин ирж, ажиллаж байгаа хүүхдүүд ч цөөнгүй байсан. Мөн шилжих хөдөлгөөнд оролцсон алт олборлож буй хүүхдүүдийн бараг тал хувь нь, жонш олборлож буй хүүхдүүдийн 20 хувь нь тухайн сумандаа бүртгүүлээгүй байв.

*Алт/жоншины албан бус уурхайн орчимд амьдарч байгаа хүүхдүүдийн ахуйн нөхцөл маш муу байна.* Алт олборлогч гурван хүүхэд тутмын нэг, жонш олборлогч бараг хоёр хүүхэд тутмын нэг нь жилийн ихэнх хугацаанд уурхайн орчимд амьдардаг бөгөөд эдгээр хүүхдүүдийн багагүй хувь (алт олборлогч хүүхдүүдийн 19 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 16.6 хувь) нь зориулалтын бус сууцанд аж төрж байна. Уурхайн орчимд амьдарч байгаа алт олборлож буй хүүхдүүдийн дөнгөж 7.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 28.8 хувь нь л хамгаалалттай худгийн усыг ундандаа хэрэглэдэг гэжээ. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд эрүүл ахуйн хангалтгүй орчин, нөхцөлд амьдарч байгаа нь эдгээр хүүхдүүдийн ихэнх хувь нь сууцны ойролцоо зориулалтын бие засах газаргүй, зориулалтын хог, хаягдал хаях газаргүй өрхөд амьдарч байгаагаас харагдаж байна.

*7-15 насны албан бусаар алт олборлогч хүүхдүүдийн дөрөвний нэг нь, жонш олборлогч хүүхдүүдийн есний нэг нь сургууль завсарджээ.* Уурхайд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн дунд бичиг үсэг тайлагдаагүй тохиолдол цөөнгүй

байсны зэрэгцээ 7-15 насны алт олборлогч дөрвөн хүүхэд тутмын нэг нь, жонш олборлогч есөн хүүхэд тутмын нэг нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Алт олборлож буй шилжигч хүүхдүүдийн сургуульд сурахгүй байгаа хувь шилжигч бус хүүхдүүдийнхтэй харьцуулахад 3 дахин их, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 5 дахин их байлаа. Алт/жонш олборлогч хүүхдүүдийн ар гэрийн гачигдалтай байдал нь сургууль завсардалтын гол шалтгаан болж байна.

**Албан бусаар жонш олборлож байгаа хүүхдүүдтэй харьцуулахад алт олборлогч хүүхдүүдийн эрүүл мэндийн даатгалд харагдалтын хувь хангалтгүй байна.** Алт олборлож буй хүүхдүүдийн 9.5 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхгүй, 16.5 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй байлаа. Шилжигч бус алт олборлож байгаа хүүхдүүдийн бичиг баримтын бүрдлийн хувь шилжигч хүүхдүүдтэй харьцуулахад өндөр, ялангуяа эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байна.

**Амьжиргааны доогуур түвшин, ар гэрийн гачигдалтай байдал нь хүүхдийн хөдөлмөр эрхлэх гол шалтгаан болж байна.** Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон гол гурван шалтгааныг ач холбогдлоор эрэмблэхэд нэгдүгээрт: өрхийн орлогоо нэмэгдүүлэх, хоёрдугаарт: өөрийн гэсэн мөнгөтэй болох, гуравдугаарт: эцэг, эх ажилгүй учраас гэсэн шалтгаанууд орж байна.

**Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй нөхцөл байдалд ажиллаж байгаа эдгээр хүүхдүүдийн дунд мөнгөн ус болон тэсэрч дэлбэрэх бодистой ажилладаг хүүхдүүд цөөнгүй байна.** Алт олборлож буй хүүхдүүдийн хамгийн их хийдэг ажлуудад ус, шороо зөөх, алт угаах, алт ухах, нүх малтах, шороо зөөх, шороо шигших ажлууд ордог байна. Үүний зэрэгцээгээр эдгээр хүүхдүүд мөнгөн ус олборлох (7 хувь), мөнгөн усаар алт бариулах (14.2 хувь), тэсэлгээ хийх зэрэг аюултай бодис, химийн урвалтай харьцдаг ажлуудыг тодорхой хэмжээгээр хийдэг болох нь харагдлаа. Жонш олборлож буй хүүхдүүдийн хамгийн их хийдэг ажлуудад шороо зөөх, нүх малтах, жонш зөөх, хүдэр чулуу зөөх, хүдэр/чулуу/жонш бутлах, жонш ухах, жонш зөөх зэрэг жонш олборлох үйл ажиллагаатай холбоотой бүхий л ажлуудыг хийж байна. Жонш олборлож буй хүүхдүүдийн 8.1 хувь нь тэсэрч дэлбэрэх аюултай бодистой харьцдаг ажлыг хийдэг гэжээ.

**Албан бусаар алт олборлогч хүүхдүүдийн тал хувь нь шөнийн цагаар байнга болон хааяа ажилладаг байна.** Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 33.5 хувь нь хааяа, 15.5 хувь нь байнга шөнийн цагаар ажилладаг байна. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн 22.1 хувь нь шөнийн цагаар ажилладаг гэжээ.

**Эрэгтэй хүүхдүүдэд 21 цагаас хойш ажиллах тохиолдол эмэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байна.** Алт олборлож буй хүүхдүүдийн ажил өглөө дунджаар 9 цагаас хойш эхэлж, орой дунджаар 19 цаг өнгөрөөд дуусдаг бол жоншны уурхайд ажилладаг хүүхдүүдийн ажил өглөө дунджаар 8-9 цагийн хооронд эхэлж, орой дунджаар 19 цаг өнгөрөөд дуусдаг байна. Эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдийн бодвол 21 цагаас хойш буюу оройн цагаар ажиллах нь түгээмэл байна. Тухайлбал, алт олборлодог эрэгтэй хүүхдүүдийн 26.2 хувь нь, жонш олборлодог эрэгтэй хүүхдүүдийн 18.5 хувь нь 21 цагаас хойш ажлын цаг дуусдаг гэсэн хариултыг өгчээ. Өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа нь 8-9 цаг буюу хуулинд заасан хугацаанаас илүү байна.

Эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдийг бодвол илүү цагаар ажиллаж байгаа бөгөөд алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 12.2 хувь, жонш олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 8.8 хувьд нь ажлын дундуур амрах боломж гардаггүй гэжээ. Эрэгтэй хүүхдүүд уурхайд дунджаар жилийн 4-5 сард нь, харин эмэгтэй хүүхдүүд 3-4 сард нь ажилладаг байна.

**Эрэгтэй хүүхдүүд олборлож буй алт/жоншны хэмжээгээрээ, олж буй орлогоороо ч эмэгтэй хүүхдүүдээс илүү байна.** Алт олборлож байгаа эрэгтэй хүүхэд сард дунджаар 6.1 грамм, эмэгтэй хүүхэд 5.7 грамм алт олборлодог бөгөөд эрэгтэй хүүхдүүд сард дунджаар 69.4 мянган төгрөг, эмэгтэй хүүхдүүд 64.6 мянган төгрөгний орлого олдог ажээ. Харин жонш олборлож байгаа эрэгтэй хүүхэд сард дунджаар 14.3 тонн эмэгтэй хүүхдүүд 5.1 тонн жонш олборлодог бөгөөд эрэгтэй хүүхдүүд сард дунджаар 123.7 мянган төгрөг, эмэгтэй хүүхдүүд 43.5 мянган төгрөгний орлого олдог байна.

**Алт/жонш олборлогч хүүхдүүд олсон орлогоо ихэвчлэн өрхийн хэрэглээнд зарцуулдаг байна.** Алт олборлож буй хүүхдүүдийн 55.9 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 56.2 хувь нь орлогоо өрхийн хэрэглээнд зарцуулдаг байна. Үүний зэрэгцээгээр алт/жонш олборлож олсон орлогоо алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 25.1 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 30 хувь, жонш олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 28.3 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 49.6 хувь нь 100 хувь гэрийнхэндээ өгдөг байна.

#### **Алт/жонш олборлогч хүүхдүүдийн эрүүл мэндийн байдал**

Албан бусаар алт/жонш олборлогч хүүхдүүдийн 29.7 хувь нь ажиллаж байхдаа өвдөж байсан бөгөөд эдгээр хүүхдүүдийн 24 хувь нь судалгаа авах үед өөрсдийгөө өвчтэй байгаа гэсэн ба үе мөчний болон амьсгалын замын өвчнөөр голдуу өвдсөн байв.

Алтны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 20.5 хувь нь ажлын байран дээрээ осол, гэмтэл авч байсан бол жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 21.8 хувь нь осолдож байжээ. Өвчтэй эсвэл осол, гэмтэл авсан хүүхдүүдийн 43.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй бөгөөд тэдний 21.4 хувь нь эмнэлгээс хэт алслагдсан учраас эмнэлэгт хандаж чадаагүй гэсэн байна.

Хүүхдүүдийн алт, жонш олборлоогүй үеийн эрүүл мэндийн байдлыг ажиллаж эхэлснээс хойшхи үетэй харьцуулбал, алт олборлож буй хүүхдүүдийн 21.3 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 21 хувь нь эрүүл мэндийн байдлаа муудсан гэж үзжээ.

**Хөдөлмөр хамгааллын наад захын шаардлагыг мэддэг гэсэн гурван хүүхэд тутмын нэг нь л түүнийг дагаж мөрддөг байна.** Алтны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн ердөө 15.8 хувь, жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 34.1 хувь нь хөдөлмөр хамгааллын наад захын шаардлагыг мэддэг гэсэн ба энэ талын мэдлэгтэй хүүхдийн 34 орчим хувь л хөдөлмөр хамгааллын наад захын шаардлагыг дагаж мөрддөг байна.

#### **Хүүхдийн цаашидын хүсэл эрмэлзэл**

Цаашид сурах болон ажил эрхлэх боломжоос албан бусаар алт олборлогч хүүхдүүдийн 78.7 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 83.1 хувь нь сурах боломжийг нь сонгоно гэсэн байна. Түүнчлэн охидууд хөвгүүдийг бодвол цаашид суурь боловсрол эзэмших, сургуульд суралцах илүү сонирхолтой

бөгөөд үүнд шаардлагатай мөнгөө олж авахын тулд ажиллаж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүд цаашид хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийх сонирхол харьцангуй бага байгаа (алт олборлогч хүүхдүүдийн 53.7, жонш олборлогч хүүхдүүдийн 56.8 хувь) бөгөөд эдгээр хүүхдүүд цаашид суурь боловсрол эзэмших, ямар нэг мэргэжил эзэмших, цалинтай ажил эрхлэх төлөвлөгөөтэй байв. Харин албан бусаар алт/жонш олборлодог хүүхдүүдийн хувьд, ажилдаа дуртай байдаг хамгийн гол шалтгаан нь гэрийнхэндээ тус дэм болдог явдал байв.

## **АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ/ЭХИЙН БАЙДАЛ**

*Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийн дийлэнх нь хувьдаа малгүй байна.* Алт олборлож байгаа хүүхэдтэй өрхийн 29.5 хувь, жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхийн дөнгөж 15.6 хувь нь л хувьдаа малтай юм байна. Өрхөд байгаа малын төрлөөр авч үзэхэд голчлон хонь, ямаатай, харин адуу, үхэр дунджаар нэг өрхөд цөөн тоотой байна.

*Албан бусаар алт олборлож байгаа дөрвөн өрх тутмын нэг нь шилжигч өрх байна.* Алт олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдийн хариултаас харахад эдгээр өрхүүдийн 27.9 хувийг шилжигч өрх эзэлж байна. Шилжигч өрхүүдийн 41.2 хувь нь түр оршин суугаа, үлдсэн 58.8 хувь нь тухайн орон нутагт 5 хүрэхгүй жил амьдарч байгаа өрхүүд байлаа. Харин жонш олборлож буй хүүхэдтэй, судалгаанд хамрагдсан нийт 35 өрхийн гурав нь түр оршин суугаа, хоёр нь 5 хүрэхгүй жил тухайн газраа оршин суугаа шилжигчид байв.

*Шилжин ирсэн өрхүүдийн дийлэнх нь алт, жонш олборлох зорилгоор ирж байна.* Алт олборлож буй өрхүүдийн шилжин ирсэн гол шалтгаан нь давхардсан тоогоор алтны уурхайд ажиллах (41.2 хувь), ашиг орлогоо нэмэгдүүлэх (27.9 хувь) гэсэн шалтгаан байгаа бол жонш олборлодог өрхийн хувьд амьжиргаагаа сайжруулах, жоншны уурхайд ажиллах (тус бүр 33.3 хувь) гэсэн хариултууд зонхилж байна

*Алт/жонш олборлож буй хүүхэдтэй өрхүүдийн сарын дундаж орлогын дийлэнхийг алт/жонш олборлолтоос орсон орлого эзэлж байна.* Алт/жонш олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдээс тухайн өрхийн сарын дундаж орлогын хэмжээг асуухад алт олборлож байгаа өрхийн хувьд сарын дундаж орлого дунджаар 114906 төгрөг байхад жонш олборлож байгаа өрхийн хувьд 126500 төгрөг байлаа. Өрхийн сарын дундаж орлогын 70 орчим хувийг алт/жонш олборлолтоос олсон орлого бүрдүүлдэг юм байна. Харин эцэг/эхчүүдийн талаас илүү хувь нь хүүхдүүдийнхээ алт/жонш олборлолтоос олсон ажлын хөлсийг өрхийн амьдралд дунд зэрэг хувь нэмэр болдог гэж үзэж байна.

*Алт, жонш олборлодог хүүхэдтэй өрхүүдийн дийлэнхийнх нь сарын дундаж орлого амьдралд нь хүрэлцдэггүй байна.* Алт олборлодог эцэг/эхчүүдийн талаас илүү хувь нь өрхийн сарын дундаж орлого амьжиргаанд нь хүрэлцдэггүй, 7.4 хувь нь хангалттай хүрэлцдэг гэж хариулжээ. Харин жонш олборлодог эцэг/эхчүүдийн хувьд өрхийн сарын дундаж орлого хангалттай хүрэлцдэг гэсэн хариулт байгаагүй ба дөрвөн хүн тутмын гурав нь амьжиргаанд хүрэлцдэггүй, нэг нь дунд зэрэг хүрэлцдэг гэсэн хариултыг өгчээ.

*Албан бусаар алт/жонш олборлож буй эцэг/эхчүүдийн ихэнх нь эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж байна.* Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжгүй гэж алт олборлогч эцэг/эхчүүдийн 4.9 хувь, жонш олборлогч эцэг эхчүүдийн 3.1 хувь нь хариулжээ.

*Эцэг/эхчүүдийн талаас илүү хувь нь хүүхдүүдийнхээ алт/жонш олборлохыг хүлээн зөвшөөрч байна.* Эцэг, эхчүүдийн 66.2 хувь нь хүүхдүүдийнхээ алт/жонш олборлож байгааг хүлээн зөвшөөрдөг гэж хариулсан байна.

*Ерөнхийдөө, алт/жонш олборлох ажлын нөхцлийг таван эцэг/эх тутмын дөрөв нь хүнд, хортой гэж үздэг байна.* Эцэг/эхчүүдийн үзэж байгаагаар алт олборлох ажлыг хүүхэд эрхлэхэд хүнд гэж үзэж байгаа хамгийн гол гурван шалтгаанд давхардсан тоогоор *íúääçäýúðò*, тоосжилт ихтэй (78.2 хувь), *õî, ðäöääàðò*, аюултай эрсдэлтэй (68.1 хувь), *ãòðääãòääàðò*, хүнд ачаа үүрдэг (64.7 хувь) гэсэн шалтгаанууд орж байхад харин жонш олборлодог хүүхдүүдийн хувьд *íúääçäýúðò*, тоосжилт ихтэй, хүнд ачаа үүрдэг (тус бүр 63.3 хувь), *õî, ðäöääàðò*, хортой нөхцөлд ажилладаг (50.0 хувь), *ãòðääãòääàðò*, аюултай эрсдэлтэй (43.3 хувь) гэсэн шалтгаанууд орж байна.

*Эцэг/эхчүүд хүүхдүүдээ сургуульд суралцуулахыг хүсч байна.* Эцэг/эхийн хариулснаар алт олборлож байгаа хүүхдүүдийн 59.0 хувь нь албан сургалтанд, 2.5 хувь нь албан бус сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд үлдсэн 38.5 хувь нь сургуульд суралцдаггүй юм байна. Эцэг/эхчүүдийн 92.9 хувь нь хэрвээ хүүхдүүд ажил хийхээ болиод сургуульдаа үргэлжлэн суралцана эсвэл сургуульд орно гэвэл ажил хийхийг нь зогсооно гэж хариулжээ.

## **АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖИЛ ОЛГОГЧИЙН БАЙДАЛ**

*Ажил олгогчид харьцангуй залуу насны, эрэгтэй хүмүүс байна.* Ажил олгогчдын дундаж нас алт олборлогчдын хувьд 34.9, жонш олборлогчдын хувьд 35.3 байгаа ба эрэгтэйчүүд (алт олборлогчдын 76.5 хувь, жонш олборлогчдын 80 хувь) зонхилон энэ ажлыг хийж байна

*Жонш олборлож буй ажил олгогчид алт олборлогчдоос олон тооны хүмүүсийг ажиллуулж байна.* Алт олборлож буй нэг ажил олгогч дунджаар 4.8 хүнтэй хамтран ажиллаж байхад жонш олборлож буй нэг ажил олгогч 11.1 хүнтэй ажиллаж байна.

*Ажил олгогчдын дунд гэр бүлийн гишүүдээ ажиллуулах явдал байна.* Алт олборлогч 1 ажил олгогч дунджаар 2.3, харин жонш олборлож буй ажил олгогч дунджаар 1.6 хүнийг гэр бүлээсээ хөлсгүйгээр ажиллуулж байна. Эдгээр гэр бүлийн гишүүдээс 0.7 (алт олборлогч) ба 0.3 (жонш олборлогч) нь тус тус 5-17 насны хүүхдүүд байна.

*Алт, жонш олборлож буй ажил олгогчдын хүүхэд ажиллуулах хандлага ялгаатай байна.* Алт олборлож буй ажил олгогчдын 70.6 хувь нь зөвхөн 15-17 насны хүүхдүүдийг ажиллуулдаг бол жонш олборлогчдын 60 хувь нь 5-14 ба 15-17 насны хүүхдүүдийн аль алиныг зэрэг ажиллуулж байна. Мөн алт олборлож буй нэг ажил олгогч дунджаар 5-14 насны 0.4 хүүхэд, 15-17 насны 1

хүүхэд ажиллуулж байхад жонш олборлож буй нэг ажил олгогч дунджаар 5-14 насны 1.6 хүүхэд, 15-17 насны 2 хүүхэд ажиллуулж байна.

***Хүүхэд алт/жонш олборлох ажилд татагдан орж байгаад томчууд, эцэг/эх, ойр дотны хүмүүсийн оролцоо нөлөөлж байна.*** Давхардсан тоогоор, алт олборлож буй ажил олгогчдын 53 хувь, жонш олборлогчдын 80 нь хүүхдийг ажилд авахдаа хүүхдийн эцэг/эх, өөрийн хамаатан саднаараа дамжуулан авсан байна.

***Ажил олгогчид хүүхдүүдээр давхар ажил хийлгэж байна.*** Ажил олгогчид хүүхдүүдээр нүх малгах/шороо ухах, ус/шороо зөөх, алт угаах, шороо шигших зэрэг үндсэн ажлуудыг хийлгэхийн зэрэгцээ хоол хийх/бэлтгэх, хувцас угаах, гэр цэвэрлэх, ус/түлээнд явуулах, зараалд гүйлгэх зэрэг үнэлгээгүй, давхар ажлыг хийлгэж байна. Дээрх үндсэн ажлуудад эрэгтэй хүүхдүүд илүү оролцож байгаа бол үнэлгээгүй ажлыг 15-17 насны, эмэгтэй хүүхдүүд илүүтэй гүйцэтгэж байна.

***Ажил олгогчид хүүхдүүдийг хөдөлмөрийн хуулинд зааснаас илүү цагаар ажиллуулж байна.*** Алт олборлож буй ажил олгогчид хүүхдүүдийг дунджаар 7 хоногийн бүх өдөр, жонш олборлогчид 6.4 өдөр нь ажиллуулж байна. Мөн хүүхдүүдийг өдөрт ажиллуулдаг дундаж цаг нь алт олборлогчдын хувьд 9 цаг, жонш олборлогчдын хувьд 7.2 цаг байна.

***Ажил олгогчдын дунд хүүхдийг хөлсгүй ажиллуулах явдал байна.*** Нийт ажил олгогчдын 27.3 хувь нь хүүхэд ажиллуулсныхаа төлөө огт төлбөр төлдөггүй ба 15-17 насны хүүхдэд мөнгөн хэлбэрээр, 5-14 насны хүүхдэд мөнгөн бусаар (хоол, хүнс, хувцас, хичээлийн хэрэгсэл) хөлс төлдөг хандлага түгээмэл байна. Хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлсийг ажил олгогчид ялгаатайгаар, тухайлбал ямар ч насны эрэгтэй хүүхдийн хөдөлмөрийг эмэгтэй хүүхдийнхээс өндрөөр үнэлж байна.

***Ажил олгогч ба хүүхдүүдийн хооронд хөдөлмөрийн гэрээ, хэлцэл хийгдсэн байдал хангалтгүй байна.*** Алт олборлож буй ажил олгогчдын 85.3 хувь, жонш олборлогчдын 40 хувь нь хүүхэд ажиллуулахдаа хөдөлмөрийн ямар нэг гэрээ/хэлцэл хийгээгүй ба ганцхан жонш олборлогч бичгээр, бусад нь амаар хэлцэл хийжээ.

***Ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл ба нийгмийн хамгаалалд тавих анхаарал хангалттай биш байна.*** Алт олборлогчдын 52.9 хувь, жонш олборлогчдын 40 хувь нь тус тус ажиллуулж байгаа хүүхдүүдээ ажлын хувцас, хэрэгслээр хангадаггүй байна. Мөн алт олборлож буй ажил олгогчдын 47.1 хувь, жонш олборлогчдын 10 хувь нь хүүхдүүдэд сургуульдаа явах боломж гаргаж өгдөггүй/хүүхэд сургуульд сурдаггүй тул ийм боломж гаргаж өгөх шаардлагагүй гэжээ. Ажиллуулж буй хүүхэд өвдөх/бэртэхэд 8.8-20 хувь нь ямар ч тусламж үзүүлдэггүй байна.

***Хүүхдийн хөдөлмөрийн талаарх ажил олгогчийн мэдлэг хангалтгүй байна.*** Нийт ажил олгогчдын 1/3 нь л хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулиар зөвшөөрөгдсөн доод насыг мэдэж байна. Энэ мэдлэг алт олборлогч, 35-аас доош насны, эмэгтэй, 2-оос цөөн жил ажиллаж буй ажил олгогчдын дунд бусдаас бага байна.

## **АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ НАСАНД ХҮРЭГЧДИЙН БАЙДАЛ**

*Албан бусаар ашигт малтмал олборлогчдын дийлэнх нь алтны уурхайд ажиллаж байна.* Албан бусаар алт/жонш олборлож буй нийт 37906 насанд хүрсэн хүн ам байгаагийн 89.6 хувь нь алтны уурхайд, үлдсэн 10.4 хувь нь жоншны уурхайд ажиллаж байна.

*Албан бусаар алт/жонш олборлогчдын нас харьцангуй залуу байна.* Албан бусаар алт олборлогчдын дундаж нас 31.3, жонш олборлогчдынх 35.0 байна. Хүйсийн хувьд, алт/жонш албан бусаар олборлож буй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байна.

*Албан бусаар алт/жонш олборлогчдын талаас илүү хувь нь ашигт малтмал олборлож буй сумандаа 5 ба түүнээс жил амьдарч байна.* Насанд хүрэгчдийн 18.2 хувь нь ашигт малтмал олборлож буй сумандаа 5 жилээс доош хугацаанд, 56.9 хувь нь 5 ба түүнээс дээш жил ажиллаж, амьдарч байна. Харин үлдсэн 24.9 хувь нь түр оршин сууж байгаа ажээ.

*Шилжин ирэгчдэд гэр бүлийн шилжилт зонхилж байна.* Албан бусаар алт олборлохоор шилжин ирэгчид голдуу өөрсдийн гэр бүлээрээ тодруулбал, эхнэр/нөхөр, хүүхдүүдтэйгээ хамт шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Харин жонш олборлогчдын хувьд хосууд хамтдаа шилжих хөдөлгөөнд илүүтэй оролцсон байна. Харамсалтай нь шилжин ирэгчдийн тэдний ердөө тал хувь нь л ажиллаж, амьдарч буй сумандаа бүртгүүлжээ.

*Шилжигчид ажил хийх, алт жонш олборлох шалтгаанаар шилжих хөдөлгөөнд илүүтэй оролцсон байна.* Ажлын байрны хомсдолын улмаас алт, жонш олборлож амьжиргаагаа залгуулах нь шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаан болж байна. Албан бусаар алт олборлогчдын 29.7 хувь, жонш олборлогчдын 23.4 хувь нь өмнө нь алт/жонш олборлох ажил хийж байжээ.

*Алт/жонш олборлогчдын дунд ирээдүйн шилжилт хийх сонирхолтой хүмүүс цөөнгүй байна.* Албан бусаар алт олборлогчдын 30.5 хувь, жонш олборлогчдын 43.8 хувь нь одоогийн алт олборлож буй газраасаа өөр газар уруу шилжихийг хүсч байгаа ажээ. Шилжихийг хүсч буй жонш олборлож буй эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

*Жонш олборлогчдын талаас илүү хувь нь уурхайн орчимд амьдарч байна.* Албан бусаар алт олборлогчдын 49.0 хувь, жонш олборлогчдын 75.8 хувь нь уурхайн орчимд буюу алт/жонш олборлож буй газартаа амьдарч байна.

*Ундны цэвэр усны хангамж албан бусаар алт олборлогчдын дунд илүү хүндрэлтэй байна.* Албан бусаар алт олборлогчдын ердөө 12.3 хувь, жонш олборлогчдын 10.8 хувь нь хамгаалалттай ундны усыг ажлын байран дээрээ хэрэглэж байна.

*Албан бусаар алт олборлогчид жижиг суурингийн хэлбэр лүү шилжих хандлагатай болж байна.* Албан бусаар алт олборлож буй уурхайн орчимд ямар нэгэн үйлчилгээнүүд байдаг гэж алт олборлогчдын 85 хувь нь хариулсан байхад жонш албан бусаар олборлогчдын 36.2 хувь нь ийм хариултыг өгчээ. Алт олборлогчид гэр дэлгүүр (78.5 хувь), тээврийн үйлчилгээ (62.4 хувь), үсчин,

хоолны газар гэх мэт хувийн жижиг үйлчилгээ (39.6 хувь)-г хүртэх боломж өндөр байна. Тэр ч байтугай зарим газар эмнэлгийн үйлчилгээг авч байна.

**Албан бусаар алт/жонш олборлохын хажуугаар өөр ажил эрхэлдэг хүмүүс цөөнгүй байна.** Албан бусаар алт олборлож буй газарт насанд хүрсэн бараг 10 хүн тутмын нэгийнх нь өрх гэр дэлгүүр (26.1 хувь) ажиллуулах, үсчин, хоолны газар (68.2 хувь) гэх мэт хувийн жижиг үйлчилгээ үзүүлэх бизнес эрхэлж байгаа ажээ. Жоншны уурхай дээр албан бусаар ажиллаж буй 50 хүн буюу 1.3 хувь (хувийн жижиг бизнес эрхэлж байгаа) нь ийм хариултыг өгсөн байна.

**Албан бусаар алт/жонш олборлогчдын тавны хоёр нь бүтэн жилийн туршид ажиллаж байна.** Амралттай болон их хэмжээний мөнгөний хэрэгцээ гарсан үедээ ажилладаг алт олборлогчдын хувийн жин жонш олборлогчдынхоос өндөр байна.

**Алтны уурхайд ажиллагсад илүү урт цагаар ажиллаж байна.** Судалгаанаас өмнөх долоо хоногт ажилласан ажлын өдрийн дундаж хугацаа алт болон жонш олборлогчдын хувьд нэлээд ойролцоо буюу 5.5 өдөр байна. Сүүлийн долоо хоногт өдөрт алтны уурхайд ажиллагчид 9.9 цаг ажилласан байхад жоншны уурхайд ажиллагчдын хувьд өдрийн ажлын дундаж хугацаа 1.4 цагаар доогуур буюу 8.5 цаг байв.

**30 хүртэл насны залуучуудын дунд уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт шаардлагын талаархи мэдлэгийн түвшин нэлээд доогуур байна.** Албан бусаар алт олборлогчдын 65.9 хувь, жонш олборлогчдын 41.3 хувь нь огт мэдэхгүй гэжээ. Насанд хүрэгчдийн ердөө 21.4 хувь л аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдээлэл авч байжээ.

**Алтны уурхайд эрэгтэйчүүд, харин жоншны уурхайд эмэгтэйчүүд илүүтэй осолд өртсөн байна.** Албан бусаар алт олборлож буй насанд хүрэгчдийн 13.8 хувь, жонш олборлож буй насанд хүрэгчдийн 12.1 хувь нь ажлаа хийж байхдаа осолд орж байжээ. Осолд өртөгсөд голдуу нүх, хонгил руу унасан хүмүүс байгаа бөгөөд сумын эмнэлгээс тусламжийг түлхүү авчээ.

**Уурхайд ажиллаж эхэлснээс хойш эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт гарсан гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байна.** Алт олборлогчдын 41.3 хувь (эмэгтэйчүүдийн 43.9 хувь, эрэгтэйчүүдийн 40.1 хувь), жонш олборлогчдын 17.3 хувь (эмэгтэйчүүдийн 26.9 хувь, эрэгтэйчүүдийн 9.4 хувь) нь уурхайд ажиллаж эхэлснээс хойш эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт гарсан гэжээ. Алт/жонш албан бусаар олборлож буй насанд хүрэгчдийн 80 гаруй хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдан, эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээлгэсэн ч тэдгээрийн дөрөвний нэг гаруй хувь нь даатгалын хураамжаа төлөөгүй байгаа ажээ.

**Согтууруулах ундааны зүйлсийн хэрэглээ албан бусаар алт/жонш олборлогчдын дунд түгээмэл байна.** 25-34 насны залуучуудын согтууруулах ундааны зүйлс хэрэглэдэг гэсэн нь бусад насны бүлгийнхнээс хамгийн өндөр байна.

**Жоншны уурхайд албан бусаар ажиллагчдын сарын дундаж орлого нь алтны уурхайд ажиллагчдаас их байна.** Албан бусаар алт олборлогчид долоо хоногт дунджаар 4.758 грамм алт олборлож, сардаа 119026 төгрөгийн орлого олж



байхад жонш олборлогчид долоо хоногт 5287.5 килограмм жонш олборлож, сардаа 122214 төгрөгийн орлоготой ажилладаг байна.

***Албан бусаар алт, жонш олборлогчдын 40 гаруй хувь нь 18 хүртэлх насны хүүхэдтэй хамт амьдарч байна.*** Уурхайд албан бусаар ажиллаж буй хүмүүстэй хамт амьдардаг хүүхдүүдээс алт/жонш олборлох ажиллагаанд оролцдог гэж насанд хүрэгчдийн 28.1 хувь хариулжээ. Алт/жоншны уурхай дээр ажиллаж байгаа хүүхдүүдээ алт/жонш олборлох ажил хийлгэхгүй хөндийрүүлэх хэрэгтэй гэж насанд хүрэгчдийн 76.2 хувь нь үзжээ.

***Насанд хүрэгчдийн талаас илүү хувь нь энэ салбарт үргэлжлүүлэн ажиллах хандлагатай байна.*** Насанд хүрэгчдийн 52.9 хувь нь алт/жонш олборлох ажлаа үргэлжүүлэн хийх хандлагатай байна. Тэдний талаас илүү нь хэр удаан ажиллах талаар тодорхой хугацаа төлөвлөгөөгүй байна.

***Насанд хүрэгчдийн 40 гаруй хувь нь албан бусаар алт/жонш олборлолтыг тусгай хууль гаргах нь зүйтэй гэж үзэж байна.*** Албан бусаар алт/жонш олборлогчдын өнөөгийн байдлыг сайжруулахын тулд төр засгаас юуны өмнө энэ салбарт ажиллах зөвшөөрөл өгөх, эрүүл мэнд, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, хяналт, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна гэжээ.

## БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

### 1.1 Үндэслэл

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцтай холбогдон ажил эрхлэлтийн салбарт гарсан нэг өөрчлөлт бол албан бус сектор<sup>1</sup> үүсэн, хурдацтай газар авч, улмаар хүн амын амьжиргаагаа залгуулах хөдөлмөрийн талбарын нэг болон өргөжсөн явдал юм.<sup>2</sup> 2003 онд Үндэсний Статистикийн Газраас явуулсан “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс харахад, улсын хэмжээнд хөдөө аж ахуйн бус *ᠠᠵᠢᠯᠢᠬᠤ ᠬᠦᠴᠢᠨ ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ᠎ᠠ* нийт 460300 хүн ажиллаж байна гэсэн тооцоо гарчээ. Хэдийгээр албан бусаар алт болон жонш олборлож байгаа хүн амын тоог тус тусад нь нарийн тодорхойлсон судалгааны ажил байхгүй байгаа боловч энэ секторт насанд хүрэгчид төдийгүй, хүүхдүүд олноор татагдан орж, хүн амын багагүй хэсгийн амьжиргааны гол эх үүсвэр болж байгаа билээ.

Албан бус сектор нь хүн амын ажил эрхлэлтийг дэмжих, тэдний орлогыг нэмэгдүүлж, улмаар ядуурлыг бууруулахад зохих хувь нэмэр оруулж байгаа мэт боловч тэр хэмжээгээрээ эдийн засгийн далд буюу нуугдмал үйл ажиллагааг бий болгодог байна. Иймээс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас албан бус секторын талаарх тоон мэдээллийг статистикийн мэдээллийн нэг хэсэг болгож тогтмол цуглуулах шаардлагатайг зөвлөмж болгосон байдаг. Албан бус секторын талаарх тоон мэдээллийг тогтмол цуглуулсанаар албан бус секторын цар хүрээ, хэмжээ, төлөв байдлыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох бодлого, үйл ажиллагаа явуулах боломж бүрддэг байна.

Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүмүүс эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын наад захын шаардлага хангахгүй орчинд ажиллаж, улмаар эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээ хүртэх боломжоор хязгаарлагдаж байгаа нь энэ талаар холбогдох бодлого, шаардлагатай үйл ажиллагаа явуулах хэрэгцээ байсаар байгааг харуулж байна.

### 1.2 Судалгааны зорилго, судалсан асуудлууд

Судалгааны үндсэн зорилго нь албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн тоог тодорхойлох, алт болон жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн ажил эрхлэлтийн бодит дүр төрхийг харуулах анхдагч мэдээлэл цуглуулахад оршиж байлаа. Түүнчлэн албан бусаар алт, жонш олборлож буй хүүхдүүдийн эцэг, эх, ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх үзэл бодол, хандлагыг тодорхойлоод зогсохгүй, энэ хэлбэрийн хөдөлмөрийг зохицуулах талаарх олон нийтийн үзэл бодлыг тусгахыг зорилоо.

Судалгааг дараахь үндсэн асуудлуудын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Албан бусаар алт болон жонш олборлолт явагдаж буй багийн нутаг дэвсгэрт болон уурхайн орчимд амьдарч байгаа өрхийн бүтэц, шинж байдал, хүн амын шилжих хөдөлгөөн, ажил эрхлэлт, сургуульд хамрагдалт;

<sup>1</sup> Тодорхойлолтыг арга зүй, аргачлалын хэсгээс харна уу.

<sup>2</sup> СЭЗЯ, НҮБХХ, 2004 он

- Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн шинж байдал, шилжих хөдөлгөөн, ажлын нөхцөл, орлого, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудлууд;
- Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн өрхийн шинж байдал, уурхайд хүүхдээ ажиллуулж буй эцэг, эхчүүдийн хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, боловсролын талаарх хандлага, үзэл бодол;
- Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдэд ажил олгогчдын шинж байдал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх ажил олгогчийн хандлага;
- Албан бусаар алт/жонш олборлож байгаа насанд хүрэгчид, тэдний боловсрол, эрүүл мэнд, шилжих хөдөлгөөн, ажлын нөхцөл, орлого, хөдөлмөр хамгааллын асуудлууд;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ялангуяа албан бусаар алт, жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах талаарх олон нийтийн хандлага, үзэл бодол; зэрэг болно.

### **1.3 Илтгэлийн бүтэц**

“Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-ны илтгэл нь 8 үндсэн бүлгээс бүрдэж байна. Бүлэг 1-д судалгааны үндэслэл болон зорилгыг тодорхойлж өгөв. Бүлэг 2-д судалгааны аргачлал, арга зүйг, Бүлэг 3-т албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрх, хүн амын шинж байдлыг танилцуулах болно. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн шинж байдал, өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт, ажлын нөхцөл байдал, орлого, тулгарч буй бэрхшээл зэргийн талаар Бүлэг 4-т өгүүлэх юм. Алт, жоншны уурхайд албан бусаар ажиллаж байгаа хүүхдүүдийн талаарх эцэг/эхийн хандлага, байр суурийг Бүлэг 5-д, ажил олгогчийн хандлага, үзэл бодлыг Бүлэг 6-д тус тус авч үзлээ. Бүлэг 7-д албан бусаар алт/жонш олборлож байгаа насанд хүрэгчдийн асуудлуудыг хөндөн тавьж, эцэст нь судалгаанаас гарсан гол дүгнэлт, зөвлөмжийг тодорхойлсон болно.

## БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

1993 оны 1-р сард ОУХБ-аас зохион байгуулсан Хөдөлмөрийн Статистикчдын Олон Улсын 15-р бага хурлаар батлагдсан тогтоолд *ᠠᠶᠠᠠᠢ ᠠᠪᠢ ᠨᠠᠶ᠋ᠠᠳᠤ* гэдгийг хувийн сонирхлын үүднээс ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй нэгжүүдээс бүрдэнэ гэж тодорхойлсон байдаг. Албан бус сектор дахь үйлдвэрлэл, үйлчилгээ нь хөдөлмөр болон хөрөнгийн хуваарь байхгүй, эсвэл маш бага хэмжээтэй байдаг өрхийн жижиг аж ахуйн хэлбэрээр ажилладаг.

Цөөн хүн амтай Монгол орны хувьд албан бус секторуудын дотор албан бусаар алт олборлолт нэлээн өргөн хүрээг хамарсан салбар болоод байгаа бөгөөд улам өргөжин хүрээгээ тэлсээр байна. Монголын нэлээд хэдэн аймагт хүмүүс шороон болон чулуун ордоос алт олборлох ажлыг хийж байгаа билээ. Монголын бизнес хөгжлийн агентлаг болон Eco-Minex олон улсын байгууллага Монгол улсад ойролцоогоор 100000 орчим хүн албан бусаар алт олборлох ажлыг хийж байна гэсэн тооцоо гаргасан ба энэ нь хөдөөгийн ажиллах хүчний 20 орчим хувийг бүрдүүлж байна<sup>3</sup>.

Энэхүү судалгаагаар, *ᠣᠳᠳ* гэсэн ойлголтонд судалгаа авах үед нэг сууцанд хамтран амьдарч, өдөр тутмын хүнсний хэрэгцээгээ хамтран хангаж байсан хоорондоо ураг төрлийн холбоотой болон холбоогүй хүмүүсийг хамруулсан.

Албан бусаар алт/жонш олборлож буй *ᠳᠤᠵᠢᠳᠦᠶᠠ* гэдэгт хувийн сонирхлын үүднээс орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор албан бус секторын нэг хэлбэр болох алт, жоншны ордод хувиараа ажиллаж байгаа 5-17 насны хүүхдүүдийг хамрууллаа.

Албан бусаар алт/жонш олборлож буй *ᠢᠠᠨᠠᠢᠠ ᠳᠤᠵᠢᠳᠦᠶᠠ* хувийн сонирхлын үүднээс орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор албан бус секторын нэг хэлбэр болох алт, жоншны ордод хувиараа ажиллаж байгаа 18 ба түүнээс дээш насны хүмүүсийг багтаав.

*᠋᠋᠋᠋᠋᠋* гэдэгт судалгаа явагдсан газарт 5 ба түүнээс доош жил амьдарч байгаа болон түр сууж байгаа хүмүүсийг хамруулсан. Судалгаа явагдсан газарт 5 ба түүнээс дээш жил амьдарч байгаа болон төрснөөсөө хойш амьдарч байгаа хүмүүсийг *᠋᠋᠋᠋᠋᠋ ᠠᠪᠢ* гэсэн ангилалд орууллаа.

*᠋᠋᠋᠋᠋᠋* гэсэн ойлголтонд тухайн газрын хэмжээ, гарц, ажиллаж буй хүн амын тооноос үл хамааран албан бусаар алт болон жонш олборлолт явагдаж буй бүх газруудыг хамруулав.

Судалгаагаар, *᠋᠋᠋᠋᠋᠋ ᠠᠶᠠᠠᠢ* гэдгийг бид албан бусаар алт/жонш олборлох салбарт хөдөлмөрийн гэрээтэй болон гэрээгүйгээр 18 насанд хүрээгүй хүүхдийг шууд удирдлаган доороо ажиллуулж байгаа, эсвэл 18 нас хүрээгүй хүүхдийн ажилд нь удирдан, зохион байгуулах үүрэгтэйгээр оролцдог, ажилтай

<sup>3</sup> ХАССТ, ОУХБ “Төв аймгийн Борнуур Заамар сумууд дахь албан бус алт олборлолт” судалгааны тайлан, 2004 он

холбоотой аливаа шийдвэр гаргахад нь голлох үүрэг гүйцэтгэдэг 18 ба түүнээс дээш насны хүн байна гэж тодорхойлсон.

“Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанл хүрэгчдийн суурь судалгаа”-нд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашиглав.

## 2.1 Тоон судалгааны арга зүй

### 2.1.1 Түүвэрлэлтийн арга зүй

Монгол Улсын нийт 21<sup>4</sup> аймгийн 332 сумаас 46 суманд албан бусаар алт олборлолт, 11 суманд албан бусаар жонш олборлолт явагддаг байна. Иймээс судалгааны түүвэрлэлтэнд дээрх 57 сум хамрагдсан юм.

#### Түүврийн хэмжээ

Улсын хэмжээнд албан бусаар алт, жонш олборлож байгаа хүн амын талаарх судалгаа, тоон мэдээлэл хангалтгүй байгаа учраас түүврийн хэмжээг тогтооход шаардлагатай статистик мэдээлэл дутагдалтай байлаа. 2004 онд явагдсан “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-ны үр дүнгээс харахад, улсын хэмжээнд 5-17 насны 68580 хүүхэд эдийн засгийн идэвхтэй байсан бөгөөд энэ нь мөн насны нийт хүүхдийн 10.1 хувийг бүрдүүлж байна. Тухайн үед эдийн засгийн идэвхтэй байсан нийт хүүхдүүдийн 0.8 хувь нь уул уурхайн салбарт ажиллаж байна гэсэн үр дүн гарчээ. Гэхдээ энэхүү тоон мэдээллээс албан бусаар алт болон жонш олборлож байгаа хүүхдүүдийн тоог шууд тодорхойлох боломжгүй юм. Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны 23300 хүн уул уурхайн салбарт ажиллаж байгаа<sup>5</sup> боловч эдгээр хүмүүсийг албан бусаар ажиллаж байна гэж шууд дүгнэх боломжгүй байв.

Иймээс тус судалгааны түүвэрлэлтэнд нийт 21 сум, сум бүрээс албан бусаар алт болон жонш олборлож байгаа 2 баг<sup>6</sup>, баг бүрээс 12 хүүхэд, 8 насанд хүрэгч сонгогдсон болно.

#### Түүврийн загвар

Судалгаанд түүвэрлэлтийн 3 шатат загварыг ашиглалаа. Түүвэрлэлтийн эхний шатны нэгж нь албан бусаар алт/жонш олборлодог **сумууд**, хоёр дахь шатны нэгж нь сонгогдсон сумын албан бус алт/жонш олборлолтын төвлөрөл хамгийн их болон хамгийн бага байгаа **багууд**, гурав дахь буюу сүүлийн шатны нэгж нь сонгогдсон баг дахь албан бусаар алт/жонш олборлодог **хүүхэд болон насанд хүрэгчид** байна.

Бидний сонирхож буй шинж тэмдэг болох албан бусаар алт/жонш олборлож байгаа хүн амын тоо сум бүрт харилцан адилгүй байлаа. Иймээс албан бусаар алт/жонш олборлож буй хүн амын төвлөрөлд үндэслэн *ᠶ᠋ᠪᠠᠭᠠᠶ᠋ᠠᠳ* хийсэн юм. Тухайн суманд албан бусаар алт олборлож байгаа хүн амын тоо 500-аас их бол их төвлөрөлтэй, албан бусаар жонш олборлож байгаа хүн амын тоо 80-аас их бол их төвлөрөлтэй гэж үзлээ. Хүснэгт 2.1-д албан бусаар алт/жонш олборлодог сумуудыг мужлан харууллаа.

<sup>4</sup> Нийслэл Улаанбаатар хотыг оруулаагүй болно.

<sup>5</sup> ҮСГ, “Ажиллах хүчний суурь судалгааны тайлан”, 2004 он

<sup>6</sup> Түүвэрлэлтийн хоёр дахь шатны арга зүйг үзнэ үү.



### Түүвэрлэлтийн нэгдүгээр шат

Бага хэмжээтэй мужийн хувьд давхар жинлэлтийг харгалзан, мөн пропорциональ төлөөлөх чадварт үндэслэн түүвэрлэлтийг хийхэд түүвэрлэлтийн эхний шатанд муж бүрээс дараахь тооны сумууд сонгогдов.

#### Өдлий үндэс 2.2. Түүвэрлэлтийн нэгдүгээр шатанд сонгогдсон сумуудын тоо, мужаар

Мужууд	Муж дахь албан бусаар алт олборлодог сумын тоо	Муж дахь албан бусаар жонш олборлодог сумын тоо	Муж бүрээс сонгогдсон сумын тоо
1 Албан бусаар алт олборлодог, төвлөрөл ихтэй сумууд	5	-	3
2 Албан бусаар жонш олборлодог, төвлөрөл ихтэй сумууд	-	3	2
3 Албан бусаар алт олборлодог, төвлөрөл багатай сумууд	41	-	13
4 Албан бусаар жонш олборлодог, төвлөрөл багатай сумууд	-	8	3
<b>Бүгд</b>	<b>46</b>	<b>11</b>	<b>21</b>


Муж бүрээс сумуудыг сонгохдоо буцаалтгүй энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Нэгдүгээр шатанд сонгогдсон сумуудыг Хүснэгт 2.3-т харууллаа.

#### Өдлий үндэс 2.3 Түүвэрлэлтийн нэгдүгээр шатанд сонгогдсон сумууд

Аймгууд	Сонгогдсон сумууд	Мужийн дугаар
1 Баянхонгор	Баян-Овоо	3
	Бууцагаан	3
	Бөмбөгөр	1
2 Өвөрхангай	Уянга	1
	Тарагт	3
	Бат-Өлзийт	3
3 Хэнтий	Цэнхэрмандал	3
	Дархан	4
	Мөрөн	3
4 Дорноговь	Айраг	2
	Өргөн	4
	Даланжаргалан	2
5 Өмнөговь	Цогт-Овоо	3
	Сэврэй	3
6 Сэлэнгэ	Мандал	3
	Баянгол	3
7 Дархан-Уул	Шарын гол	3
8 Төв	Заамар	1
	Сэргэлэн	3
9 Дундговь	Өлзийт	3
	Дэлгэрхангай	4
<b>Бүгд</b>		<b>21</b>

Зураг 2.1-д судалгаанд хамрагдсан аймаг, сумуудын зураглалыг тоймлон харууллаа.

Сóдóó 2.1. Судалгаанд хамрагдсан аймаг, сумуудын тойм зураглал



### Түүвэрлэлтийн хоёр дахь шат

Хоёрдугаар шатны түүвэрлэлт нь сонгогдсон суманд очсоны дараагаар хийгдсэн болно. Судлаачид түүвэрлэлтийн нэгдүгээр шатанд сонгогдсон суманд очиж, албан бусаар алт/жонш олборлож буй уурхай нь аль багт харьяалагдаж байгаад үндэслэн сонгогдсон сумын нийт багуудыг дараахь дэд мужид хуваасан. Үүнд:

- *Äyá ì óæ 1*: Албан бус алт/жонш олборлолтын төвлөрөл ихтэй багууд
- *Äyá ì óæ 2*: Албан бусаар алт/жонш олборлолтын төвлөрөл багатай багууд
- *Äyá ì óæ 3*: Албан бусаар алт/жонш олборлодоггүй багууд (өөрөөр хэлбэл багийн нутаг дэвсгэрт уурхай буюу орд газар байхгүй)

Үүний дараагаар түүвэрлэлтийн хоёрдугаар шатанд нэг ба хоёрдугаар дэд муж тус бүрээс нэг багийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Тухайн суманд албан бусаар алт/жонш олборлож буй нэг, эсвэл хоёр баг байгаа тохиолдолд тухайн багуудыг шууд сонгосон ба албан бус алт/жонш олборлолттой 2 багийн хувьд баг бүр дэх төвлөрлийн үзүүлэлтийг урьдчилан гаргасан. Харин тухайн сумын 3 ба түүнээс олон багт албан бусаар алт/жонш олборлох ажиллагаа явагдаж байвал төвлөрлийг тогтоож, их болон бага төвлөрөлтэй 2 багийг санамсаргүйгээр сонгов. Ингэхэд, түүвэрлэлтийн нэг дэх шатанд сонгогдсон 21 сумаас нийт 29 баг хоёр дахь шатны түүвэрлэлтэнд сонгогдсон.

### Түүвэрлэлтийн гурав дахь шат

Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд болон насанд хүрэгчдийн хувьд түүврийн хүрээг тус тусад нь тодорхойлох зорилгоор *óðóééí äñóóéäüí ðóóäýüä* ашиглан сонгогдсон бүх багийн уурхайн орчимд оршин сууж байгаа нийт өрхүүд, багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа зарим өрхүүдийн жагсаалтыг гаргасан. Үүний дараагаар, баг бүрээс 12 хүүхэд, 8 насанд



хүрэгчийг (нийтдээ 348 хүүхэд, 232 насанд хүрэгч) энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгож, судалгаанд хамруулав.

### 2.1.2 Түүврийн жин ба тооцооллын арга зүй

Түүврийн жин нь тухайн нэгжийн түүвэрлэлтэнд сонгогдох магадлалын урвуу хэмжигдэхүүн юм. Тус судалгааны түүвэрлэлтийн загвар нь жигнэсэн байдлаар хийгдээгүй учраас түүвэрлэлтийн нэгж тутамд түүврийн жинг тооцох, улмаар тооцоолол хийхэд түүврийн жинг ашиглах шаардлагатай.

Түүврийн жинг ашиглан албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн тоог тодорхойлов. Түүврийн жингийн тооцоонд дараахь (2.1) томъёог ашигласан ба ингэхдээ судалгааны түүвэрлэлтийн арга зүйтэй уялдуулж үзлээ.

$$\bar{Y}_t = \sum_{s=1}^5 \frac{N_{ts}}{n_{ts}} \sum_{i=1}^{n_{ts}} \sum_{j=1}^2 \frac{M_{tsij}}{m_{tsij}} \sum_{k=1}^{m_{tsij}} \frac{H_{tsijk}}{h_{tsijk}} \sum_{l=1}^{m_{tsij}} \frac{C_{tsijk}}{c_{tsijk}} \sum_{l=1}^{c_{tsijk}} y_{tsijkl} \quad (2.1)$$

Үүнд:

- s = s-дэх мужийн индекс
- t = t-дэх ашигт малтмалын төрлийн индекс
- i = i-дэх сумын индекс
- j = j-дэх дэд мужийн индекс
- k = k-дахь багийн индекс
- l = l-дэх түүвэрлэгдсэн хүн амын индекс
- N = тухайн муж дахь нийт сумын тоо
- n = сонгогдсон сумын тоо
- M = тухайн сумын дэд муж дахь нийт багийн тоо
- m = тухайн сумын дэд мужаас сонгогдсон багийн тоо
- H = сонгогдсон баг дахь нийт өрхийн тоо
- h = сонгогдсон багаас өрхийн жагсаалт асуулганд хамрагдсан нийт өрхийн тоо
- C = тухайн багийн нутаг дэвсгэрт албан бусаар алт/жонш олборлож байгаа нийт хүн амын тоо
- c = тухайн багаас судалгаанд сонгогдсон нийт хүн амын тоо

Дээрх томъёог ашиглан улсын хэмжээнд албан бусаар алт болон жонш олборлож байгаа нийт хүүхэд, насанд хүрэгчдийн тоог тодорхойлсон ба Хүснэгт 2.4-д судалгаанд хамрагдсан болон тооцоолсон албан бусаар алт/жонш олборлож байгаа хүмүүсийг гол шинж байдлаар харууллаа.

Улсын хэмжээнд 5-17 насны 7996 хүүхэд албан бусаар алт, жонш олборлох үйл ажиллагаанд оролцож байна. Эдгээр хүүхдүүдийн 91.4 хувийг алтны ордод ажиллаж буй хүүхдүүд бүрдүүлж байгаа бөгөөд алт, жоншны ордтой суманд, эсвэл уурхайн орчимд амьдардаг өрхийн хүүхдүүд энэхүү хөдөлмөрт оролцох нь түгээмэл байна. Алт, жонш олборлож байгаа 5-17 насны 2162 хүүхэд тухайн суманд 5-аас доош жил амьдарч байгаа нь уурхайд ажиллах зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцох явдал багагүй байгааг харуулж байна. Нийт 2572 хүүхэд сургуулиас завсардан алт, жонш олборлох ажил хийж байгаа ба сургуульд сурахынхаа хажуугаар уурхайд ажиллаж буй хүүхдийн тоо түүнээс хоёр дахин илүү байлаа.

Тооцооллын үр дүнгээс харахад, улсын хэмжээнд 18 ба түүнээс дээш насны 37906 насанд хүрэгч албан бусаар алт, жонш олборлож байна. Тэдний дийлэнхийг алт олборлодог, эрэгтэйчүүд бүрдүүлж байлаа. Хүүхдүүдтэй харьцуулахад алт, жонш олборлох зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцох явдал өндөр, цаашлаад уурхайн орчимд амьдарч буй байдал илүү байна.

*ᠪᠢᠶᠢᠨᠠᠨᠢ* 2.4. Судалгаанд хамрагдсан болон тооцоолсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхэд, насанд хүрэгчдийн тоо, сонгосон шинж байдлаар

Сонгосон шинж байдал	Хүүхэд (5-17 настай)		Насанд хүрэгч (18 ба түүнээс дээш настай)	
	Судалгаанд хамрагдсан	Тооцоолсон	Судалгаанд хамрагдсан	Тооцоолсон
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	266	6562	158	25373
Эмэгтэй	82	1434	74	12533
<b>Олборлож буй ашигт малтмалын төрөл</b>				
Алт	288	7309	192	33960
Жонш	60	687	40	3946
<b>Ихэвчлэн амьдардаг газар</b>				
Уурхайн орчимд	151	2814	132	19636
Тухайн суманд	178	4890	80	13916
Өөр аймаг, суманд	19	292	20	4354
<b>Шилжилтийн байдал</b>				
Шилжигч	97	2162	91	16345
Шилжигч бус	251	5834	141	21561
<b>Сургуульд сурдаг эсэх</b>				
Сурдаг	237	5424	-	-
Сурдаггүй	111	2572	-	-
<b>Бүгд</b>	<b>348</b>	<b>7996</b>	<b>232</b>	<b>37906</b>

Улсын хэмжээнд албан бусаар алт/жонш олборлож байгаа багуудад 0-6 насны, өөрөөр хэлбэл сургуулиас өмнөх насны нийт 9400 хүүхэд (0-4 насны нийт 6011 хүүхэд) байгаа бөгөөд, тэдний 23.9 хувь болох 2245 хүүхэд (0-4 насны хүүхдийн 24.5 хувь буюу 1471 хүүхэд) алт/жонш олборлож буй газарт буюу уурхайд амьдардаг байлаа. Сургуулиас өмнөх насны хүүхдүүд албан бусаар алт/жонш олборлож байгаа эсэхийг судалж үзэхэд, нийт 9305 хүүхэд албан бусаар алт болон жонш олборлоход оролцдоггүй хүүхдүүд байв (ажил эрхлэлтийн байдлыг 5 ба түүнээс дээш насны хүн амын хувьд тодорхойлсон болно).

### 2.1.3 Асуулгын хуудас

Тоон судалгааны мэдээллийг дараахь ялгаатай асуулгын хуудсуудаар цуглуулсан. Үүнд:

1. Өрхийн асуулга
2. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдийн асуулга
3. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдийн эцэг/эхийн асуулга
4. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдийн ажил олгогчийн асуулга
5. Албан бусаар алт/жонш олборлож байгаа насанд хүрэгчдийн асуулга

Асуулгын хуудсуудыг боловсруулахад судалгааны багийн гишүүд, Монгол дахь ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн ажилтнууд, Энэтхэг улсын Шинэ-Дели хот дахь ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн бүсийн судалгааны мэргэжилтэн хамтран ажилласан.

Өрхийн асуулгад сонгогдсон багийн нутагт орших алт, жоншны уурхайд оршин сууж байгаа нийт өрхүүд, багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа зарим өрхүүдийг хамруулав. Энэхүү асуулгын хуудас нь албан бусаар алт ба жонш олборлож байгаа нийт хүн амын тоог тодорхойлоход ашиглагдсан болно.

Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, тэдний эцэг/эх болон ажил олгогчийн асуулга нь уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн шинж байдал, ажил эрхлэлт, ажлын нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр хамгааллын асуудлыг цогц байдлаар үнэлж, дүгнэлт өгөх зорилгоор боловсруулагдсан.

Асуулгын хуудас бүрт хамрагдсан нэгжийн тоог Хүснэгт 2.5-д харуулав.

*᠋ᠣᠵᠢᠨᠢᠶ᠋ᠠᠳᠤ 2.5 Судалгаанд хамрагдалт*

	Асуулгын төрлүүд	Хамрагдсан нэгжийн тоо
1	Өрхийн асуулга	
	Хамрагдсан өрхийн тоо	2592
	Хамрагдсан хүн амын тоо	11252
2	Хүүхдийн асуулга	348
3	Эцэг/эхийн асуулга	154
4	Ажил олгогчийн асуулга	44
5	Насанд хүрэгчдийн асуулга	232

#### **2.1.4 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт**

Судалгааны мэдээлэл цуглуулалтанд МУИС-ийн ХАССТ-ийн багш, судлаачид, хүн ам зүйн бакалавр, магистрын ангийн оюутнууд оролцсон. Мэдээлэл цуглуулах ажлыг 8 багийн ахлагч, 33 ярилцлага авагчийн бүрэлдэхүүнтэйгээр 2005 оны 9-р сарын 9-нөөс 29-ны хооронд хийж гүйцэтгэв. Багийн ахлагч, ярилцлага авагчдын үүргээ гүйцэтгэж буй байдлыг үнэлэх, мэдээлэл цуглуулалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор Хэнтий, Төв аймгуудад хяналт, шалгалтыг хийсэн.

Тоон судалгааны мэдээллийг ISSA программын тусламжтайгаар компьютерт оруулж, мэдээллийн боловсруулалт, шинжилгээнд судалгааны мэдээлэлд статистик шинжилгээ хийх SPSS программыг ашиглалаа. Тоон судалгааны мэдээллийн шинжилгээнд энгийн тайлбар статистик, харьцуулах статистикийн арга зүйг өргөн хэрэглэв.

#### **2.1.5 Судалгааны хязгаарлагдмал байдал**

“Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-ны гол онцлог нь улсын хэмжээнд албан бусаар алт болон жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн тоог тодорхойлсон явдал байлаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажил хичээлийн шинэ жил эхэлсэний дараагаар хийгдсэн бөгөөд энэ үед гар аргаар алт олборлогчдын хувьд ихээхэн

шилжилт хөдөлгөөнтэй байлаа. Энэхүү нөхцөл байдал нь судалгааны хамрагдалтанд нөлөөлсөн байж болох юм.

Нөгөөтэйгүүр, судалгаанд хамрагдсан багуудын нийт өрхөөс өрхийн асуулга авах боломжгүй байсан учраас албан бусаар алт/жонш олборлогчдыг бүрэн хамруулах үүднээс уурхайд оршин сууж байгаа нийт өрх, багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа зарим өрхүүдийг хамруулсан. Албан бусаар алт/жонш олборлож байгаа багууд дахь өрхүүд тус судалгаанд дутуу хамрагдсан учраас түүврийн тооцооллыг хийхдээ засварлагч хүчин зүйлийг ашиглав.

## **2.2 Чанарын судалгааны арга зүй**

“Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-нд чанарын судалгааны арга зүйг мөн адил ашигласан. Чанарын судалгаа буюу бүлгийн ярилцлагад засаг/захиргааны болон удирдах албан тушаалтан, иргэн, ажил олгогч, багш, цагдаа, эрүүл мэндийн ажилтан, ажил олгогч, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс хамрагдсан юм. Бүлгийн ярилцлагаар хөдөлмөр эрхэлж буй, тэр дундаа албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн талаарх олон нийтийн үзэл бодлыг тодорхойлох, тэдний ажлын нөхцөл, сургуульд хамрагдалт, хөдөлмөр зохицуулалт, энэ талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг тодруулах зорилготой байлаа.

Бүлгийн ярилцлагаар дараахь үндсэн асуудлуудын хүрээнд мэдээллийг цуглуулав. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх боломжтой хууль эрх зүйн зохицуулалт ба нөөц бололцоо;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг устгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хууль эрх зүйн зохицуулалтууд, түүний үр дүн;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэнд гарч буй өөрчлөлт, хувьсал, өргөжилт, хүрээгээ тэлж буй байдал;
- Хот-хөдөө дэх хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт/динамик, алт/жоншны уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдийн шилжилт хөдөлгөөн;
- Хүүхэд ба насанд хүрэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт/динамик;
- Хүүхдийн хөдөлмөр, түүнтэй тэмцэх асуудлаарх оролцогчдын үзэл бодол, хүүхдийн хөдөлмөрийг устгахад шаардлагатай арга хэмжээ, зохицуулалтын механизм;
- Хүүхэд, тэдний гэр бүлд зориулан боловсрол, эрүүл мэнд, зээл тусламж болон бусад нийгмийн үйлчилгээг “хүртээсэн” бодит жишээ, баримт, энэ талаар үйл ажиллагааг явуулахад бэлэн байгаа эсэх;
- Хүүхдүүдийн эрүүл мэндийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалалтын хувцас, хэрэгсэл олгосон бодит жишээ, баримт ба энэ талаарх үйл ажиллагааг явуулахад бэлэн байгаа эсэх, нөөц бололцоо; зэрэг болно.

Чанарын судалгааны мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар боловсруулж, судалгааны тайланд шигтгээ хэлбэрээр оруулсан болно.

### БҮЛЭГ 3. АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ БАГУУД ДАХЬ ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ

Энэхүү бүлэгт албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын нас, хүйсийн бүтэц, шилжих хөдөлгөөн, уурхай дахь ажил эрхлэлтийн байдал болон сургуулийн насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын талаар өгүүлэх юм. Мөн албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрхүүдийн бүртгэл, байршил, өрхийн хэмжээ<sup>7</sup> болон уурхайд ажиллаж байгаа өрхийн гишүүдийн тоонд анхаарал хандуулах болно.

**3.1 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрхийн шинж байдал**  
"Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа"-нд албан бусаар алт болон жонш олборлолт явагдаж буй нийт 21 сум, тэдгээр сумдаас 19805<sup>8</sup> өрх хамрагдсан. Нийт өрхийн 35.9 хувь нь уурхайд, 64.1 хувь нь багийн нутаг дэвсгэрт оршин суудаг өрхүүд байлаа. Өрхүүдийн шинж байдлыг Хүснэгт 3.1-д харуулав.

*Огъи үгэ* 3.1 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь өрхүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлт, байршлаар

Сонгосон үзүүлэлт	Байршил		Нийт
	Уурхайд	Багийн нутаг дэвсгэрт	
<b>Өрхөд амьдарч байгаа хүн амын тоо</b>			
1	5.3	3.5	4.2
2-3	36.1	24.1	28.4
4-6	42.4	61.1	54.4
7-9	12.1	11.0	11.4
10 ба түүнээс олон	4.1	0.3	1.6
<i>Аоги ааае</i>	4.40	4.44	4.42
<b>Алт/жонш олборлож буй хүн амын тоо</b>			
Байхгүй	3.1	19.2	13.4
1	11.8	23.3	19.2
2-3	50.7	47.3	48.5
4-5	21.7	9.1	13.6
6+	12.7	1.1	5.3
<i>Аоги ааае</i>	3.28	1.78	2.32
<b>Оршин сууж буй сумандаа бүртгэлтэй эсэх</b>			
Тийм	39.5	97.1	76.4
Үгүй	60.5	2.9	23.6
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон нийт өрхийн тоо</b>	<b>7111</b>	<b>12694</b>	<b>19805</b>

Өрхийн хэмжээг байршлаар авч үзэхэд, багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа 4 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн хувь уурхайд оршин сууж байгаа мөн тооны гишүүнтэй өрхийн хувиас 13.8 пунктээр өндөр байв. Өрхөд амьдарч байгаа хүн амын дундаж тоо 4.42 гарсан нь улсын дундажтай нэлээд ойролцоо үзүүлэлт бөгөөд үүнд байршлаар төдийлөн ялгаа ажиглагдсангүй. Өөрөөр

<sup>7</sup> Өрхийн хэмжээ гэдэг нь нэг өрхөд амьдарч байгаа нийт хүн амын тоо юм.

<sup>8</sup> Тооцоолсон өрхийн тоо

хэлбэл, уурхайд болон багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа өрхүүдийн хүн амын дундаж тоо ердөө 0.04 пунктээр ялгаатай байлаа.

Албан бусаар алт/жонш олборлож буй багуудын уурхайд оршин суудаг өрхүүдийн 3.1 хувь нь албан бусаар алт болон жонш олборлодог нэг ч гишүүнгүй байхад, багийн нутагт оршин суудаг өрхүүдийн 1/5 орчим хувь нь уурхайд ажилладаг гишүүнгүй өрхүүд байлаа. Үүнтэй холбоотойгоор, уурхайд оршин суудаг өрхийн нийт (4-5) гишүүдээс 3-4 нь албан бусаар алт/жонш олборлоход оролцдог ажээ. Гэтэл багийн нутагт оршин сууж байгаа нэг өрхийн 4-5 (4.44) гишүүнээс 1-2 (1.78) нь л албан бусаар алт ба жонш олборлоход оролцдог байна. Үүнээс уурхайн орчимд амьдарч байгаа өрхийн гишүүдийн дийлэнх нь албан бусаар алт/жонш олборлох хөдөлмөрт оролцдог гэдгийг харж болно.

Албан бусаар алт/жонш олборлож буй 4 өрх тутмын 3 нь (76.4 хувь) сумандаа бүртгэлтэй байгаа боловч энэ тоо байршлаар нэлээд ялгаатай байлаа. Тухайлбал, уурхайн орчимд амьдарч буй өрхүүдийн 3/5 нь тухайн сумандаа бүртгэлгүй байхад, багийн нутаг дэвсгэрт амьдарч буй өрхүүд бараг бүгд бүртгэлтэй байна. Үүнээс уурхайн орчимд өөр аймаг, сумаас шилжин ирсэн, албан бусаар алт ба жонш олборлоход илүүтэй оролцдог өрх, хүмүүс оршин суудаг гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

**3.2 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын шинж байдал**  
Тооцооллоор, энэхүү судалгаанд 19805 өрхийн 87617 хүн хамрагдсан ба нийт хүн амын 55 хувийг эрэгтэй, 45 хувийг эмэгтэй хүн ам бүрдүүлж байна. Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амыг аймгуудаар Хүснэгт 3.2-т харууллаа.


*Өгүүлэл 3.2. Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын хувийн жин түүвэрлэгдсэн аймаг, хүйсээр*

Түүвэрлэгдсэн аймгууд	Хүйс		Бүгд	Тооцоолсон нийт хүн амын тоо
	Эрэгтэй	Эмэгтэй		
Баянхонгор	49.9	50.1	100.0	11778
Өвөрхангай	57.9	42.1	100.0	17998
Төв	61.9	38.1	100.0	6190
Өмнөговь	59.1	40.9	100.0	4423
Дархан-Уул	52.5	47.5	100.0	8642
Сэлэнгэ	51.8	48.2	100.0	26413
Дорноговь	78.6	21.4	100.0	3581
Дундговь	52.3	47.7	100.0	2975
Хэнтий	51.1	48.9	100.0	5617
<b>Нийт</b>	<b>55.0</b>	<b>45.0</b>	<b>100.0</b>	<b>87617</b>

Хүснэгт 3.2-оос харахад, Өвөрхангай, Баянхонгор, Сэлэнгэ аймгаас судалгаанд хамрагдагсад хамгийн өндөр хувийг эзэлж байна. Тухайлбал, нийт хүн амын 30.1 хувийг Сэлэнгэ аймгийн албан бусаар алт, жонш олборлодог багуудад ажиллаж/амьдарч буй хүмүүс бүрдүүлсэн бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан бусад аймгуудын хүн амын эзлэх хувийн жингээс харгалзан 9.6-26.7 пунктээр өндөр үзүүлэлт байлаа. Харин Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын албан бусаар алт/жонш олборлолт явагдаж буй багууд дахь хүн амын тоо хамгийн бага хувийг эзэлж байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй багуудад амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаа 122 буюу 100 эмэгтэйд 122 эрэгтэй ногдож байлаа. Бараг бүх аймгуудад эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийн тооноос олон байсан бөгөөд, ялангуяа Дорноговь аймгийн албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь эрэгтэй хүн амын тоо эмэгтэй хүн амын тооноос 3.7 дахин өндөр байв.

Зураг 3.1-д албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын нас, хүйсийн бүтцийг суваргаар<sup>9</sup> дүрслэн харууллаа.



Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын нас, хүйсийн суваргын ерөнхий хэлбэрийг харахад, 10-29 насны хүмүүс илүүтэй хамрагдсан дүр зураг ажиглагдаж байна.

Хүйсийн харьцааг насны бүлгээр авч үзэхэд, 0-9, 35-49 мөн 55 ба түүнээс дээш насны бүлгүүдэд эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амын тооноос олон, бусад насны бүлгүүдэд эрэгтэй хүн амын тоо эмэгтэй хүн амын тооноос олон байлаа.

Хүн амын насны бүтцийг тодорхойлох зарим гол үзүүлэлтийг Хүснэгт 3.3-т харуулав.

Албан бусаар алт/жонш олборлолт явагдаж буй багуудад оршин сууж байгаа нийт хүн амын тал хувь нь 23-аас доош, тал хувь нь 23-аас дээш насны хүмүүс байна. Голч насанд хүйсээр ялгаа ажиглагдсангүй. Хүн ам зүйн ачаалал 45.7

<sup>9</sup> Суваргыг хувийн жингээр зурсан болно.

байгаа ба энэ нь насны бүтцээс хамаарах нийгэм эдийн засгийн үр нөлөө харьцангуй бага байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны 100 хүнд хөдөлмөрийн бус насны ойролцоогоор 46 хүнийг "тэжээх" үүрэг ногдож байна. Насны залуу бүтэцтэй холбоотойгоор нийт ачааллын 93 орчим хувийг хүүхдийн ачаалал эзэлж байлаа.

*ᠬᠢᠭᠠᠨ ᠪᠤᠰᠤᠶ᠋ᠢᠨ 3.3 Албан бусаар алт/жонш олборлож буй багууд дахь хүн амын хувийн жин, насны бүтцийг харуулах зарим үзүүлэлт болон хүйсээр*


Насны бүтцийн үзүүлэлт	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
Залуу нас (0-14 )	28.4	30.2	29.2
Хөдөлмөрийн нас (15-59 )	69.7	67.3	68.6
Хөгшин нас (60 ба түүнээс дээш)	1.9	2.5	2.2
<i>ᠠᠶᠢᠨ ᠡᠻᠡᠳᠦ ᠳᠦᠵᠢ ᠠᠢ ᠴᠡᠰᠡᠢ ᠠ-ᠠᠠᠬᠡᠭᠡ</i>	*	*	45.7
<i>ᠲᠡᠵᠡᠳᠡᠭᠡᠢ ᠠ-ᠠᠠᠬᠡᠭᠡ</i>	*	*	42.5
<i>ᠳᠡᠰᠡᠨ ᠠᠶᠢᠨ ᠤ ᠳᠡᠵᠢ ᠠᠢ ᠤᠢ ᠠ-ᠠᠠᠬᠡᠭᠡ</i>	*	*	3.2
<i>ᠠᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠠᠶᠢ</i>	24.98	24.89	25.10
<i>ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢ</i>	23.00	23.00	23.00
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон нийт хүн амын тоо</b>	<b>48204</b>	<b>39413</b>	<b>87617</b>

*\*-ᠳᠡᠵᠡᠳᠡᠭᠡ ᠠᠢ ᠴᠡᠰᠡᠢ ᠠ-ᠠᠠᠬᠡᠭᠡ ᠳᠡᠵᠡᠳᠡᠭᠡ ᠳᠡᠵᠡᠳᠡᠭᠡ ᠳᠡᠵᠡᠳᠡᠭᠡ ᠳᠡᠵᠡᠳᠡᠭᠡ.*



Таваас дээш насны нийт хүн амын ажил эрхлэлтийн байдлыг албан бусаар алт олборлоход оролцдог, албан бусаар жонш олборлоход оролцдог, энэ хэлбэрийн хөдөлмөрт оролцдоггүй гэсэн үндсэн шалгууруудаар тодорхойлсон юм. Албан бусаар алт/жонш олборлож байгаа багуудад тав ба түүнээс дээш насны нийт 81606 хүн байгаагийн 50.5 хувь нь буюу нийт 41269 хүн албан бусаар алт олборлоход оролцдог, 5.7 хувь нь буюу 4633 хүн албан бусаар жонш олборлоход оролцдог, 43.8 хувь нь буюу 35704 хүн ийм төрлийн ажилд оролцдоггүй хүмүүс байна.

Тэдний хүйсийн байдлыг авч үзэхэд албан бусаар алт болон жонш олборлох үйл ажиллагаанд эрэгтэйчүүд түлхүү оролцдог нь харагдаж байна (Зураг 3.2). Ялангуяа албан бусаар жонш олборлож буй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээс 3.5 дахин өндөр байлаа. Харин албан бусаар алт/жонш олборлох үйл ажиллагаанд алинд нь ч оролцдоггүй эрэгтэй хүн амын хувь эмэгтэй хүн амын хувиас 23.4 пунктээр доогуур байлаа.





Судалгааны үр дүнгээс харахад, уул уурхайн салбарын үндсэн хэлбэрүүд болох алт болон жоншны ордод албан бусаар 5 ба түүнээс дээш насны нийт 45902 хүн ажиллаж байна. Зураг 3.3а ба 3.3б-д алт/жоншны ордод албан бусаар ажиллаж буй хүмүүсийг нас болон олборлож буй ашигт малтмалын төрлөөр харууллаа.



Албан бусаар алт болон жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн хувь нэлээд ойролцоо байлаа. Энэ хэлбэрийн хөдөлмөрт оролцож буй хүн амын насны бүтцийг харахад насанд хүрэгчид хүүхдүүдээс илүүтэй оролцож байгаа ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Албан бусаар алт/жонш олборлоход оролцож байгаа насанд хүрэгчдийн хувь хүүхдүүдийнхээс 4.6-5.8 дахин өндөр байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүмүүсийг олборлож буй ашигт малтмалын төрлөөр авч үзэхэд, 10 хүн тутмын 9 нь алт, үлдсэн 1 нь жонш олборлож буй хүмүүс байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй багуудад оршин сууж байгаа 5-17 насны нийт хүүхдүүдийн 27.4 хувь нь албан бусаар алт олборлодог, 2.6 хувь нь албан бусаар жонш олборлодог, үлдсэн хувь нь үүнд оролцдоггүй хүүхдүүд байлаа. Хүүхдүүдийн хувьд, нас ахихын хэрээр албан бусаар алт/жонш олборлоход оролцож буй байдал нэмэгдсэн хандлага ажиглагджээ (Хүснэгт 3.4).

Тухайлбал, албан бусаар жонш олборлож буй нийт хүүхдүүдийн 5.2 хувь нь 5-8 настай байсан бол 44.2 хувь нь 15-17 насны хүүхдүүд байна. Мөн жонш олборлоход оролцож байгаа нийт хүүхдүүдийн 5 хүрэхгүй хувийг 5-8 насныхан бүрдүүлж байгаа ба энэ нь жонш олборлоход оролцож байгаа 15-17 насны хүүхдүүдийн хувиас даруй 12.6 дахин бага үзүүлэлт байна.

*᠋ᠣᠵᠢᠶ᠋ᠠᠳ 3.4. Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, алт/жонш олборлоход оролцдог эсэх, насны бүлгээр*

Насны бүлэг	Алт/жонш олборлоход оролцдог эсэх			Нийт
	Алт олборлодог	Жонш олборлодог	Оролцдоггүй	
<i>᠋ᠣᠵᠢᠶ᠋ᠠᠳ</i>				
5-8	5.2	4.4	32.6	24.4
9-11	16.5	14.8	23.9	21.6
12-14	34.1	25.5	24.6	27.2
15-17	44.2	55.3	18.9	26.8
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>5-17 насны тооцоолсон хүүхдүүдийн тоо</b>	<b>7309</b>	<b>687</b>	<b>18703</b>	<b>26699</b>
<i>᠋ᠠᠯᠠᠶ᠋ᠠᠳ ᠋ᠣᠵᠢᠶ᠋ᠠᠳ</i>				
18-25	25.8	19.4	26.7	25.6
25-34	33.1	39.4	23.1	30.5
35-44	27.3	26.5	23.8	26.1
45-54	11.6	13.0	13.0	12.1
55-64	1.9	1.6	6.8	3.4
65 ба түүнээс дээш	0.3	0.1	6.6	2.3
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>18 ба түүнээс дээш насны тооцоолсон насанд хүрэгчдийн тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>	<b>17001</b>	<b>54907</b>

Албан бусаар алт/жонш олборлож буй багуудад амьдарч байгаа насанд хүрэгчдийн дунд 25-34 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд, алт/жонш олборлож буй хүмүүсийн дунд ч мөн насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байлаа. Харин 65 ба түүнээс дээш насныхны хувьд албан бусаар алт/жонш олборлож буй байдал хамгийн бага байна.

Албан бусаар алт/жонш олборлолт явагдаж буй багуудад амьдарч буй 6-17 насны хүүхдүүдээс тэдний сургуульд хамрагдалтын талаар сонирхсон ба үр дүнг Хүснэгт 3.5-д харуулав.

Өзгөтэй 3.5. 6-17 насны хүүхдүүдийн хувийн жин, сургуульд сурдаг эсэх, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Сургуульд сурдаг эсэх		Бүгд	6-17 насны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тоо	6-17 насны тооцоолсон хүүхдүүдийн тоо
	Тийм	Үгүй			
<b>Насны бүлэг</b>					
6-8	72.0	28.0	100.0	580	4667
9-11	95.0	5.0	100.0	627	5780
12-14	91.7	8.3	100.0	741	7267
15-17	74.8	25.2	100.0	890	7133
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	81.6	18.4	100.0	1554	13571
Эмэгтэй	86.8	13.2	100.0	1284	11276
<b>Алт/жонш олборлоход оролцдог эсэх</b>					
Алт олборлодог	72.5	27.5	100.0	749	7306
Жонш олборлодог	79.4	20.6	100.0	128	687
Оролцдоггүй	89.1	10.9	100.0	1961	16852
<b>Оршин сууж буй сумандаа бүртгэлтэй эсэх</b>					
Тийм	86.9	13.1	100.0	2491	21758
Үгүй	63.0	37.0	100.0	347	3089
<b>Өрхийн байршил</b>					
Уурхайн орчимд	64.8	35.2	100.0	739	5301
Багийн нутаг дэвсгэрт	89.1	10.9	100.0	2099	19546
<b>Нийт</b>	<b>83.9</b>	<b>16.1</b>	<b>100.0</b>	<b>2818</b>	<b>24847</b>

Сургуульд хамрагдалтын байдлыг насны бүлгээр авч үзэхэд 6-8 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын байдал хамгийн доогуур гарчээ. Мөн 15-17 насны 4 хүүхэд тутмын нэг нь сургуульд сурахгүй байгаа нь энэ насны хүүхдүүд алт/жонш олборлоход илүүтэй оролцож байгаатай холбоотой байна (Бүлэг 4-ийг үзнэ үү).

Алт/жонш олборлох ажиллагаанд оролцдог, алт/жонш олборлож буй газарт оршин сууж буй, тухайн сумандаа бүртгэлгүй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт доогуур байгааг Хүснэгт 3.5-аас харж болно. Уурхайн орчимд оршин сууж буй 10 хүүхэд тутмын 6 нь (63 хувь) сургуульд сурч байгаа бол багийн нутаг дэвсгэрт оршин суудаг 10 хүүхэд тутмын бараг 9 нь (86.9 хувь) сургуульд сурч байна. Үүнээс сургууль завсардсан буюу суралцаагүй хүүхдүүд уурхайн орчимд амьдарч, албан бусаар алт/жонш олборлох ажиллагаанд арай илүү оролцдог болох нь харагдаж байна.

Өрхийн асуулгыг ашиглан цуглуулсан өөр нэг үндсэн мэдээлэл бол уурхайн орчимд болон тухайн багийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүмүүсийн шилжих хөдөлгөөний талаарх мэдээлэл байлаа. Тав ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.4 хувь нь буюу 50887 хүн судалгаа авсан багийн нутаг дэвсгэрт 5 ба түүнээс дээш жил, 22.4 хувь нь буюу 18286 хүн 1-4 жил, 15.2 хувь буюу 12433 хүн нэг хүртлэх жилийн хугацаанд тус тус тухайн газартаа амьдарч байгаа хүмүүс байлаа.

Тэдний шилжих сонирхлыг судалж үзэхэд, 55.6 хувь нь тухайн газартаа 5 ба түүнээс дээш жил, 13.2 хувь нь 1-4 жил, 16.1 хувь нь нэг хүртлэх жил амьдрахаар төлөвлөж байна. Харин 5 ба түүнээс дээш насны хүмүүсийн 15.1 хувь нь ирээдүйн шилжилтийнхээ талаар ямар нэгэн төлөвлөлт хийгээгүй байлаа.

Хүснэгт 3.6-д албан бусаар алт/жонш олборлож байгаа багууд дахь тав ба түүнээс дээш насны хүн амын алт/жонш олборлолтын байдлыг шилжих хөдөлгөөний зарим үзүүлэлтээр харууллаа.


**Өгүүлэл 3.6. Тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, шилжих хөдөлгөөний үзүүлэлт ба алт/жонш олборлоход оролцдог эсэхээр**

Шилжих хөдөлгөөний үзүүлэлт	Алт/жонш олборлоход оролцдог эсэх			Нийт
	Алт олборлодог	Жонш олборлодог	Оролцдоггүй	
<b>Судалгаа авсан газарт оршин сууж буй хугацаа</b>				
5 ба түүнээс дээш жил	53.6	29.6	77.0	62.4
1-4 жил	28.2	16.2	16.1	22.4
1 жил хүртэл	18.2	54.2	6.9	15.2
<b>Судалгаа авсан газарт амьдрахаар төлөвлөж буй хугацаа</b>				
5 ба түүнээс дээш жил	50.6	34.8	64.6	55.6
1-4 жил	14.2	8.7	12.2	13.2
1 хүртлэх жил	18.9	51.4	8.5	16.1
Төлөвлөөгүй/Мэдэхгүй	16.3	5.1	14.7	15.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>5 ба түүнээс дээш насны тооцоолсон нийт хүн амын тоо</b>	<b>41269</b>	<b>4633</b>	<b>35704</b>	<b>81606</b>

Албан бусаар алт олборлож байгаа нийт хүн амын 53.6 хувь нь судалгаа авсан газарт 5 ба түүнээс дээш жил, үлдсэн хувь нь 5 хүртлэх жилийн хугацаанд оршин сууж буй хүмүүс байлаа. Жонш олборлож буй хүмүүсийн талаас илүү хувь нь нэг жил хүртлэх хугацаанд тухайн газарт оршин сууж буй шилжигчид байлаа.

Албан бусаар алт/жонш олборлох үйл ажиллагаанд оролцдоггүй хүн амын хувьд “Тухайн газартаа 5 ба түүнээс жилээр оршин сууна” гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байна (64.6 хувь). Гэтэл жонш олборлож байгаа хүн амын хувьд тухайн газартаа нэг жил хүртлэх хугацаагаар оршин суухаар төлөвлөж байгаа хувь хамгийн өндөр байгаа нь (51.4 хувь) нэлээд сонирхол татах үр дүн байлаа.

Оршин сууж буй сумандаа бүртгэлтэй байх эсэх нь тухайн хариулагчийн оршин сууж буй хугацаатай шууд хамааралтай байна (Зураг 3.4). Тухайн газартаа тав ба түүнээс дээш жил амьдарч байгаа хүн амын 91.5 хувь нь бүртгэлтэй байхад, нэг жил хүртлэх хугацаагаар амьдарч байгаа 10 хүн тутмын бараг 7 нь (68.7 хувь) бүртгэлгүй байлаа.



Ирээдүйд шилжихээр төлөвлөж байгаа хүмүүсийн хувьд оршин сууж буй сумандаа бүртгүүлэх сонирхол бага байна. Өөрөөр хэлбэл, тухайн газартаа оршин суухаар төлөвлөж буй хугацаа бага байхын хэрээр бүртгэлд хамрагдаагүй байдал өндөр байгаа нь харагдаж байна. Тухайлбал, судалгаа авсан газарт нэг жил хүртэл хугацаагаар амьдрахаар төлөвлөж байгаа 5 ба түүнээс дээш насны хүн амын 68.2 хувь, 1-4 жил амьдрахаар төлөвлөж байгаа 4 хүн тутмын 1 нь (24.5 хувь) судалгаа авах үед оршин сууж байсан сумандаа бүртгүүлээгүй хүмүүс байлаа.

Үүнээс байнга оршин суух төлөвлөгөөгүй хүмүүс бүртгэлийн асуудалд анхаарал тавьдаггүй гэдэг нь харагдаж байгаа бөгөөд бүртгэлгүй байдал нь тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

## **БҮЛЭГ 4. АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ ХҮҮХДҮҮД**

Энэ бүлэгт албан бусаар алт, жонш олборлож буй 5-17 насны хүүхдүүдийн шинж байдал, өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт, олж буй орлого ба зарцуулалт, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, дадал зуршил, ирээдүйн хүсэл мөрөөдөл, тэдэнд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй авч үзэх болно.

### **4.1 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн шинж байдал**

“Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-нд нийтдээ 288 алт олборлогч, 60 жонш олборлогч хүүхдүүд хамрагдсан бөгөөд тархаалтын тооцооллоос харахад судалгаанд хамрагдсан алт олборлож буй хүүхдүүд 7309 алт олборлогч хүүхдүүдийг, жонш олборлож буй хүүхдүүд 687 жонш олборлогч хүүхдүүдийг төлөөлж байна. Өмнөх бүлгүүдэд энэ талаар нэлээд дэлгэрэнгүй тайлбарласан тул энэ бүлэгтээ зөвхөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд нарийвчилсан мэдээллийг гаргалаа. Ингэхдээ алт, жоншны албан бус уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдийн түүврийн хэмжээ ялгаатай байгааг харгалзан харьцуулсан тайлбар хийхийг зорьсонгүй.

#### **4.1.1 Хүн ам зүйн шинж байдал**

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, насаар Хүснэгт 4.1-д харууллаа.

*Өгүүлэл 4.1.* Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, насаар

Нас	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
5	0.1	0.0	0.1	0.0	0.0	0.0
6	1.1	1.6	1.2	0.0	0.0	0.0
7	1.7	0.0	1.4	2.1	0.0	1.8
8	0.6	3.0	1.1	0.0	0.0	0.0
9	0.6	2.6	0.9	1.1	11.2	2.8
10	6.1	2.5	5.4	8.1	12.9	8.9
11	4.7	0.3	3.9	4.4	0.0	3.6
12	8.9	0.9	7.4	3.2	25.9	7.0
<b>5-12</b>	<b>23.7</b>	<b>10.9</b>	<b>21.4</b>	<b>18.8</b>	<b>50.0</b>	<b>24.2</b>
13	8.7	15.9	10.0	8.8	18.1	10.4
14	16.5	29.5	18.8	12.0	18.1	13.0
15	20.3	12.6	18.9	12.8	8.6	12.1
<b>13-15</b>	<b>45.5</b>	<b>58.1</b>	<b>47.8</b>	<b>33.4</b>	<b>44.9</b>	<b>35.4</b>
16	16.2	15.8	16.1	18.1	0.0	15.0
17	14.6	15.2	14.7	29.5	5.2	25.4
<b>16-17</b>	<b>30.8</b>	<b>31.0</b>	<b>30.8</b>	<b>47.8</b>	<b>5.1</b>	<b>40.4</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<i>Дундаж нас</i>	<i>14.0</i>	<i>14.2</i>	<i>14.1</i>	<i>14.6</i>	<i>12.5</i>	<i>14.2</i>
<b>Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо</b>	<b>216</b>	<b>72</b>	<b>288</b>	<b>50</b>	<b>10</b>	<b>60</b>
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>5993</b>	<b>1316</b>	<b>7309</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 82 хувь нь эрэгтэй, 18 хувь нь эмэгтэй хүүхдүүд, жонш олборлож буй хүүхдүүдийн 82.8 хувь нь эрэгтэй 17.2 хувь нь эмэгтэй хүүхдүүд байв. Эндээс уурхайн хүнд нөхцөлд эрэгтэй хүүхдүүд илүүтэйгээр хөдөлмөр эрхэлдэг болох нь харагдаж байна.

Албан бусаар алт олборлож байгаа хүүхдүүдийн дунд 13-15 насны хүүхдүүд (47.8 хувь), жонш олборлож байгаа хүүхдүүдийн дунд 16-17 насны хүүхдүүд (40.4 хувь) бусад насны хүүхдүүдтэй харьцуулахад илүүтэйгээр ажиллаж байна. Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн дундаж нас 14.1, жонш олборлож буй хүүхдүүдийн дундаж нас 14.2 байв. Алт олборлогч хүүхдүүдийн хувьд дундаж нас нь хүйсээр онцын ялгаагүй харин жонш олборлогч эмэгтэй хүүхдүүдийн дундаж нас хамгийн бага буюу 12.5 байлаа. Эндээс албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд нь хөдөлмөрийн хуулинд заасан уурхайд хөдөлмөр эрхэлж болох доод наснаас даруй 4 жилийн өмнөөс эхлэн ажиллаж байгаа нь харагдаж байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, сонгогдсон аймгаар Хүснэгт 4.2-т харууллаа.

*᠔ᠵᠢᠢᠶ᠋ᠠᠳ 4.2* Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, түүвэрлэгдсэн аймгаар

Түүвэрлэгдсэн аймаг	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Баянхонгор	48.5	51.5	<b>100.0</b>	-	-	-
Дархан-Уул	91.8	8.2	<b>100.0</b>	-	-	-
Дорноговь	-	-	-	88.3	11.7	<b>100.0</b>
Дундговь	41.7	58.3	<b>100.0</b>	58.2	41.8	<b>100.0</b>
Хэнтий	57.7	42.3	<b>100.0</b>	100.0	0	<b>100.0</b>
Сэлэнгэ	97.2	2.8	<b>100.0</b>	-	-	-
Төв	90.4	9.6	<b>100.0</b>	-	-	-
Өмнөговь	92.4	7.6	<b>100.0</b>	-	-	-
Өвөрхангай	85.2	14.8	<b>100.0</b>	-	-	-
<b>Нийт</b>	<b>82.0</b>	<b>18.0</b>	<b>100.0</b>	<b>82.8</b>	<b>17.2</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>5993</b>	<b>1316</b>	<b>7309</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

Баянхонгор, Дундговь аймгийг эс тооцвол албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн ихэнх хувь нь эрэгтэй хүүхдүүд байв. Хэнтий аймагт гэхэд л албан бусаар жонш олборлож байгаа хүүхдүүд бүгд эрэгтэй хүүхдүүд байна.

#### 4.1.2 Шилжих хөдөлгөөн


Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шилжих хөдөлгөөний байдлыг *ᠶᠠᠶ᠋ᠠᠵᠠᠶᠠᠳᠤ*: төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн, *᠔ᠶ᠋ᠠᠵᠠᠶᠠᠳᠤ*: сүүлийн таван жилийн хөдөлгөөн гэсэн хоёр хэсэг болгон авч үзлээ.

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдэд тухайн судалгаа авсан сумаас өөр аймаг суманд төрсөн хүүхдүүдийг хамруулан тооцсон. Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 38.5 хувь, жонш олборлож буй

хүүхдүүдийн 46.6 хувь нь төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хүүхдүүд нь амьдралынхаа аль нэг хугацаанд төрсөн газраасаа шилжин өөр аймаг, суманд амьдарч байна гэсэн үг юм. Шилжих хөдөлгөөнд оролцсон алт олборлож буй хүүхдүүдийн 78.6 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 80.6 хувь нь эрэгтэй хүүхдүүд байлаа.

Сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийг тооцохдоо түр суугч хүүхдийг хамруулан тооцсон ба эдгээр хүүхдүүдийг *øèèæèã*, тухайн газартаа тав ба түүнээс жил амьдарч байгаа хүүхдүүдийг *øèèæèã- áóñ* гэж шилжих хөдөлгөөний байдлаар нь хоёр ангилж үзэв. Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 27.8 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 19.5 хувь нь сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцсон эдгээр хүүхдүүдэд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь олборлож буй ашигт малтмалын төрөл тус бүрд харгалзан 85.2, 90.3 байлаа. Албан бусаар алт/жоншны олборлож буй хүүхдүүд, тэр дундаа эрэгтэй хүүхдүүд шилжих хөдөлгөөнд багагүй хэмжээгээр оролцдог болох нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна. Үүн дээр зуны амралтаараа ажилладаг хүүхдүүдийг нэмбэл үүнээс ч илүү тоо гарах магадлалтай бөгөөд зуны цагт алт/жоншны уурхайнуудад түр зуурын чанартай шилжих хөдөлгөөн ихэсдэг гэдгийг тооцох хэрэгтэй.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцох болсон шалтгааныг Зураг 4.1-д харууллаа.



Оуи айуэйуэ: \*- “Бусад” гэсэн ангилалд суралцах, зах зээлд ойртох, амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн шалтгаанууд багтсан.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 58.2 хувь нь алт олборлох, 25.5 хувь нь хамаатан саднаа бараадах, 7.4 хувь нь ямар нэгэн ажил эрхлэх, үлдсэн 8.9 хувь нь суралцах, зах зээлд ойртох, амьжиргаагаа дээшлүүлэх зэрэг шалтгаанаар тухайн газарт шилжин иржээ. Алт олборлох зорилгоор шилжин ирсэн эмэгтэй хүүхдүүдийн хувь эрэгтэй хүүхдүүдийнхээс 1 пунктээр, харин



хамаатан саднаа бараадаж ирсэн эрэгтэй хүүхдүүдийн хувь эмэгтэй хүүхдүүдийнхээс 8.1 пунктээр өндөр байна. Харин судалгаанд хамрагдсан албан бусаар жонш олборлож буй эмэгтэй хүүхдүүд 100 хувь хамаатан саднаа бараадах шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцсон бол эрэгтэй хүүхдүүдийн ихэнх хувь нь буюу 65.3 хувь нь жонш олборлох, 9.9 хувь нь хамаатан саднаа бараадах, 16.5 хувь нь ямар нэгэн ажил эрхлэх, үлдсэн 8.3 хувь нь суралцах шалтгаанаар тухайн газарт шилжин иржээ.

Уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь хүүхдийн хөдөлмөрийн олон тэвчишгүй хэлбэрүүдийг өөртөө агуулсан байдаг. Иймээс албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд эцэг эх, хамаатан саднуудынхаа анхаарал халамж, хараа хяналтан дор шилжих хөдөлгөөнд оролцож, ажил эрхэлж байгаа эсэхийг тодруулах нь эдгээр хүүхдүүдийн хувьд нэлээд чухал юм. Шилжих хөдөлгөөнд оролцсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийг олборлож буй ашигт малтмалын төрөл, нас, хамт ирсэн хүмүүсээр Хүснэгт 4.3-д харуулав.

*Өгүүлэл 4.3. Шилжих хөдөлгөөнд оролцсон албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувь, олборлож буй ашигт малтмалын төрөл, нас, хамт ирсэн хүмүүсээр*

Хамт ирсэн хүмүүс	Ашигт малтмалын төрөл							
	Алт				Жонш			
	5-12	13-15	16-17	Нийт	5-12	13-15	16-17	Нийт
Ганцаараа	8.4	0.5	9.8	5.8	0.0	38.5	21.0	17.4
Эцэг эх	91.6	89.8	73.5	83.1	100.0	61.5	41.9	65.2
Ах эгч/Өвөө эмээ	65.7	76.6	62.6	68.8	72.7	23.1	37.1	46.2
Хамаатан	1.2	15.5	3.2	7.8	0.0	0.0	0.0	0.0
Найз (эцэг эхээсээ зөвшөөрөл авсан)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	21.0	9.8
<b>Тооцоолсон шилжигч хүүхдийн тоо</b>	<b>332</b>	<b>822</b>	<b>876</b>	<b>2030</b>	<b>44</b>	<b>26</b>	<b>62</b>	<b>132</b>

*Өгүүлэл 4.3:* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцэхгүй

Судалгаанд хамрагдсан алт олборлож буй хүүхдүүдийн 5.8 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 17.4 хувь нь ганцаараа шилжих хөдөлгөөнд оролцсон ба эдгээр хүүхдүүд нь янз бүрийн насны бүлгийн хүүхэд байна.

Тухайн суманд 5 хүртлэх жил амьдарч байгаа алт олборлож буй хүүхдүүдийн 56.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 80 хувь нь тухайн сумандаа бүртгүүлсэн, харин үлдсэн хүүхдүүд нь бүртгүүлээгүй болон бүртгүүлсэн эсэхээ мэдэхгүй хүүхдүүд байна.

Цаашид тухайн уурхайнхаа орчимд алт олборлож буй хүүхдүүдийн 65.8, жонш олборлож буй хүүхдүүдийн 57.5 хувь нь ажиллаж, амьдарна гэж төлөвлөж байгаа бөгөөд амьдрах хугацаагаа төлөвлөсөн алт олборлож буй хүүхдүүд дунджаар 31 сар, жонш олборлож буй хүүхдүүд дунджаар 49 сар амьдрах бодолтой байгаа юм байна. Харин цаашид тухайн уурхайд ажиллаж, амьдрах бодолгүй байгаа алт олборлож буй хүүхдүүдийн 55.6 хувь нь хэдий хугацааны дараа нүүхээ төлөвлөөгүй байгаа бол 25.3 хувь нь нэг сарын дотор, үлдсэн 24.4 хувь нь хоёр ба түүнээс дээш сарын дараа нүүхээр төлөвлөжээ. Эдгээр хүүхдүүдийн 68.9 хувь нь аймгийн болон сумын төв рүү, 10.9 хувь нь өөр уурхай руу, үлдсэн 28.2 хувь нь нийслэл хот руу шилжих хүсэлтэй байгаагийн зэрэгцээ 18.6 хувь нь ганцаараа, 71.4 хувь нь эцэг, эхтэйгээ шилжихээр

төлөвлөж байгаа ажээ. Жонш олборлож буй хүүхдүүдийн 23.6 хувь нь буюу 6 хүүхэд хэзээ нүүхээ төлөвлөөгүй байхад 53.8 хувь нь нэг сарын дотор, 22.6 хувь нь хоёр ба түүнээс дээш сарын дотор шилжихээр төлөвлөжээ. Эдгээр хүүхдүүдийн 79.1 хувь нь аймгийн болон сумын төв рүү, 4.1 хувь нь өөр уурхай руу, 16.8 хувь нь нийслэл хот руу нүүх хүсэлтэй байгаагийн зэрэгцээ 43.3 хувь нь ганцаараа, 52.9 хувь нь эцэг, эхтэйгээ хамт шилжихээр төлөвлөсөн байна. Шилжих хүсэлтэй байгаа шалтгааны дараалал нь алт, жоншны уурхайд адилхан байсан бөгөөд *í yāāçāyūdò*: суралцах, *ōī, ðāōāāāðò*: алт/жонш олборлохоос өөр ажил эрхлэх, *āōðāāāōāāāðò*: хамаатан саднаа бараадах шалтгаанууд оржээ.

#### 4.1.3 Амьдралын нөхцөл, ар гэрийн байдал

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд маш олон хүчин зүйлс нөлөө үзүүлж байдаг ч энэ удаа зөвхөн хүүхдийн амьдарч буй орчин, хамт амьдарч байгаа хүмүүсийн нөлөөллийн талаар авч үзье. Өөрөөр хэлбэл, тухайн хүүхдийн амьдардаг өрх уурхайн орчимд байгаа тохиолдолд, мөн тухайн хүүхэдтэй хамт амьдарч байгаа өрхийн гишүүд нь алт/жонш олборлож байгаа тохиолдолд хүүхэд алт/жонш олборлох үйл ажиллагаанд илүүтэйгээр татагдан орох магадлалтай юм.

Хүснэгт 4.4-д албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр харуулав.

*Õçîí ýāò 4.4. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Ихэвчлэн амьдардаг газар</b>		
Уурхайн орчимд	34.0	47.5
Тухайн сумын төвд	62.5	46.9
Бусад сум/аймагт	3.5	5.6
<b>Өрх болон уурхайн хоорондох зай (км)</b>		
1 хүртлэх	27.3	30.0
1-14.9	31.0	40.0
15-99.9	36.8	26.1
100 ба түүнээс дээш	2.0	3.9
Мэдэхгүй	2.9	0.0
<b>Дундаж зай</b>	<b>17.0</b>	<b>29.3</b>
<b>Уурхайн орчимд амьдарч байгаа хугацаа (сар)</b>		
1-3	39.6	59.1
4-36	36.3	21.4
37 ба түүнээс дээш	24.1	19.5
<b>Дундаж хугацаа</b>	<b>29.2</b>	<b>25.8</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>7309</b>	<b>687</b>

Ерөнхийдөө алт олборлож буй хүүхдүүдийн 34 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 47.5 хувь нь жилийн ихэнх хугацаанд алт/жонш олборлодог тухайн уурхайнхаа орчимд амьдардаг бол алт олборлож буй хүүхдүүдийн 62.5 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 46.9 хувь нь тухайн уурхайн харьяалагддаг суманд амьдардаг байна. Тухайн хүүхдийн амьдарч байгаа

өрхөөс уурхай хүртлэх дундаж зай алт олборлож буй хүүхдүүдийн хувьд 17 км, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 29.3 км байна. Дундаж зай ийнхүү өндөр гарч байгаад өөр аймаг, сумаас түр хугацаагаар шилжин ирсэн хүүхдүүдийн байнга амьдардаг газраас уурхай хүртлэх зай их байгаа нь нөлөөлжээ. Тухайлбал, албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдийн амьдарч байгаа өрх болон уурхай хүртлэх зай хамгийн ихдээ олборлож буй ашигт малтмалын төрөл тус бүрд харгалзан 450, 800 километр байна.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 24.1 хувь нь, жонш олборлож буй хүүхдүүдийн 19.5 хувь нь уурхайн орчимд 3 ба түүнээс дээш жил амьдарч байгаа ба алт олборлож буй хүүхдүүдийн уурхайн орчимд амьдарч байгаа дундаж хугацаа 29 сар, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 26 сар байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн амьдарч буй өрхөөс 5-17 насны 1-2 хүүхэд (тухайн хүүхэд өөрөө ороод), насанд хүрсэн хоёр хүн дунджаар алт/жоншны уурхайд албан бусаар ажилладаг байна. Албан бусаар алт/жонш олборлож буй уурхайд нэг өрхөөс хамгийн ихдээ 5 хүүхэд, 7 насанд хүрэгчид ажиллаж байна.

#### ***Уурхайн орчимд амьдардаг хүүхдүүдийн ахуйн нөхцөл***

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тал орчим хувь нь жилийн ихэнх хугацаанд уурхайн орчимд амьдардаг тухай дээр дурдсан билээ. Тэгвэл эдгээр хүүхдүүд нь ямар нөхцөл байдалд амьдарч байгааг олборлож буй ашигт малтмалын төрлөөр Хүснэгт 4.5-д харууллаа.

Уурхайн орчимд амьдардаг алт олборлож буй хүүхдүүд дунджаар 4-5 хүнтэй өрхөд (тухайн хүүхэд өөрөө ороод) амьдардаг бөгөөд ам бүлийн гишүүдийн хоёр нь 18-аас доош насны хүүхдүүд байна. Харин жонш олборлож буй хүүхдүүд дунджаар 5-6 хүнтэй өрхөд амьдардаг бөгөөд эдгээр ам бүлийн гишүүдийн 2-3 нь 18-аас доош насны хүүхдүүд байна.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн дийлэнх хувь нь (80.1 хувь) гэрт амьдардаг, харин жонш олборлож буй хүүхдүүдийн 57.7 хувь нь гэрт, 26.1 хувь нь сууцны тусдаа байшинд амьдардаг байна. Албан бусаар ажиллаж байгаа хүүхдүүдийн багагүй хувь нь (алт олборлогч хүүхдүүдийн 19 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 16.3 хувь) сууцны зориулалтын бус байранд тухайлбал, майхан, урц, овоохой, дугуйнцаг, түүнчлэн машинд амьдарч байна.

Алт олборлож буй хүүхдүүдийн 80.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 59.8 хувь нь өөрийн болон эцэг, эхийн эзэмшлийн сууцанд амьдардаг ба үлдсэн хувь нь бусдын сууцанд төлбөргүй амьдардаг ажээ.

Уурхайн орчимд амьдардаг өрхийн ихэнх хувь нь лаа хэрэглэдэг болох нь алт олборлож буй хүүхдүүдийн 91.2 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 70.8 хувь нь лаа хэрэглэдэг гэж хариулснаас харагдаж байгаа юм. Жонш олборлож буй хүүхдүүдийн 18.8 хувь нь төвлөрсөн цахилгаан хангамжтай өрхөд амьдардаг гэсэн үр дүн гарчээ. Энэ нь жонш олборлож байгаа зарим газар, тодруулбал, Хэнтий аймгийн Бор-Өндөр багт дэд бүтэц сайн хөгжсөн, хуучин ашиглаж байсан уурхайнууд цөөнгүй байсан учир цахилгааны хэрэглээ өндөр гарахад нөлөөлсөн.

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ* 4.5 Уурхайн орчимд амьдардаг албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Сууцны төрөл</b>		
Гэр	80.1	57.7
Сууцны тусдаа байшин	0.9	26.1
Урц/овоохой/дугуйнцаг*/машин	3.0	4.0
Майхан	16.0	12.3
<b>Сууцны эзэмшил</b>		
Өөрийн/эцэг, эхийн эзэмшлийн	80.4	59.8
Бусдын сууцанд төлбөргүй сууж байгаа	19.6	40.2
<b>Сууцны гэрэлтүүлгийн төрөл</b>		
Төвлөрсөн цахилгаан хангамж	1.1	18.8
Төвлөрсөн бус цахилгаан хангамж	1.7	0.0
Мотор	4.8	3.0
Лаа	91.2	70.8
Гэрэлтүүлэг хэрэглэдэггүй	1.2	7.4
<b>Ундны усны эх үүсвэр</b>		
Хамгаалалттай худаг	7.4	28.8
Хамгаалалтгүй худаг	31.4	60.1
Гол/булаг/рашаан	57.1	9.2
Тогтоол ус	4.1	1.9
<b>Ундны ус хүртлэх зай (метр)</b>		
100 хүртлэх	23.7	23.6
101-499	31.2	17.2
500-1999	26.0	22.7
2000 ба түүнээс дээш	19.1	36.5
<b>Дундаж зай</b>	<b>941.0</b>	<b>2013.3</b>
<b>Сууцны ойролцоо зориулалтын бие засах газар байдаг эсэх</b>		
Тийм	5.1	38.3
Үгүй	94.9	61.7
<b>Сууцны ойролцоо зориулалтын хог, хаягдал хаях газар байдаг эсэх</b>		
Тийм	4.0	20.9
Үгүй	96.0	79.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон уурхайн орчимд амьдардаг хүүхдийн тоо</b>	<b>2504</b>	<b>326</b>

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ*: \*-Монгол гэрийн хэв шинжийг агуулсан боловч зарим иж бүрдэл нь дутуу сууцыг хэлнэ;

Цэвэр усны хүртээмжийг тооцдог хэмжүүр нь ундны усны эх үүсвэрийг тодруулах явдал юм. Уурхайн орчимд амьдарч байгаа алт олборлож буй хүүхдүүдийн дөнгөж 7.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 28.8 хувь нь л хамгаалалттай худгийн усыг ундандаа хэрэглэдэг гэжээ. Түүгээр ч үл барам тогтоол усыг ундандаа хэрэглэдэг гэсэн хариулт багагүй байлаа. Тухайн хүүхдийн амьдарч байгаа өрхөөс ундны ус хүртлэх дундаж зай алт олборлож буй хүүхдүүдийн хувьд 1, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 2.1 километр гарсан.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд эрүүл ахуйн хангалтгүй орчин, нөхцөлд амьдарч байгаа нь эдгээр хүүхдүүдийн ихэнх хувь нь (алт олборлогч хүүхдүүдийн 96 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 79.1) сууцны ойролцоо зориулалтын бие засах газаргүй, зориулалтын хог, хаягдал хаях газаргүй (алт

олборлогч хүүхдүүдийн 94.9 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 61.7 хувь) өрхөд амьдарч байгаагаас харагдаж байна.

### *Асран хамгаалагчийн хараа, хяналт*


Уурхайд ажиллаж байгаа хүүхдэд уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, тэдний ирээдүйн талаарх эцэг, эхийн үзэл бодол, хандлага нэн чухлын зэрэгцээ эцэг, эхийн хараа, хяналт ч мөн чухал юм. Энэ талаар дараагийн бүлэгтээ дэлгэрэнгүй авч үзэх учраас эцэг, эхийн хараа хяналтын зарим үзүүлэлтүүдийг энд авч үзье.

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт олборлож буй хүүхдүүдэд эцэг, эх нь хоёулаа амьд байгаа хүүхдийн эзлэх хувь 77.5, харин эцэг нь нас барсан хүүхдийн эзлэх хувь 19.4, эх нь нас барсан хүүхдийн эзлэх хувь 1.9, эцэг, эх нь хоёулаа нас барсан буюу бүтэн өнчин хүүхдийн эзлэх хувь 1.2 байна. Харин жонш олборлож буй хүүхдүүдэд эцэг, эх хоёулаа амьд байгаа хүүхдийн эзлэх хувь 84.4, эцэг нь нас барсан хүүхдийн эзлэх хувь 9.2, эх нь нас барсан хүүхдийн эзлэх хувь 4.5, эцэг, эх нь хоёулаа нас барсан хүүхдийн эзлэх хувь 1.9 байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, шилжих хөдөлгөөний байдлаар Зураг 4.2-д харууллаа.

Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг шилжигч бус хүүхдүүдийн эзлэх хувь шилжигч хүүхдүүдтэй харьцуулахад алт олборлогч хүүхдүүдийн хувьд 8.5 пунктээр, жонш олборлогч хүүхдүүдийн хувьд 10.3 пунктээр тус тус өндөр байна.

Эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй алт/жонш олборлож буй хүүхдүүдийн 43.7 хувь нь өвөө, эмээ, төрсөн ах, эгчийндээ, 27.7 хувь нь хамаатан айлдаа, 25.9 хувь нь танил айлдаа, үлдсэн 2.7 хувь нь ажил олгогч айлдаа амьдарч байна.



Түүнчлэн тухайн ажлыг хийж эхэлснээс хойш гэр бүлийнхэнтэйгээ хэрхэн, харилцаж холбоо барьж байгааг тодруулахад албан бусаар алт олборлож буй түр суугч хүүхдүүдийн 52.7 хувь нь гэртээ очдог, 15.3 хувь нь гэр бүлийн гишүүдтэйгээ хамт ажилладаг, 12.3 хувь нь ямар ч холбоогүй байдаг, үлдсэн хувь нь гэрээс нь хүн ирдэг, утсаар ярих болон хэл дуулгадаг гэсэн хариултыг өгчээ. Харин жонш олборлож буй түр шилжигч хүүхдүүдийн 50.7 хувь нь ямарч холбоогүй байдаг, 17.8 хувь нь гэртээ очдог, 13.7 хувь нь утсаар ярьдаг, 17.8 хувь нь гэр бүлийн гишүүдтэйгээ хамт ажилладаг гэсэн хариулт өгсөн байна.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг бичиг баримтын бүрдэл болон сонгосон үзүүлэлтүүдээр Хүснэгт 4.6-д харуулав. Жонш олборлож буй хүүхдүүдийн бичиг баримтын бүрдэл харьцангуй сайн, бичиг баримтгүй хүүхдийн тоо бага байсан учраас хүснэгтээр харуулаагүй болно. Алт олборлож буй хүүхдүүдийн 88.9 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхтэй, 77.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй, үлдсэн хувь нь байхгүй, мэдэхгүй гэж хариулжээ. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн 95.5 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхтэй, 89.7 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй байлаа.

*Өгүүлэл 4.6.* Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, бичиг баримтын бүрдэл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Төрсний гэрчилгээ/ Иргэний үнэмлэх*			Эрүүл мэндийн даатгалын дэвтэр			Бүгд	Тооцоолсон алт олборлож буй хүүхдийн тоо
	Байгаа	Байхгүй	МГ**	Байгаа	Байхгүй	МГ		
<b>Насны бүлэг</b>								
5-12	88.2	10.8	1.0	75.7	19.8	4.5	<b>100.0</b>	<b>1567</b>
13-15	87.3	9.7	3.0	77.0	13.8	9.2	<b>100.0</b>	<b>3489</b>
16-17	91.8	8.2	0.0	80.3	18.5	1.2	<b>100.0</b>	<b>2253</b>
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	88.7	9.3	2.0	75.7	17.4	6.9	<b>100.0</b>	<b>5993</b>
Эмэгтэй	89.8	10.2	0.0	87.4	12.6	0.0	<b>100.0</b>	<b>1316</b>
<b>Шилжих хөдөлгөөний байдал</b>								
Шилжигч	83.7	14.9	1.4	60.9	34.9	4.2	<b>100.0</b>	<b>2030</b>
Шилжигч бус	90.9	7.4	1.7	87.5	9.8	2.7	<b>100.0</b>	<b>5279</b>
<b>Эцэг, эхийн байдал</b>								
Эцэг, эх нь хоёулаа амьд	88.3	9.6	2.1	78.3	15.3	6.4	<b>100.0</b>	<b>5666</b>
Эцэг, эхийн аль 1 нь амьд	90.6	9.4	0.0	75.0	21.6	3.4	<b>100.0</b>	<b>1558</b>
Хоёулаа нас барсан	100.0	0.0	0.0	90.6	9.4	0.0	<b>100.0</b>	<b>85</b>
<b>Нийт</b>	<b>88.9</b>	<b>9.5</b>	<b>1.6</b>	<b>77.8</b>	<b>16.5</b>	<b>5.7</b>	<b>100.0</b>	<b>7309</b>

*Өгүүлэл 4.6:* \*-16 ба түүнээс дээш настай хүүхдээс иргэний үнэмлэхтэй эсэхийг асуусан

\*\* - Мэдэхгүй

Шилжигч бус хүүхдүүдийн бичиг баримтын бүрдлийн хувь шилжигч хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байсан хэдий ч эдгээр хүүхдүүдийн бичиг баримтын бүрдлийн хувь ялангуяа эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй хүүхдүүдийн эзлэх хувь мөн өндөр байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд 16 хүртлэх насны бүх хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг төр хариуцна гэж заасан байдаг ч эцэг, эхийн хариуцлагагүйгээс шилжигч

хүүхдүүдийн 34.9 хувь, шилжигч бус хүүхдийн 9.8 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байна.

Энэ байдал нь эдгээр хүүхдүүдийн хувьд асар их эрсдлийг дагуулж байгаа юм. Иймээс холбогдох байгууллагууд болон хүүхдийн эцэг, эхийн зүгээс бичиг баримтжуулах ажилд анхаарал тавин ажиллах хэрэгтэй байна.

#### 4.1.4 Сургуульд хамрагдалт ба бичиг үсгийн мэдлэг

Хэдийгээр манай улс бичиг үсэг тайлагдалтын түвшнээрээ дэлхийд дээгүүрт ордог, бүх нийтээрээ бичиг үсэгтэн болох уриа тавьсан ч сүүлийн жилүүдэд энэ амжилтаа төдийлөн хадгалж чадахгүй байна.

Судалгаанд хамрагдсан уншиж, бичиж чаддаггүй албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийг олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр Хүснэгт 4.7-д харуулав.

*Өгүүлэл 4.7* Уншиж, бичиж чаддаггүй албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувь, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл			
	Алт		Жонш	
	Уншиж чаддаггүй хүүхдүүдийн хувь	Бичиж чаддаггүй хүүхдүүдийн хувь	Уншиж чаддаггүй хүүхдүүдийн хувь	Бичиж чаддаггүй хүүхдүүдийн хувь
<b>Нас</b>				
5-12	25.5	25.5	7.9	7.9
13-15	13.4	14.3	0.0	0.0
16-17	9.3	9.9	13.3	13.3
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	15.1	15.3	6.5	6.5
Эмэгтэй	12.8	15.4	11.0	11.0
<b>Аймаг</b>				
Баянхонгор	10.6	13.1	-	-
Дархан-Уул	12.7	12.7	-	-
Дорноговь	-	-	14.2	14.2
Дундговь	0.0	0.0	0.0	0.0
Хэнтий	8.1	8.0	0.0	0.0
Сэлэнгэ	2.7	2.7	-	-
Төв	19.5	22.9	-	-
Өмнөговь	17.5	17.5	-	-
Өвөрхангай	42.2	42.2	-	-
<b>Нийт</b>	<b>14.7</b>	<b>15.4</b>	<b>7.3</b>	<b>7.3</b>
<b>Тооцоолсон уншиж, бичиж чаддаггүй хүүхдийн тоо</b>	<b>1075</b>	<b>1122</b>	<b>50</b>	<b>50</b>

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 14.7 хувь нь уншиж чаддаггүй, 15.4 хувь нь бичиж чаддаггүй хүүхдүүд байв. Жонш олборлож буй хүүхдүүдийн 7.3 хувь нь уншиж, бичиж чаддаггүй байна. Гэхдээ энд 7 ба түүнээс доош насны хүүхдүүд судалгаанд хамрагдсан гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Тиймээс 7 ба түүнээс дээш насны хүүхдүүдэд уншиж, бичиж чаддаггүй хүүхдийн эзлэх

хувийг тооцож үзэхэд алт олборлодог 7 хүүхэд тутмын нэг нь уншиж, бичиж чадахгүй, жонш олборлодог 15 хүүхэд тутмын нэг нь уншиж, бичиж чаддаггүй хүүхдүүд байлаа.

Төв, Өвөрхангай, Өмнөговь зэрэг алтны гарц сайтай аймгуудад алт олборлодог хүүхдүүдийн дунд уншиж, бичиж чаддаггүй хүүхдийн эзлэх хувь бусад аймагтай харьцуулахад өндөр байна.

Нэг талаас сургуульд сурах боломж, нөхцөл хязгаарлагдмал байх нь хүүхдийг хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлдөг байхад нөгөө талаас хүүхдийн хөдөлмөр нь хүүхдийн зайлшгүй боловсрол эзэмших боломжийг хаагдуулдаг байна.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг сургуульд суралцдаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр Хүснэгт 4.8-д харуулав.

Үндсэн хуулинд Монгол улсын иргэн сурч боловсрох эрхтэй гэж заасан байдаг боловч зайлшгүй сургуульд суралцах ёстой 7-15 насны алт олборлож буй хүүхдүүдийн 24.6 хувь нь, жонш олборлож буй хүүхдүүдийн 10.8 хувь нь сургуульд сурахгүй байна. Сургуульд сурахгүй байгаа эдгээр хүүхдүүдийн зэрэгцээ алт олборлож буй хүүхдүүдийн 1.9 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 3.9 хувь нь албан бус сургалтад хамрагддаг байна. Насны бүлгээр авч үзэхэд, 16-17 насны хүүхдүүдийн дунд сургуульд сурахгүй байгаа хүүхдийн эзлэх хувь хамгийн өндөр байлаа.

*᠋ᠣᠯᠢᠭᠠᠳᠤ* 4.8. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, сургуульд суралцдаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл						Бүгд
	Алт			Жонш			
	Сургуульд сурдаг	Албан бус сургалтад	Сурдаггүй	Сургуульд сурдаг	Албан бус сургалтад	Сурдаггүй	
<b>Нас</b>							
5-12	69.9	4.3	25.8	92.1	0.0	7.9	<b>100.0</b>
13-15	71.8	2.1	26.1	76.1	11.1	12.8	<b>100.0</b>
16-17	51.0	0.0	49.0	60.4	0.0	39.6	<b>100.0</b>
<b>Хүйс</b>							
Эрэгтэй	62.6	2.1	35.3	73.4	4.8	21.8	<b>100.0</b>
Эмэгтэй	75.7	1.1	23.2	74.6	0.0	25.4	<b>100.0</b>
<b>Шилжих хөдөлгөөний байдал</b>							
Шилжигч	34.3	0.5	65.2	37.0	0.0	63.0	<b>100.0</b>
Шилжигч бус	76.8	2.4	20.8	82.4	4.9	12.7	<b>100.0</b>
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>							
Хоёулантэй нь хамт	70.8	0.3	28.9	81.6	2.7	15.7	<b>100.0</b>
Хэн нэгтэй нь	53.2	3.2	43.6	66.2	9.7	24.1	<b>100.0</b>
Хамт амьдардаггүй/ өнчин	49.2	11.4	39.4	42.5	0.0	57.5	<b>100.0</b>
<b>Нийт</b>	<b>65.0</b>	<b>1.9</b>	<b>33.1</b>	<b>73.7</b>	<b>3.9</b>	<b>22.4</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>4752</b>	<b>139</b>	<b>2418</b>	<b>506</b>	<b>27</b>	<b>154</b>	




Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн сургуульд завсардалтын хувь ашигт малтмалын төрөл тус бүрд өндөр байна. Тодруулбал, алт олборлож буй шилжигч хүүхдүүдийн сургуульд сурахгүй байгаа хувь шилжигч бус хүүхдүүдийнхтэй харьцуулахад 3 дахин их, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 5 дахин их байлаа. Эндээс шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн хувьд боловсролын хүртээмж хангалтгүй, цаашид анхаарал хандуулах ёстой хурцадмал асуудал гэдэг нь харагдаж байна.

Сургуульд сурахгүй байгаа эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй/өнчин хүүхдүүдийн хувь хэн нэгтэй нь хамт амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад (жонш олборлогч хүүхдүүдийн хувьд 33.4 пунктээр) өндөр, харин эцэг, эхийнхээ хэн нэгтэй амьдардаг хүүхдийн сургууль завсардсан хувийг хоёулантай нь хамт амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад (алт олборлогч хүүхдүүдийн хувьд 14.7 пунктээр, жонш олборлогч хүүхдүүдийн хувьд 8.4 пунктээр) өндөр байлаа.

Сургуульд сурдаг албан бусаар олг олборлож буй хүүхдүүд дунджаар 7-р ангид сурч байхад жонш олборлож буй хүүхдүүд дунджаар 6-7 ангид сурч байна. Сургуульд сурч байгаа эдгээр хүүхдүүд өнгөрсөн жил ямар дүнтэй суралцсаныг олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр Зураг 4.3-д харуулав.

Хүүхдүүдийн мэдүүлж байгаагаар тэдний дийлэнх нь өнгөрсөн хичээлийн жилд В, С үнэлгээтэй суралцсан байна. Хүйсийн хувьд авч үзвэл, охид хөвгүүдээс илүү амжилттай суралцдаг нь харагдаж байна. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн дунд D буюу хангалтгүй сурч байгаа хүүхдүүдийн хувь бага биш байна. Эндээс хүүхдийн хөдөлмөр эрхлэлт тэдний сурах идэвх сонирхолд сэргээр нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.



Алт, жоншны албан бус уурхайд ажиллаж байгаа хүүхдийн сургуульд сурахгүй байгаа шалтгаан нь эцэг, эхтэйгээ хамт амьдарч байгаа эсэхээс ихээхэн хамаарч байна (Хүснэгт 4.9). Тухайлбал, эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй алт, жонш олборлох шалтгаанаар сургуульд сурахгүй байгаа хүүхдүүдийг эцэг, эхтэйгээ хамт амьдарч байгаа хүүхдүүдтэй харьцуулахад алт олборлож буй хүүхдүүдийн хувьд 3.2, жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд 23.7 пунктээр тус тус өндөр байлаа. Түүнчлэн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй сурлага тааруу шалтгаанаар сургуульд сурахгүй байгаа хүүхдүүдийн хувь эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүдийнхээс өндөр байв. Харин эсрэгээр ар гэрийн гачигдлаар (эдийн засгийн бус шалтгаан) сургуульд сурахгүй байгаа хүүхдийн эзлэх хувь эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүдийнхээс өндөр байв. Амьжиргааны доод түвшин, ар гэрийн гачигдалтай байдал нь хүүхэд хөдөлмөр эрхлэх гол шалтгаан болж байна.

**Өгүүлэл 4.9. Сургуульд сурахгүй байгаа албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувь, суралцахгүй байгаа шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл, эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэхээр**

Суралцахгүй байгаа шалтгаан	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг	Хамт амьдардаггүй/Өнчин	Нийт	Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг	Хамт амьдардаггүй/Өнчин	Нийт
Сурлага тааруу	20.0	30.9	21.0	5.7	26.7	11.9
Алт/жонш олборлодог	30.3	33.5	30.9	27.4	51.1	34.4
Мөнгөний боломжгүй	22.0	19.5	21.8	28.3	0.0	19.9
Ар гэрийн гачигдал	34.2	15.5	32.4	51.9	26.7	44.4
Бүртгэлгүй/бичиг баримтгүй	5.3	13.7	6.1	12.3	22.2	15.2
Эүүл мэндийн шалтгаан	11.4	0.0	10.3	11.3	0.0	7.9
Өр ажил эрхэлдэг	5.7	10.3	6.1	12.3	0.0	8.6
Бусад*	9.0	17.6	14.8	9.4	22.2	13.2
<b>Судалгаанд хамрагдсан сургуульд сурахгүй байгаа хүүхдийн тоо</b>	<b>2186</b>	<b>232</b>	<b>2418</b>	<b>108</b>	<b>46</b>	<b>154</b>

Өгүүлэл 4.9-ийн үүднээс: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцэхгүй

\*- "Бусад" гэсэн ангилалд сургуульд сурах шаардлагагүй, нас нь болоогүй, сургуулиас хол анги дүүргэлт хэтэрсэн, багш загнадаг зэрэг шалтгаанууд багтсан.

## 4.2 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт

Судалгааны энэхүү хэсэгт албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн анхны болон одоогийн ажил эрхлэлт, ажил хийх болсон шалтгаан, хийдэг ажлын төрөл, ажлыг хийх явцдаа түгээмэл хэрэглэдэг багаж, хэрэгслүүд, ажлын нөхцөл, сарын олборлолтын хэмжээ ба олдог орлого, ажлын цагийн үргэлжлэх хугацаа ба амралтын талаар дэлгэрэнгүй авч үзнэ.

## 4.2.1 Өнгөрсөн үеийн ажил эрхлэлт


### Анхны ажил эрхлэлт

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд дунджаар 12 насандаа анх өрхөөс гадуур хөдөлмөр эрхэлж эхэлсэн байна. Одоогийн эрхэлж байгаа ажил нь тэдний анхны ажил мөн гэж алт олборлож буй хүүхдүүдийн 73.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 86 хувь нь хариулжээ. Эмэгтэй хүүхдүүдийн хийж эхэлсэн анхны ажил нь албан бус уурхайд алт/жонш олборлох ажил байсан нь алт олборлож буй охидын 92.8 хувь, жонш олборлож буй охидын 100 хувь анхны ажил мөн гэж хариулснаас харагдаж байна. Иймээс охидын анх хийж эхэлсэн ажлын талаар дурьдахгүйгээр, харин эрэгтэй хүүхдүүдийн анх хийж эхэлсэн ажлын талаар товч авч үзье.

Өмнө нь өөр ажил хийж байсан албан бусаар алт/жонш олборлож буй хөвгүүдийн хувийн жинг хийж эхэлсэн анхны ажил, олборлож буй ашигт малтмалын төрлөөр Зураг 4.4-д харууллаа.

Алт олборлож буй хөвгүүдийн 18.1 хувь нь мал маллах, 14.8 хувь нь гэрийн үйлчлэгчийн ажил, 15 хувь нь ямар нэг байгууллагад, 10.4 хувь нь гудамжинд бараа худалдаалах 38.6 хувь нь мод, нүүрс, төмөр, металл цуглуулж зарах ажлуудыг голчлон хийдэг байсан бол жонш олборлож буй хөвгүүдийн 82.3 хувь нь мал маллах, 17.7 хувь нь төмөр, металл цуглуулж зарах ажлуудыг голчлон хийдэг байжээ.

Өмнө нь өөр ажил хийж байсан алт/жонш олборлож буй хүүхдүүд дунджаар хоёр удаа ажлаа сольж байсан ба хамгийн ихдээ гэхэд таван удаа ажлаа сольж байжээ.



Өүгү айяаёуё: \*- машин харах/угаах, хурдны морь унах, янз бүрийн юм хийж зарах зэрэг ажлууд орсон


### Ажил эрхлэлтийн өнгөрсөн үеийн байдал

Өмнө нь алт, жонш олборлож буй хүүхдүүдийн анх өрхөөс гадуур хөдөлмөр эрхэлж эхэлсэн насыг дурьдсан бол одоо алт, жоншны уурхайд ажиллаж эхэлсэн насыг авч үзье. Алт/жонш олборлож буй хүүхдүүд тухайн уурхайдаа дунджаар 12-13 насандаа ажиллаж эхэлсэн байна.

Алт олборлож буй хүүхдүүдийн 12.8 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 9.6 хувь нь өмнө нь өөр төрлийн уурхайд ажиллаж байжээ. Тодруулбал, алт олборлогч хүүхдүүд өмнө нь нүүрс, цагаан тугалганы уурхайд ажиллаж байжээ.

Одоогийн ажиллаж байгаа уурхайтай нь ижил төрөлтэй боловч байршлын хувьд өөр уурхайд ажиллаж байсан эсэхийг тодруулахад алт олборлож буй хүүхдүүдийн 32.1 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 19.1 хувь нь “*òéèì*” гэсэн хариултыг өгчээ. Хүйсийн хувьд, эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад ажиллаж буй уурхайнхаа байршлыг илүү өөрчилсөн байна. Алт олборлож буй хүүхдүүд дунджаар 2-3 уурхайд ажиллаж байсан бол жоншны уурхайд ажиллаж байгаа хүүхдүүд дунджаар 3 уурхайд ажиллаж байжээ.

Ажиллаж байсан уурхайгаа сольсон эдгээр хүүхдүүдийн хувийн жинг уурхайгаа солих болсон шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрлөөр Зураг 4.5а, Зураг 4.5б-д харууллаа.



Өүг айаае: \*- Эцэг, эх болон гэр бүлийн гишүүдээ даган  
\*\*- сургуулиас хол, ажил олгогч бага цалин хөлс өгдөг, ажлын нөхцөл хүнд байсан зэрэг шалтгаанууд орсон


Ажиллаж байсан уурхайгаа сольсон алт олборлож буй хүүхдүүдийн дийлэнх нь буюу 89.9 хувь нь, жонш олборлож буй хүүхдүүдийн 79.5 хувь нь уурхайн гарц муудсан учраас уурхайгаа сольсон байна.

### 4.2.2 Одоогийн ажил эрхлэлт

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгааныг тодруулах нь судалгааны хамгийн гол зорилтуудын нэг байсан. Иймд албан бусаар алт, жонш олборлож буй

хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгааныг олборлож ашигт малтмалын төрөл, хүйсээр Зураг 4.6-д харууллаа.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон гол шалтгаануудад өрхийн орлогоо нэмэгдүүлэх, өөрийн гэсэн мөнгөтэй болох, эцэг, эх ажилгүй, ажлын туршлагатай болох гэсэн шалтгаанууд нэлээд хувийг эзэлж байна. Үүний зэрэгцээгээр алт олборлож буй хүүхдүүдийн 18.5 хувь нь сургууль завсардсан учраас ажиллах болсон гэжээ. Алт олборлож буй хүүхдүүдийн 12.5 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 16.7 хувь нь эцэг, эхийн шахалтаас уурхайд хөдөлмөр эрхэлж байна гэж хариулсан тохиолдлыг энд онцлон дурьдах нь зүйтэй болов уу.



*Өүг аүггүү:* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцэхгүй  
 \*- сургалттай холбоотой мөнгөө олж авдаг, ар гэрийн гачигдал, харж хандах хүнгүй учир, өөрийн сонирхлоороо гэсэн шалтгаанууд орсон ба дийлэнх хувийг нь өөрийн сонирхлоороо гэсэн шалтгаан эзэлж байв

Зарим эцэг, эхчүүд бидний хойч ирээдүй болсон хүүхдээ сургуулиас гарган, цөөн хэдэн төгрөгний төлөө өөрсдийн эрх ашигтаа нийцүүлэн тэдний балчир биеийг уурхайн хүнд хүчир ажилд дайчилж байгаа нь үнэхээр харамсалтай.



уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд эцэг, эхчүүд ихээхэн нөлөөлдөг болохыг дахин харуулж байна.

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ* 4.10. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувь, хамтран ажилладаг хүмүүс, олборлож буй ашигт малтмалын төрөл, насаар

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл							
	Алт				Жонш			
	5-12	13-15	16-17	Нийт	5-12	13-15	16-17	Нийт
<b>Ихэвчлэн хэнтэй хамт ажилладаг</b>								
Ганцаараа	0.0	1.0	9.1	3.3	0.0	9.9	0.0	3.5
Эцэг эх/ гэр бүлийн гишүүд	84.3	65.7	57.9	67.3	90.9	65.8	53.8	67.0
Хамаатан садан	20.2	24.8	12.2	21.2	23.6	24.8	34.3	29.6
Найз нөхөд	12.3	29.1	33.7	27.6	3.6	14.0	28.2	17.2
Танил хүмүүс	15.3	19.9	13.2	16.9	3.6	6.6	20.2	11.4
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>1567</b>	<b>3489</b>	<b>2253</b>	<b>7309</b>	<b>165</b>	<b>244</b>	<b>278</b>	<b>687</b>

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ*: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцэхгүй

Хүснэгт 4.11-д албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг уурхайд хийдэг ажлууд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр харуулав.

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ* 4.11. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, уурхайд хийдэг ажлууд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Уурхайд хийдэг ажлууд	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Тийм	Үгүй	Бүгд	Тийм	Үгүй	Бүгд
Нүх малгах/шороо ухах	71.5	28.5	<b>100.0</b>	65.2	34.8	<b>100.0</b>
Ус/шороо зөөх	92.5	7.5	<b>100.0</b>	76.1	23.9	<b>100.0</b>
Шороо шигших	62.2	37.8	<b>100.0</b>	13.2	86.8	<b>100.0</b>
Чулуу/хүдэр зөөх	23.5	76.5	<b>100.0</b>	67.5	32.5	<b>100.0</b>
Хүдэр/чулуу/жонш бутлах	19.1	80.9	<b>100.0</b>	60.7	39.3	<b>100.0</b>
Алт/жонш ухах	74.5	25.5	<b>100.0</b>	62.7	37.3	<b>100.0</b>
Алт угаах <sup>1</sup>	85.6	14.4	<b>100.0</b>	-	-	-
Мөнгөн ус олборлох <sup>1</sup>	7.0	93.0	<b>100.0</b>	-	-	-
Мөнгөн усаар алт бариулах <sup>1</sup>	14.2	85.8	<b>100.0</b>	-	-	-
Жонш кублэх <sup>2</sup>	-	-	-	43.4	56.6	<b>100.0</b>
Хүдэр өрөмдөх <sup>1</sup>	3.6	96.4	<b>100.0</b>	-	-	-
Компрессор/помп/дамнуургат татлага ажиллуулах	20.7	79.3	<b>100.0</b>	8.0	92.0	<b>100.0</b>
Тэсэлгээ хийх	5.1	94.9	<b>100.0</b>	8.1	91.9	<b>100.0</b>
Улны ус шавхах	31.9	68.1	<b>100.0</b>	0.0	100.0	<b>100.0</b>
Шлюндэх	21.9	78.1	<b>100.0</b>	1.9	98.1	<b>100.0</b>

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ*: <sup>1</sup>Зөвхөн алт олборлох үйл ажиллагаанд хамаарна;

<sup>2</sup>Зөвхөн жонш олборлох үйл ажиллагаанд хамаарна;

Алт олборлож буй хүүхдүүдийн хамгийн их хийдэг ажлуудад ус, шороо зөөх, алт угаах, алт ухах, нүх малгах, шороо зөөх, шороо шигших ажлууд ордог байна. Үүний зэрэгцээгээр эдгээр хүүхдүүд мөнгөн ус олборлох, мөнгөн усаар алт бариулах, тэсэлгээ хийх зэрэг аюултай бодис, химийн урвалтай харьцдаг ажлуудыг тодорхой хэмжээгээр хийдэг болох нь харагдлаа.

Алт угаахдаа олон цагаар усан дотор зогсож ажиллахын зэрэгцээ өөрийн биеэ мөнгөн усаар хордуулж байгаа хүүхдүүдийн жишээ цөөнгүй байгаа билээ.

Жонш олборлож буй хүүхдүүдийн хамгийн их хийдэг ажлуудад шороо зөөх, нүх малгах, жонш зөөх, хүдэр чулуу зөөх, хүдэр/чулуу/жонш бутлах, жонш ухах, жонш зөөх зэрэг жонш олборлох үйл ажиллагаатай холбоотой бүхий л ажлуудыг хийж байна. Хүйсийн хувьд, тухайн ажлын хүнд, хөнгөнөөс хамааран бага зэрэг ялгаатай байв. Жонш олборлож буй хүүхдүүдийн 8.1 хувь нь тэсэрч дэлбэрэх аюултай бодистой харьцдаг ажлыг хийдэг гэжээ. Алт/жонш олборлож буй хүүхдүүд эдгээр ажлуудыг хийхдээ ямар багаж хэрэгслүүд ашигладаг болохыг Хүснэгт 4.12-д харууллаа.

Хүрз, шуудай, хуванцар түмпэн, хувин гэх мэт уурхайн хөдөлмөрт өргөн хэрэглэгддэг хамгийн энгийн багаж хэрэгслүүдийг байнга ашигладаг хүүхдүүдийн хувь харьцангуй өндөр байв. Нөгөөтэйгүүр аюултай хурц үзүүртэй багаж хэрэгсэл тухайлбал, осков, лоом, жоотуу байнга ашигладаг хүүхдүүдийн хувь ч багагүй байна. Цаашилбал алт олборлож буй хүүхдүүдийн 5.9 хувь нь мөнгөн усыг өдөр тутмын үйл ажиллагаандаа байнга, 15.1 хувь нь хааяа хэрэглэдэг, тэсэлгээний бодисыг жонш олборлож буй хүүхдүүдийн 18.3 хувь нь байнга болон хааяа хэрэглэдэг гэжээ.

*Өгүүлэл* 4.12. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ашигладаг багаж хэрэгслүүд болон олборлож буй ашигт малтмалын төрлөөр


Ашигладаг багаж, хэрэгслүүдийн төрөл	Ашигт малтмалын төрөл							
	Алт				Жонш			
	Байнга	Хааяа	Огт үгүй	Бүгд	Байнга	Хааяа	Огт үгүй	Бүгд
Хүрз	82.5	11.0	6.5	<b>100.0</b>	81.1	13.0	5.9	<b>100.0</b>
Алх/лантуу	39.0	32.0	29.0	<b>100.0</b>	60.8	15.4	23.8	<b>100.0</b>
Осков	78.3	11.1	10.6	<b>100.0</b>	37.8	16.0	46.2	<b>100.0</b>
Олс дээс	61.5	17.6	20.9	<b>100.0</b>	19.8	11.9	68.3	<b>100.0</b>
Шуудай	87.2	8.4	4.4	<b>100.0</b>	43.5	9.2	47.3	<b>100.0</b>
Лаа	63.3	20.2	16.7	<b>100.0</b>	20.8	14.0	65.3	<b>100.0</b>
Гар чийдэн	64.3	19.8	15.9	<b>100.0</b>	7.7	17.5	74.8	<b>100.0</b>
Төмөр шигшүүр	17.9	32.7	49.4	<b>100.0</b>	4.2	5.2	90.6	<b>100.0</b>
Мөнгөн ус	5.9	15.1	79.0	<b>100.0</b>	-	-	-	-
Мөнгөн ус хадгалах сав	8.2	11.5	80.3	<b>100.0</b>	-	-	-	-
Хуванцар түмпэн	86.7	7.5	5.8	<b>100.0</b>	40.2	10.6	49.2	<b>100.0</b>
Хувин	73.8	12.9	13.3	<b>100.0</b>	70.9	15.9	13.2	<b>100.0</b>
Уур, нүдүүр	11.9	17.9	70.2	<b>100.0</b>	12.1	7.1	80.8	<b>100.0</b>
Лоом/жоотуу	51.7	22.1	26.2	<b>100.0</b>	67.8	7.9	24.3	<b>100.0</b>
Тэсэлгээний бодис	1.4	3.6	95.0	<b>100.0</b>	5.7	12.6	81.7	<b>100.0</b>
Моторт шигшүүр	12.0	16.6	71.4	<b>100.0</b>	0.0	5.5	94.5	<b>100.0</b>
Гар шигшүүр	25.7	25.0	49.3	<b>100.0</b>	2.2	3.3	94.5	<b>100.0</b>
Шлюц	17.4	11.8	70.8	<b>100.0</b>	0.0	0.0	100.0	<b>100.0</b>
Дамнуургат татлага	23.7	17.3	59.0	<b>100.0</b>	8.7	2.9	88.4	<b>100.0</b>
Бусад хэрэгслүүд	0.6	5.1	94.3	<b>100.0</b>	0.0	0.0	100.0	<b>100.0</b>

Дээрх багаж, хэрэгслүүдийн талаас илүү хувь нь (47.1 хувь) хүүхдүүдийн өөрсдийнх нь байгаа бөгөөд 33.8 хувь нь холимог (зарим нь өөрийнх нь, зарим нь хүнийх), үлдсэн хувь нь түрээслэх болон хүнээс түр гуйж хэрэглэдэг байна.





Алт олборлож буй хүүхдүүдэд хэл амаар доромжлох (алт олборлогч хүүхдүүдийн 70.8 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 81.8 хувь), зодуулах (алт олборлогч хүүхдүүдийн 64.5 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 27.3 хувь), ажлаа хийлгэх (алт олборлогч хүүхдүүдийн 52.9 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 27.3 хувь) болон мөнгө нэхэх (алт олборлогч хүүхдүүдийн 51.1 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 32.7 хувь) зэрэг дарамт шахалтууд хамгийн элбэг тохиолддог байна (Зураг 4.7).



Оүгү айаёүё: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцэхгүй

\*- "Бусад" гэсэн ангилалд бороохой/хий/буу/нохойгоор сүрдүүлэх зэрэг дарамт, шахалтууд багтсан.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс хэн нэгний дарамт, шахалтад өртдөг хүүхдүүд багагүй хувьтай байгаа нь тэнд хүүхдүүдийн эрх, ашиг нэлээд зөрчигдөж байгааг харуулж байна.

### **Ажлын цагийн үргэлжлэх хугацаа ба амралт**

Алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг ажлын цагийн ногдол болон олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр Хүснэгт 4.14-д харууллаа.

Алт олборлож буй хүүхдүүдийн ажил өглөө дунджаар 9 цагаас хойш эхэлж, орой дунджаар 19 цаг өнгөрөөд дуусдаг байна. Хүйсийн хувьд ажлын эхлэх болон дуусах хугацаа бага зэрэг ялгаатай буюу эмэгтэй хүүхдийн ажиллаж эхлэх цаг эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад арай хойно эхлээд бага зэрэг эрт дуусдаг байна.

*ᠪᠦᠵᠡᠨᠢᠨᠠᠨᠨᠢ* 4.14. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ажлын цагийн ногдол, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр

Ажлын цагийн ногдол	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<b>Ажил эхэлдэг цаг</b>						
9 цагаас өмнө	29.2	25.0	28.4	40.0	43.2	40.6
9-10 цагийн хооронд	27.9	28.7	28.0	29.6	0.0	24.6
10-11 цагийн хооронд	29.6	30.8	29.8	20.4	56.8	26.6
11 цагаас хойш	13.3	15.5	13.7	10.0	0.0	8.2
<b>Дундаж цаг</b>	<b>9:06</b>	<b>9:18</b>	<b>9:12</b>	<b>8:48</b>	<b>9:00</b>	<b>8:48</b>
<b>Ажил дуусдаг цаг</b>						
19 цагаас өмнө	24.9	30.5	25.0	23.9	30.5	25.0
19-20 цагийн хооронд	22.3	27.1	26.1	25.8	27.1	26.1
20-21 цагийн хооронд	26.6	42.4	33.6	31.8	42.4	33.6
21 цагаас хойш	26.2	0.0	15.3	18.5	0.0	15.3
<b>Дундаж цаг</b>	<b>19:30</b>	<b>19:12</b>	<b>19:24</b>	<b>19:24</b>	<b>18:36</b>	<b>19:12</b>
<b>Өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа</b>						
7 ба түүнээс доош цаг	22.1	15.7	20.9	23.9	49.2	28.2
7-8 цаг	24.6	21.8	24.1	21.3	0.0	17.6
9-10 цаг	29.5	42.2	31.8	28.3	33.1	29.1
11 ба түүнээс дээш цаг	23.8	20.3	23.2	26.5	17.7	25.1
<b>Дундаж цаг</b>	<b>8:48</b>	<b>8:48</b>	<b>8:48</b>	<b>8:48</b>	<b>8:30</b>	<b>8:48</b>
<b>Уурхайд жилд ажилладаг хугацаа</b>						
1-2 сар	19.0	25.9	20.2	19.9	51.3	25.3
3 сар	40.5	36.1	39.7	41.3	19.3	37.5
4-6 сар	22.1	36.3	24.6	21.1	12.6	19.6
7 ба түүнээс дээш сар	18.4	1.7	15.5	17.7	16.8	17.6
<b>Дундаж</b>	<b>4.4</b>	<b>3.5</b>	<b>4.3</b>	<b>4.6</b>	<b>3.6</b>	<b>4.4</b>
<b>Ажлын дундуур амрах хугацаа гардаг эсэх</b>						
Гийм	87.8	85.1	87.3	91.2	100.0	92.7
Үгүй	12.2	14.9	12.7	8.8	0.0	7.3
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо</b>	<b>5993</b>	<b>1316</b>	<b>7309</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

Жоншны уурхайд ажилладаг хүүхдүүд ажил нь өглөө дунджаар 8-9 цагийн хооронд эхэлж, орой дунджаар 19 цаг өнгөрөөд дуусдаг гэжээ. Түүнчлэн эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдийн бодвол 21 цагаас хойш буюу оройн цагаар ажиллах нь түгээмэл байна. Тухайлбал, алт олборлодог эрэгтэй хүүхдүүдийн 26.2 хувь нь, жонш олборлодог эрэгтэй хүүхдүүдийн 18.5 хувь нь 21 цагаас хойш ажлын цаг дуусдаг гэсэн хариултыг өгчээ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тодорхойлох бас нэг үзүүлэлт бол ажлын цагийн үргэлжлэх хугацаа юм. ОУХБ-ын зөвлөмжөөр долоо хоногт ажлын нөхцлөөс үл хамааран 43 болон үүнээс дээш цагаар хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамааруулдаг байна. Өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа нь 8-9 цаг буюу хуулинд заасан хугацаанаас илүү байна. Эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдийг бодвол илүү цагаар ажиллаж байна.

Ажил хийх явцад ихэнх хүүхдүүдэд амрах хугацаа гардаг гэсэн боловч хүйсийн хувьд, алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 12.2 хувь, жонш олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 8.8 хувьд нь ажлын дундуур амрах боломж гардаггүй гэжээ.

Эрэгтэй хүүхдүүд уурхайд дунджаар жилийн 4-5 сард нь, харин эмэгтэй хүүхдүүд 3-4 сард нь ажилладаг байна. Олборлож буй ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл, алт/жонш олборлож буй хүүхдүүд ялгаагүй дунджаар ялгаагүй 4-5 сар ажиллаж байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн дийлэнх (90-93 хувь) нь зуны улиралд буюу уурхайн ажлын онцлогоос шалтгаалж улирлын чанартай ажилладаг байна. Хэдийгээр ихэнх хүүхдүүд зуны улиралд ажиллаж байгаа ч өвөл, хавар, намрын улиралд хүүхдүүдийн багагүй хувь нь алт, жонш олборлох ажлыг хийсээр байна. Энэ нь тэднийг сурч боловсрох болон бусад эрхээ эдэлж чадахгүйд хүргэж байна.

### **Давхар хөдөлмөр эрхлэлт**

Алт олборлож буй хүүхдүүдийн 25.8 хувь нь албан бусаар ажиллахын зэрэгцээ өөр төрлийн хөдөлмөр давхар эрхэлдэг байна. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд дээрх тохиолдол илрээгүй юм.

Хүснэгт 4.15-д давхар хөдөлмөр эрхэлдэг албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг эрхэлдэг ажил, олборлож буй ашигт малтмалын төрөл, насаар харууллаа.

**Өгүүлэл 4.15. Давхар хөдөлмөр эрхэлдэг албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, эрхэлдэг ажил, насаар**

Эрхэлдэг ажлын төрөл	Насны бүлэг			
	5-12	13-15	16-17	Нийт
Хоол, жижиглэнгийн бараа зарах	9.8	2.5	2.0	3.9
Бусдад үйлчлэх*	66.6	37.4	28.0	41.7
Мод/нүүрс зөөх	0.0	17.2	9.8	12.3
Металл/төмөр цуглуулж зарах	23.6	36.7	0.0	27.3
Бусад байгууллагад ажиллах	0.0	4.7	45.1	11.1
Бусад**	0.0	1.5	15.1	3.7
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон давхар хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн тоо</b>	<b>389</b>	<b>1152</b>	<b>346</b>	<b>1887</b>

Өгүүлэл 4.15: \*- Ус авах, түлээ хагалах зэрэг ажлууд багтсан

\*\* - Хурдны морь унах, цагаан тугалга угаах, будгийн ажлууд багтсан

Давхар хөдөлмөр эрхэлж байгаа эдгээр хүүхдүүд ихэвчлэн бусдад үйлчлэх буюу гэрийн үйлчлэгчийн шинж чанартай ажлуудыг хийдэг ажээ. Мөн металл, төмөр цуглуулж зардаг хүүхдүүдийн хувь ч багагүй байв. Насны бүлгээр авч үзвэл, бага насны хүүхдүүд гэрийн үйлчлэгчийн шинжтэй ажлуудыг илүүтэйгээр, 13-17 насны хүүхдүүд бусад байгууллагад ажиллах болон хүнд ажлуудыг илүүтэйгээр хийдэг болох нь харагдлаа.

### 4.3. Албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн орлого ба зарцуулалт

Албан бусаал алт/жонш олборлож буй бараг гурван хүүхэд тутмын хоёр нь алт/жонш олборлох ажлыг гэр бүлдээ, харин үлдсэн нь өөртөө энэ ажлыг хийж байна гэсэн хариултуудыг өгчээ. Дээрх хариулт аль ч төрлийн ашигт малтмал олборлогчдын хувьд ялгаагүй байлаа. Дашрамд хэлэхэд алт олборлодог хүүхдүүдийн 1.9 хувь, жонш олборлодог хүүхдүүдийн 1.5 хувь нь ажил олгогчийн удирдлаганд ажилладаг гэсэн хариултыг өгсөн байв. Эдгээр алт олборлогч хүүхдүүдийн 80.3 хувь нь ажлынхаа хөлсийг ажил олгогчоос бэлэн мөнгөөр, үлдсэн нь мөнгөн бусаар (хоол хүнс) авдаг гэжээ. Ажил олгогчийн өгдөг сарын дундаж цалин 75655 төгрөг байв. Харин жонш олборлодог хүүхдүүд ажлынхаа хөлсийг 100 хувь бэлэн мөнгөөр авдаг бөгөөд сард дунджаар 250000 төгрөг ажил олгогчоос авдаг байна.

Хүснэгт 4.16а, 4.16б-д өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар алт, жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг сард олборлодог ашигт малтмалын хэмжээ болон сарын орлогоор харууллаа.

*Оүлй үяò 4.16à. Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, хүйс, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Сард олборлодог алтны хэмжээ (грамм)</b>			
1.87 хүртлэх грамм	20.2	11.7	18.7
1.88- 3.75 грамм	28.7	27.4	28.5
3.76-7.50 грамм	26.4	39.7	28.7
7.51 ба түүнээс дээш грамм	24.7	21.2	24.1
<b>Дундаж хэмжээ</b>	<b>6.1</b>	<b>5.7</b>	<b>6.0</b>
<b>Сарын дундаж орлого (төгрөг)</b>			
1000-24999	15.8	23.6	17.2
25000-49999	31.6	30.7	31.5
50000-74999	24.4	13.8	22.5
75000-100000	18.4	17.9	18.3
101000 ба түүнээс дээш	9.8	14.0	10.5
<b>Дундаж хэмжээ</b>	<b>69404</b>	<b>64643</b>	<b>68555</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон өөртөө болон гэр бүлдээ ажилладаг алт олборлож буй хүүхдийн тоо</b>	<b>5889</b>	<b>1277</b>	<b>7166</b>

*Оүл аүяэүе:* 1 USD = 1227 төгрөг (Монгол банкны ханшаар)

Хүснэгт 4.16а-аас харахад сардаа алт олборлож байгаа нэг хүүхэд дунджаар 6 грамм, эрэгтэй хүүхэд 6.1 грамм, эмэгтэй хүүхэд 5.7 грамм алт олборлодог юм байна. Олборлосон алтны хэмжээг мөнгөн дүнгээр авч үзэхэд, эрэгтэй хүүхдүүд сардаа 69.4 мянган төгрөг, эмэгтэй хүүхдүүд 64.6 мянган төгрөгний орлого олдог ажээ. Эндээс алт олборлож байгаа эрэгтэй хүүхдүүд олборлож буй алтны хэмжээгээрээ, олж буй мөнгөөрөө ч эмэгтэй хүүхдүүдээс илүү байдаг нь харагдаж байна.

Харин жонш олборлож байгаа хүүхдүүдийн хувьд авч үзэхэд эрэгтэй хүүхэд сард дунджаар 14.3 тонн эмэгтэй хүүхдүүд 5.1 тонн буюу эрэгтэй хүүхдүүдээс бараг 3 дахин бага жонш олборлодог юм байна. Олборлож буй жоншны хэмжээтэйгээ уялдан сарын дундаж орлого ч мөнгөн дүнгээр дээрхтэй адил

ялгаатай байна. Хэдийгээр алт, жонш олборлож байгаа хүүхдүүдийн тоо харилцан адилгүй байгаа боловч сарын дундаж орлогын хэмжээг харьцуулж үзэхэд жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүд алт олборлож буй эрэгтэй хүүхдүүдийг бодвол сард дунджаар 54 орчим мянган төгрөг, харин алт олборлож буй охидууд жонш олборлож буй охидуудыг бодвол сард дунджаар 21 орчим мянган төгрөгийг илүү олдог байна.

*Оүйүяәö 4.16а. Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг албан бусаар жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, хүйс, сонгосон үзүүлэлтүүдээр*


Сонгосон үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Сард олборлодог жоншны хэмжээ (кг)</b>			
1000 хүртлэх	15.4	37.3	19.2
1001-5000	30.8	36.4	31.8
5001-10000	19.8	17.8	19.5
10000 ба түүнээш дээш	34.0	8.5	29.5
<b>Дундаж хэмжээ</b>	<b>14297</b>	<b>5057</b>	<b>12686</b>
<b>Сарын дундаж орлого (төгрөг)</b>			
1000-24999	28.5	70.1	35.7
25000-49999	9.7	11.1	9.9
50000-74999	14.3	0.0	11.9
75000-100000	14.0	5.1	12.4
101000 ба түүнээс дээш	33.5	13.7	30.1
<b>Дундаж хэмжээ</b>	<b>123715</b>	<b>43451</b>	<b>109721</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

*Оүйүяәёё: 1 USD = 1227 төгрөг (Монгол банкны ханшаар)*

Энд, хүүхдүүдийн сард олборлож буй алт/жоншны хэмжээнээс олох бодит орлого нь тухайн хүүхдийн хэлсэн сарын дундаж орлогоос зөрүүтэй байж болохыг тэмдэглэе. Хүүхдүүдийн хэлсэн дээрх мэдээллээр сарын дундаж орлогыг тодорхойлох нь хангалтгүй бөгөөд орлогын мэдээллийг бодитой гаргахын тулд илүү гүнзгийрүүлж судлах шаардлагатай.

Хүүхдийн нас нэмэгдэх тусам сард олборлосон алт/жоншны хэмжээ мөн нэмэгдсэн хандлагатай байлаа. Тухайлбал, алт олборлож буй 5-12 насны хүүхдүүдийн сард олборлосон алтны хэмжээ дунджаар 4 грамм байсан бол 16-17 насны хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 7.9 грамм байв. Үүнийг дагаад алтнаас олсон сарын дундаж орлого нь ч мөн өндөр байна (5-12 насны хүүхдүүдийн хувьд 44460 төгрөг, 16-17 насны хүүдүүдийн хувьд 79230 төгрөг). Жонш олборлож буй 5-12 насны хүүхдүүдийн сард олборлосон жоншны хэмжээ дунджаар 5.7 тонн, орлого нь 38883 төгрөг байсан бол 16-17 насны бүлгийн хүүхдүүдийн хувьд олборлосон жонш нь 19.6 тонн, жоншноос олсон сарын дундаж орлого нь 167892 төгрөг байлаа.

Зураг 4.8-д өөртөө болон, гэр бүлдээ ажилладаг албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг олборлосон алт/жоншийг хэн борлуулдаг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, насаар харууллаа.



Өөртөө болон гэр бүлдээ хөдөлмөр эрхэлдэг бага насны буюу 5-12 насны хүүхдүүдийн олборлосон алт/жоншийг эцэг, эх болон хамаатан нь илүүтэйгээр борлуулдаг болох нь харагдаж байна (алт олборлож буй хүүхдүүдийн 86.6 хувь, жонш олборлож буй хүүхдүүд 100 хувь). Харин нас нэмэгдэх тусам алт олборлож буй хүүдүүд өөрсдөө олборлосон ашигт малтмалаа борлуулдаг гэж хариулсан хувь нэмэгджээ. Тухайлбал, 5-12 насны хүүхдүүдийн 24.2 хувь нь л өөрөө алтаа борлуулдаг гэж хариулсан бол 13-15 насны хүүдүүдийн 36.2 хувь, 16-17 насны хүүхдүүдийн 54.6 хувь нь тус тус энэ хариултыг өгчээ. Түүнчлэн хамт ажилладаг хүмүүс болон найз, нөхөд нь тухайн хүүхдийн олборлосон алт/жоншийг борлуулдаг гэсэн хариултууд цөөнгүй хувийг эзэлж байна.

Харин одоо алт/жонш олборлогч хүүхдүүд алт, жонш олборлолтоос олсон орлогоо хэрхэн зарцуулдаг талаар авч үзье (Хүснэгт 4.17).

Олсон орлогын дийлэнхийг өрхийн хэрэглээнд зарцуулдаг гэсэн хүүхдийн хувь хамгийн өндөр байгаа ба энэ байдал эрэгтэй хүүхдүүдийн дунд эмэгтэй хүүхдүүдийнхээс илүү байна. Тухайлбал, алт олборлож буй хүүхдүүдийн 55.9

хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 56.2 хувь нь орлогоо өрхийн хэрэглээнд зарцуулдаг гэсэн ба энэ хариултыг өгсөн алт олборлодог эрэгтэй хүүхдүүдийн хувь эмэгтэй хүүхдүүдийнхээс 18 пунктээр өндөр байна. Харин жоншны уурхайд ажилладаг 10 эмэгтэй хүүхдийн 9 нь өөрийн олсон мөнгөө шууд өрхийн хэрэглээндээ зарцуулдаг гэсэн үр дүн гарчээ.

Алт олборлож олсон орлогоо эрэгтэй хүүхдүүдийн 25.1 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 30 хувь нь 100 хувь гэрийнхэндээ өгдөг гэж хариулсан бол өгдөггүй болон 1-25 хувийг нь өгдөг гэж хариулсан хүүхдийн хувь хүйс тус бүрд бага байлаа (2.3-6.4 хувь).

*Оᠵᠢᠶ᠋ᠠᠳ 4.17. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, сонгосон орлогын үзүүлэлтүүдээр*

Сонгосон орлогын үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<b>Олсон орлогын зарцуулалт</b>						
Өрхийн хэрэглээнд	59.1	41.1	55.9	48.9	91.5	56.2
Өөртөө хэрэгтэй зүйл авахад	35.6	51.1	38.3	44.1	8.5	38.0
Тоглох/ хармааны мөнгөнд	1.0	0.0	0.8	0.0	0.0	0.0
Сургалтын төлбөр төлөхөд	0.5	2.1	0.8	4.7	0.0	3.9
Хадгалдаг	2.3	1.4	2.2	0.0	0.0	0.0
Өрхийн гишүүддээ өгдөг	1.5	4.3	2.0	2.3	0.0	1.9
<b>Олсон орлогоосоо гэрийнхэндээ өгдөг хувь</b>						
Өгдөггүй	2.3	4.3	2.7	2.8	0.0	2.3
1-25	5.1	6.4	5.3	5.5	0.0	4.5
26-50	25.5	37.4	27.6	38.6	26.9	36.5
51-75	18.2	10.9	16.9	13.6	0.0	11.2
76-99	13.7	11.0	21.4	11.3	23.5	13.5
100	25.1	30.0	26.1	28.3	49.6	32.0
<b>Дундаж</b>	<b>70.6</b>	<b>63.8</b>	<b>69.4</b>	<b>66.3</b>	<b>80.7</b>	<b>68.7</b>
<b>Олсон орлогын өрхийн амьжиргаанд үзүүлэх хувь нэмэр</b>						
Өрхийн орлогын гол эх үүсвэр болдог	8.6	9.1	8.7	11.4	5.1	10.3
Багагүй нэмэр болдог	54.7	51.5	54.1	69.7	70.3	69.8
Бага зэрэг нэмэр болдог	34.9	36.2	35.2	16.0	24.6	17.5
Нэмэр болдоггүй	1.8	3.2	2.0	2.9	0.0	2.4
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдийн тоо</b>	<b>5993</b>	<b>1316</b>	<b>7309</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

Ерөнхийдөө алт олборлож буй хүүхдүүд дунджаар орлогынхоо 69.4 хувийг, жонш олборлож буй нийт хүүхдүүд орлогынхоо 68.7 хувийг гэрийнхэндээ зарцуулдаг ажээ. Жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн 28.3 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 49.6 хувь нь өөрийн олсон орлогоо 100 хувь гэрийнхэндээ өгдөг байна.

Алт/жонш олборлогч хүүхдүүдийн дунд өөрийн олсон орлогоо өрхийн амьжиргаанд багагүй нэмэр болдог гэж хариулсан хувь өндөр байгаагаас хүүхдүүд олсон орлогоо чамгүй үнэлдэг болох нь харагдаж байна (алт олборлож буй хүүхдүүдийн 54.7 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 69.7



хувь). Өөрийн олсон орлогоо өрхийн орлогын гол эх үүсвэр болдог болон өрхийн амьжиргаанд нэмэр болдоггүй гэсэн хувь бага байлаа.

Алт/жонш олборлогч нийт хүүхдүүдийн 13.8 хувь нь хэн нэгэнд өртэй байсан ба 23.2 хувь нь найз нөхөддөө, 23.4 хувь нь бусад хүмүүст, 13 хувь нь уурхайн орчимд ажилладаг хүмүүст, 12.1 хувь хамаатнууддаа өртэй, үлдсэн нь өрхийн гишүүддээ, ажил олгогчдоо, хамт ажилладаг хүндээ өртэй гэсэн байв. Хэн нэгэнд өртэй эдгээр хүүхдүүдийн 38.6 хувь сарын дараа, 30.3 хувь нь хоёр сарын дараа, 18.1 хувь нь 3 сарын дараа, үлдсэн нь 4 ба түүнээс дээш сарын дараа өрөө бүрэн төлж дуусгана гэжээ.

#### **4.4 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал**

##### **4.4.1 Хүүхдийн хооллолтын байдал**

Ажлын дундуур алт олборлож буй хүүхдүүдийн 33.6 хувь нь гэрээсээ авчирсан хоолоо иддэг бол 26.6 хувь нь уурхай дахь хоолны газраас, 27.2 хувь нь хувь хүмүүсээс авч, 11.4 хувь нь галаараа хамтарч болон өөрөө бэлдэж иддэг бол үлдсэн 1.2 хувь нь буюу гурван хүүхэд хоол иддэггүй байна. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн 65.7 хувь нь гэрээсээ авчирч, 18.5 хувь нь галаараа хамтарч бэлддэг, 12.8 хувь нь өөрөө бэлдэж, үлдсэн нь уурхай дахь хоолны газар болон хувь хүмүүсээс авч иддэг гэжээ.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг олборлож буй ашигт малтмалын төрөл, өдөрт хэдэн удаа халуун хоол иддэг эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр Хүснэгт 4.18-д харууллаа.

16-17 насны хүүхдүүдийн өдөрт иддэг халуун хоолны тоо арай илүү байдаг нь хүснэгтээс харагдаж байна. Өдөрт халуун хоол иддэггүй эмэгтэй хүүхэд байхгүй байхад, алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 1.8, жонш олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 8.8 хувь нь өдөрт ажлын дундуур нэг ч удаа хоол иддэггүй байна.

Эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүдийг эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад халуун хоол иддэггүй байдал алт олборлогч хүүхдүүдийн хувьд 2 дахин өндөр, жонш олборлогч хүүхдүүдийн хувьд 2.7 дахин өндөр байна.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн олдог сарын дундаж орлого нэмэгдэх тусам өдөрт иддэг халуун хоолны давтамж нэмэгдэж байна. Тухайлбал, алт олборлогч 100000 ба түүнээс дээш төгрөгний орлоготой, өдөрт гурван удаа халуун хоол иддэг хүүхдүүдийн хувь 50000-74999 төгрөгний орлоготой хүүхдүүдтэй харьцуулахад 4.2 дахин, 25000-49999 хүүхдүүдтэй харьцуулахад 2.6 дахин өндөр байлаа.

*Өзгөтэй* 4.18. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, өдөрт хэдэн удаа халуун хоол иддэг эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл									
	Алт					Жонш				
	Иддэг-гүй	1	2	3	Бүгд	Иддэг-гүй	1	2	3	Бүгд
<b>Насны бүлэг</b>										
5-12	2.2	35.8	35.7	26.3	<b>100.0</b>	7.2	50.6	33.2	9.0	<b>100.0</b>
13-15	0.1	20.8	51.9	27.2	<b>100.0</b>	0.0	30.0	37.0	33.0	<b>100.0</b>
16-17	3.0	24.5	42.3	30.2	<b>100.0</b>	13.7	19.8	38.8	27.7	<b>100.0</b>
<b>Хүйс</b>										
Эрэгтэй	1.8	23.0	47.4	27.9	<b>100.0</b>	8.8	33.7	34.3	23.2	<b>100.0</b>
Эмэгтэй	0.0	35.0	36.9	28.1	<b>100.0</b>	0.0	16.8	48.7	34.5	<b>100.0</b>
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>										
Хамт амьдардаг	1.3	24.5	47.3	26.9	<b>100.0</b>	6.1	32.8	40.8	20.3	<b>100.0</b>
Хамт амьдардаггүй/ Өнчин	2.6	32.7	24.7	40.0	<b>100.0</b>	16.3	15.0	7.5	61.2	<b>100.0</b>
<b>Сарын дундаж орлого*</b> (төгрөг)										
1000-24999	0.0	23.9	64.4	11.7	<b>100.0</b>	5.0	40.2	42.3	12.5	<b>100.0</b>
25000-49999	1.3	30.6	41.9	26.2	<b>100.0</b>	0.0	38.2	17.6	44.2	<b>100.0</b>
50000-74999	1.7	34.8	47.3	16.2	<b>100.0</b>	47.5	22.5	30.0	0.0	<b>100.0</b>
75000-100000	1.2	14.0	47.8	37.0	<b>100.0</b>	0.0	33.3	26.2	40.5	<b>100.0</b>
100001 ба түүнээс дээш	0.0	10.5	21.3	68.2	<b>100.0</b>	0.0	21.1	45.6	33.3	<b>100.0</b>
	<b>1.5</b>	<b>25.1</b>	<b>45.5</b>	<b>27.9</b>	<b>100.0</b>	<b>7.3</b>	<b>30.9</b>	<b>36.8</b>	<b>25.0</b>	<b>100.0</b>
<b>Нийт</b>	2.2	35.8	35.7	26.3	<b>100.0</b>	7.2	50.6	33.2	9.0	<b>100.0</b>

*Өүг айвчлал*: \*- Өөртөө болон гэр бүлдээ ажилладаг хүүхдүүдийн хувьд тооцогдсон (алт N=282, жонш N=59)

Албан бусаар алт/жонш олборлогч нийт хүүхдүүдийн 91.5 хувь нь нэг удаагийн хооллолтондоо цалдаг гэж хариулсан байхад үлдсэн 8.5 хувь нь цалдаггүй гэсэн хариулт өгсөн байна. Насны бүлгээр авч үзэхэд, алт олборлогч 5-12 насны хүүхдүүдийн 8.4 хувь, жонш олборлогч 16-17 насны хүүхдүүдийн 22.7 хувь хоолондоо цалдаггүй гэж хариулсан хувь бусад насны хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байсан. Албан бусаар алт/жонш олборлогч хүүхдүүдийн 21.2 хувь нь судалгаа авахаас өмнөх долоо хоногт халуун хоол идэлгүй хоносон байжээ. Эдгээр хүүхдүүд дунджаар долоо хоногийн хоёр өдөрт нь халуун хоолгүй хоносон байна.


#### 4.4.2 Эрүүл мэндийн байдал

Албан бусаар алт/жонш олборлогч хүүхдүүдийн 29.7 хувь нь ажиллаж байхдаа өвдөж байсан бөгөөд тэдний 25.4 хувь нь өвдснөөсөө хойш нэг сар хэртэй, 27.7 хувь нь 1-3 сар болж байгаа ажээ. Түүнчлэн хүүхдүүдийн 24 хувь нь судалгаа авах үед өөрсдийгөө өвчтэй байгаа гэсэн ба үе мөчний болон амьсгалын замын өвчнөөр голдуу өвдсэн байв.


Албан бусаар алт/жонш олборлож байгаа нийт хүүхдүүдийн 20.7 хувь буюу 1654 хүүхэд ажил дээрээ осолдож эсвэл гэмтэл авч байсан байна. Эдгээр хүүхдүүдийг олборлож байгаа ашигт малтмалын төрлөөр авч үзэхэд, алт

олборлож байгаа хүүхдүүдийн 20.5, жонш олборлож байгаа хүүхдүүдийн 21.8 хувьд нь ямар нэгэн осолд орох, гэмтэл авах явдал тохиолдож байжээ.

Зураг 4.9-д уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдэд тохиолдсон осол гэмтлийг ашигт малтмалын төрлөөр харууллаа. Алт болон жонш олборлож байгаа хүүхдүүдийн хувьд хөл/гараа гэмтээх явдал түгээмэл байгаа бөгөөд, ялангуяа жонш олборлож байгаа бараг бүх хүүхдүүдэд энэ төрлийн гэмтэл тохиолдсон байна. Тархи толгойндоо гэмтэл авч байсан алт олборлогч хүүхдүүдийн хувь жонш олборлогч хүүхдүүдийн хувиас 2 дахин өндөр байлаа.



Зураг 4.10-т хүүхдүүдэд тохиолдсон гэмтлийг насны бүлгээр харууллаа. Судалгааны үр дүнгээр 5-12 насны хүүхдүүдийн 6.2, 13-15 насны хүүхдүүдийн 22.1, 16-17 насны хүүхдүүдийн 28.4 хувь нь тус тус ажлын байран дээрээ ямар нэгэн осолд орж, гэмтэл авч байжээ. Бага насны хүүхдүүдийн хувьд хөл/гар болон тархи толгойгоо гэмтээх явдал түгээмэл тохиолдож байна. Харин 16-17 насны хүүхдүүд 5-12, 13-15 насны хүүхдүүдтэй харьцуулахад нуруугаа гэмтээх нь арай илүү байна. Энэ нь мөн насны хүүхдүүд хүнд хүчир ажлыг илүүтэй хийж байгаатай холбоотой юм.



Ажлын байран дээрээ өвдөж байсан болон осол гэмтэл авч байсан хүүхдүүдийн ердөө 63.3 хувь нь л (алтны уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдийн 58.2 хувь, жоншны уурхайд ажиллаж байгаа хүүхдийн 43.5 хувь) эмч, эмнэлгийн ажилтнаас зөвлөгөө, тусламж авчээ (Хүснэгт 4.19).

**Өгөгдөл 4.2**

Ажлын байран дээрээ өвдөж байсан болон осол гэмтэл авч байсан хүүхдүүдийн ердөө 63.3 хувь нь л (алтны уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдийн 58.2 хувь, жоншны уурхайд ажиллаж байгаа хүүхдийн 43.5 хувь) эмч, эмнэлгийн ажилтнаас зөвлөгөө, тусламж авчээ (Хүснэгт 4.19).

(И.А. Үдүгдүй, 14 талбар, 2000 онд авч, 2000 онд авч, 2000 онд авч, 2000 онд авч, 2000 онд авч, 2000 онд авч)

*ᠪᠦᠵᠡᠨ ᠶ᠋ᠠᠳᠤ 4.19. Ажиллаж байхдаа өвдөж байсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл				
	Алт			Жонш	
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Нийт
<b>Эмч/эмнэлгийн ажилтнаас тусламж авсан эсэх</b>					
Тийм	55.4	76.8	58.2	43.3	43.3
Үгүй	44.6	23.2	41.8	56.7	56.7
<b>Эрүүл мэндийн үйлчилгээ, тусламжийн чанар*</b>					
Маш сайн	7.6	4.1	7.0	0.0	0.0
Сайн	48.8	53.2	49.6	49.5	49.5
Дунд	33.4	30.1	32.7	50.5	50.5
Муу	10.2	12.6	10.7	0.0	0.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон ажил дээрээ өвдөж байсан хүүхдийн тоо</b>	<b>1884</b>	<b>330</b>	<b>2214</b>	<b>158</b>	<b>158</b>

Тэмдэглэл: \*- Зөвхөн эмч/эмнэлгийн ажилтнаас тусламж, үйлчилгээ авсан алт/жонш олборлогч хүүхдүүдээс асуугдсан.

Эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг эцэг эхийн 37.6 хувь нь хийсэн боловч үйлчилгээний чанар сайн байгаагүй гэж алт олборлогч хүүхдүүдийн 43.4 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 50.5 гаруй хувь нь хариулжээ.

Өвчтэй эсвэл осол, гэмтэл авсан хүүхдүүдийн 43.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй бөгөөд тэдний 21.4 хувь нь эмнэлгээс хэт алслагдсан учраас эмнэлэгт хандаж чадаагүй гэсэн байна. Тухайлбал, алт олборлож буй газраас хамгийн ойрхон эмнэлэг хүртэл дунджаар 20.5 километр, харин жонш олборлож буй газраас хамгийн ойрхон эмнэлэг хүртэл дунджаар 20.8 километр гарч байна.

Өвчтэй/осол гэмтэл авсан 3 хүүхэд тутмын нэг нь өвтэй байсан хэрнээ ажлаа үргэлжүүлэн хийж байжээ. Тэд дунджаар 10-11 өдөр өвчтэй хэвээр атлаа өөрийнхөө хүсэлтээр ажилласан гэсэн байна.

Хүүхдүүдийн алт, жонш олборлоогүй үеийн эрүүл мэндийн байдлыг ажиллаж эхэлснээс хойшхи үетэй харьцуулбал, алт олборлож буй хүүхдүүдийн 21.3 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 21 хувийнх эрүүл мэндийн байдал муудсан гэж үзэж байна.

#### **4.4.3 Хөдөлмөр хамгааллын байдал**

##### *Ажлын хувцас, багаж, хэрэгсэл*

Алтны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн ердөө 15.8 хувь, жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 34.1 хувь нь хөдөлмөр хамгааллын наад захын шаардлагыг мэддэг гэсэн ба энэ талын мэдлэгтэй хүүхдийн 34 орчим хувь л хөдөлмөр хамгааллын шаардлагыг дагаж мөрддөг байна.

Хүүхдүүдийн хэрэглэж буй хөдөлмөр хамгааллын хувцас болон багаж хэрэгслийг хэрэглээний давтамжаар Хүснэгт 4.20-д дэлгэрэнгүй харууллаа.

Уул уурхайн хүнд салбарт албан бусаар ажиллаж буй хүүхдүүд голдуу бээлий, малгайтай цамц, ширэн гутал төдийхнийг өмсөж ажилласнаар өөрийнхөө ажлын хувцасны хэрэгцээг хангаж байна.

Ажлын багаж хэрэгслийн хувьд ч мөн ялгаагүй амны маскнаас өөр олигтой багаж хэрэгсэл байхгүй байв.

Алт/жонш олборлож буй хүүхдүүдийн 72.9 хувь нь ажлын нөхцөл нь хортой гэдэгтэй санал нийлж байна. Харин алт олборлогч хүүхдүүдийн 62 хувь нь ажлын нөхцлөө хүнд, 32.1 хувь нь дунд зэрэг, 5.9 хувь нь хөнгөн, жонш олборлогч хүүхдүүдийн 65.2 хувь нь ажлын нөхцлөө хүнд, 28.7 хувь нь дунд зэрэг, 6.1 хувь нь хөнгөн гэж дүгнэжээ. Хүүхдүүдийн нас нэмэгдэх тусам ажлын нөхцлөө хүнд буюу хүндэвтэр гэж дүгнэж буй хувь нь өсөж байна.

*ᠪᠢᠨᠭ᠎ᠠ* 4.20. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, ажлын хувцас, багаж хэрэгслийн хэрэглээний давтамжаар

Ажлын хувцас, багаж хэрэгсэл	Ашигт малтмалын төрөл							
	Алт				Жонш			
	Байнга	Заримдаа	Огт үгүй	Бүгд	Байнга	Заримдаа	Огт үгүй	Бүгд
<b>Хувцас:</b>								
Усны гутал	26.0	40.5	33.5	<b>100.0</b>	5.2	12.4	82.4	<b>100.0</b>
Даавуун бээлий	71.8	18.3	9.9	<b>100.0</b>	76.7	19.2	4.1	<b>100.0</b>
Каска	12.1	13.8	74.1	<b>100.0</b>	0.9	15.4	83.7	<b>100.0</b>
Малгайтай цамц	50.4	33.0	16.6	<b>100.0</b>	17.8	21.0	61.2	<b>100.0</b>
Ширэн гутал	71.6	17.7	10.7	<b>100.0</b>	22.4	37.4	40.2	<b>100.0</b>
<b>Багаж хэрэгсэл:</b>	35.1	21.0	43.9	<b>100.0</b>	37.0	21.5	41.5	<b>100.0</b>
Бүс								
Дөрөө	4.0	7.2	88.8	<b>100.0</b>	3.6	8.0	88.4	<b>100.0</b>
Дамнуургат татлага	8.1	12.4	79.5	<b>100.0</b>	1.5	4.8	93.7	<b>100.0</b>
Маск	18.4	11.9	69.7	<b>100.0</b>	1.7	3.6	94.7	<b>100.0</b>
Чихний бөглөө	19.7	22.2	58.1	<b>100.0</b>	15.2	23.2	61.6	<b>100.0</b>
Агааржуулагч	17.3	15.5	67.2	<b>100.0</b>	10.0	16.7	73.3	<b>100.0</b>
	7.4	9.5	83.1	<b>100.0</b>	0.9	3.1	96.0	<b>100.0</b>

### *Зөрчил, осол аваар*

Хүснэгт 4.21-д уурхайд ажиллагсад болон цагдаагийнханы хооронд хэр зэрэг зөрчил гардаг, мөн хүмүүс осол аваарт хэр зэрэг өртдөг талаарх хүүхдүүдийн өгсөн мэдээллийг харуулав.

Алтны уурхайд албан бусаар ажилладаг хүүхдүүдийн хувьд уурхайд ажиллагсад болон цагдаагийнханы хооронд огт зөрчил гардаггүй гэж 22.3 хувь нь, хааяа болон цөөн хэдэн удаа зөрчил гардаг гэж 49.6 хувь нь, байнга зөрчил гардаг гэж 11.3 хувь нь хариулжээ. Харин судалгаанд хамрагдагсдын 1/6 орчим хувь нь энэ талаар мэдэхгүй гэсэн байна.

Жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн хувьд, тал хувь нь уурхайн ажиллагсад болон цагдаагийнханы хооронд огт зөрчил гардаггүй, 24.6 хувь нь хааяа болон цөөн хэдэн удаа гардаг, 8.9 хувь нь байнга гарсан гэж хариулжээ. Харин арван хүүхэд тутмын нэг нь энэ талаар ямар нэг мэдээлэлгүй байв.

Албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 56.6 хувь нь уурхайд осол аваар хааяа болон цөөн хэдэн удаа гардаг гэж хариулсан бол 19.7 хувь нь байнга гардаг гэжээ. Харин дөрвөн хүүхэд тутмын нэг нь осол аваар гардаггүй, энэ талаар мэдэхгүй гэж хариулсан байна.

Жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд, 59.6 хувь нь уурхайд осол аваар хааяа болон цөөн хэдэн удаа гардаг гэж хариулсан бол 8.3 хувь нь байнга гардаг, 32.3 хувь нь осол аваар гардаггүй, энэ талаар мэдэхгүй гэжээ. Осол аваар байнга гардаг гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь багагүй байгаа нь энэ төрлийн хөдөлмөр эрсдэл ихтэй гэдгийг харуулж байна.

*О:ᠯᠢᠶ᠋ᠠᠳ 4.21. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, ашигт малтмалын төрөл ба зөрчил, осол гардаг эсэхээр*

Зөрчил, осол гардаг эсэх	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Уурхайд ажиллагсад болон цагдаагийнханы хооронд хэр зэрэг зөрчил гардаг эсэх</b>		
Байнга	11.3	8.9
Хааяа	42.9	16.2
Цөөн хэдэн удаа	6.7	8.4
Огт үгүй	22.3	56.0
Мэдэхгүй	16.8	10.5
<b>Осол аваар хэр зэрэг гардаг эсэх</b>		
Байнга	19.7	8.1
Хааяа	43.8	48.7
Цөөн хэдэн удаа	12.8	10.9
Огт үгүй	6.7	28.8
Мэдэхгүй	17.0	3.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо</b>	<b>7309</b>	<b>687</b>

Албан бусаар алт, жонш олборлож буй хүүхдүүдийн дунд ямар нэг зөрчил гардаг эсэх болон тэдгээр хүүхдүүд осолд өртөж байсан эсэх талаар Хүснэгт 4.22-г харууллаа.

Хүснэгтээс хүүхдүүдийн дунд танхайрах, зодолдох явдал хамгийн их тохиолддог гадна бие биенийхээ ухсан шороог булаах, мөнгө/эд зүйлсийг нь хулгайлах, агсам тавих гэх мэт зөрчлүүд нэлээд байдаг нь харагдаж байна. Үүнийг олборлож буй ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл, алт олборлож буй хүүхдүүдийн дунд зодолдож, танхайрах явдал хамгийн өндөр хувьтай, мөн түүнчлэн бусдын ухсан шороог булаах, агсам тавих, мөнгө/эд зүйлсийг нь хулгайлах зөрчлүүд нэлээд тохиолддог ажээ. Энд анхаарал татаж буй нэг зүйл бол дээрмийн хэрэг багагүй (19.7 хувь) гардаг явдал юм. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн дунд ерөнхийдөө дээрхтэй адил зөрчлүүд гардаг ч дээрмийн хэрэг харьцангуй бага (2.3 хувь) тохиолддог байна.

**Өзгийг 4.22. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, дараахь хэлбэрийн зөрчлийн талаар сонссон эсэх ба сонгосон үзүүлэлтүүдээр**

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл							
	Алт				Жонш			
	Тийм	Үгүй	МГ	Бүгд	Тийм	Үгүй	МГ	Бүгд
<b>Зөрчил*</b>								
Ухсан шороо булаах	47.6	52.4	-	<b>100.0</b>	23.9	76.1	-	<b>100.0</b>
Мөнгө/эд зүйл дээрэмдэх	19.7	80.3	-	<b>100.0</b>	2.3	97.7	-	<b>100.0</b>
Мөнгө эд зүйл хулгайлах	35.4	64.6	-	<b>100.0</b>	18.9	81.1	-	<b>100.0</b>
Зодолдох/танхайрах	60.2	39.8	-	<b>100.0</b>	43.4	56.6	-	<b>100.0</b>
Агсам тавих	32.7	67.3	-	<b>100.0</b>	29.5	70.5	-	<b>100.0</b>
Хэрэлдэх	5.6	94.4	-	<b>100.0</b>	1.5	98.5	-	<b>100.0</b>
<b>Осол</b>								
Амь насаа алдсан								
Хүнд гэмтэж тахир дутуу болсон	42.9	28.0	29.1	<b>100.0</b>	28.7	59.0	12.3	<b>100.0</b>
Хөнгөвтөр гэмтэж эмнэлэгт хүргэгдсэн	46.8	24.4	29.0	<b>100.0</b>	34.8	46.3	18.9	<b>100.0</b>
Хөнгөн гэмтсэн	59.4	18.7	21.9	<b>100.0</b>	44.1	44.3	11.6	<b>100.0</b>

Уурхайд албан бусаар ашигт малтмал олборлох ажил нь маш хүнд нөхцөлтэй, эрсдэл ихтэй, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн нэг болдог билээ. Учир нь уурхайд ажиллах нөхцөл хүнд, хөдөлмөрийн аюулгүй байдал бараг хангагдаагүйн улмаас осол, аваарууд нэлээд гардаг. Судалгаагаар албан бусаар алт олборлодог хүүхдүүдийн дунд осол, эндэгдэл хэр зэрэг тохиолддог талаар тодруулахад, хүүхдүүд хүнд, хөнгөн хэлбэрээр осолд маш их өртдөг гэсэн үр дүн гарсан. Тухайлбал, албан бусаар алт олборлож байгаад амь насаа алдсан хүүхдүүдийн талаар судалгаанд хамрагдагсдын 42.9 хувь нь сонссон бол хүнд гэмтэж, тахир дутуу болсон хүүхдүүдийн талаар 46.8 хувь нь, хөнгөвтөр гэмтэж эмнэлэгт хүргэгдсэн хүүхдүүдийн талаар 59.4 хувь нь, хөнгөн гэмтэл авсан хүүхдүүдийн талаар 72.9 хувь нь сонсжээ. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд осолд өртөөд амь насаа алдсан хүүхдүүдийн талаар 28.7 хувь нь, хүнд гэмтэл авсан талаар 34.8 хувь нь, хөнгөвтөр гэмтэл авч эмнэлэгт хүргэгдэж байсан талаар 44.1 хувь нь, хөнгөн гэмтэл авч байсан талаар 69.6 хувь нь тус тус сонссон байна.

**Өгөгдөл 4.3**

Агсам тавих үйлдлийн талаар судалгаанд хамрагдагсдын 32.7 хувь нь, хүнд гэмтэж тахир дутуу болсон хүүхдүүдийн талаар 42.9 хувь нь, хөнгөвтөр гэмтэж эмнэлэгт хүргэгдсэн хүүхдүүдийн талаар 46.8 хувь нь, хөнгөн гэмтэл авсан хүүхдүүдийн талаар 72.9 хувь нь сонсжээ. Харин жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд осолд өртөөд амь насаа алдсан хүүхдүүдийн талаар 28.7 хувь нь, хүнд гэмтэл авсан талаар 34.8 хувь нь, хөнгөвтөр гэмтэл авч эмнэлэгт хүргэгдэж байсан талаар 44.1 хувь нь, хөнгөн гэмтэл авч байсан талаар 69.6 хувь нь тус тус сонссон байна.

(А.И., үгдүүд, 15 талбар, агаарын аюулгүй байдлыг хангах ажил, нэгдсэн үйлдлийн төлөвлөгөө, нэгдсэн, Агаарын аюулгүй байдлыг хангах ажил, Агаарын аюулгүй байдлыг хангах ажил)



## **4.5 Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн дадал зуршил ба чөлөөт цаг, ирээдүйн хүсэл эрмэлзлэл**

### **4.5.1 Муу дадал зуршил**

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 16.9 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 1.4 хувь, жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн 24.3 хувь нь тамхи татдаг хүүхдүүд байв. Алт олборлож буй 13-аас дээш насны хүүхдүүд өдөрт дунджаар 9-10 ширхэг тамхи, жонш олборлож буй 16-аас дээш насны хүүхдүүд өдөрт дунджаар 5-6 ширхэг тамхи татдаг байна. Харин 13-аас доош насныхны дунд тамхи татдаг муу зуршилтай хүүхэд байхгүй байв.

Алт, жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн 10 хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэж үзсэн ба алт олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 43.9 хувь, жонш олборлогч эрэгтэй хүүхдүүдийн 28.6 хувь нь ганц нэг удаа амсаж үзжээ. Долоо хоног бүр согтууруулах ундаа тогтмол хэрэглэдэг алт олборлогч 15 эрэгтэй хүүхэд, жонш олборлогч 13 эрэгтэй хүүхэд байв.

Мансууруулах бодис, тухайлбал цавуу, бензин үнэрлэх, өвс, хар тамхи татах гэх мэт муу зуршилтай хүүхдүүд алт олборлож буй хүүхдүүдийн 5.9 хувийг, жонш олборлож буй хүүхдүүдийн 6.3 хувийг эзэлж байна. Алтны уурхайд ажилладаг эдгээр хүүхдүүдийн 65.7 хувь нь ганц нэг удаа хэрэглэж үзсэн, 19.9 хувь нь долоо хоног бүр, 3.9 хувь нь сар болгон, үлдсэн 10.5 хувь нь өдөр болгон хэрэглэдэг ажээ. Харин жонш олборлож буй мансууруулах бодис хэрэглэдэг хүүхдүүд 100 хувь ганц нэг удаа л хэрэглэж үзсэн байна.

Алт/жонш олборлож буй газарт 18 хүртлэх насны охид биеэ үнэлэх явдал алт олборлож буй газарт элбэг тохиолддог гэж алт албан бусаар олборлож буй хүүхдүүдийн 1.8 хувь, дунд зэрэг гэж 3.3 хувь, ховор гэж 2.7 хувь, үлдсэн хувь нь үгүй, мэдэхгүй гэж хариулжээ. Харин жонш олборлож буй газарт 18 хүртлэх насны охид биеэ үнэлэх явдал ховор тохиолддог гэж 1.9 хувь нь хариулсан ба бусад нь үгүй, мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Мөн алт олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн 16.2 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 7.7 хувь, жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн 13.3 хувь нь сэргийлэх цагдаад баригдаж, дуудагдаж үзсэн ба тэдний баригдаж, дуудагдаж үзсэн шалтгаанд зөвшөөрөлгүйгээр алт/жонш олборлосон, гүтгүүлсэн, зодоон зэрэг шалтгаанууд орж байна. Тэр үед сэргийлэх/цагдаа нар давхардсан тоогоор алт олборлож буй хүүхдүүдийн 51.8 хувийг нь айлган сүрдүүлж, 43.3 бороохойдож зодсон, 31.2 хувьтай нь жирийн харьцсан, 16.5 хувьд нь хэргийг хүчээр хүлээлгэсэн гэжээ. Жонш олборлож буй хүүхдүүдийн 56.8 хувийг нь айлган сүрдүүлж, 29.7 хувийг нь бороохойдож зодсон, мөн 8.1 хувьтай нь жирийн харьцсан, 16.2 хувьд нь хэргийг хүчээр хүлээлгэсэн байна.

### **4.5.2 Мэдлэг, хандлага, чөлөөт цаг ба ирээдүйн хүсэл эрмэлзлэл**

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдээс чөлөөт цагаа голдуу хаана өнгөрөөж, юу хийдэг талаар асууж тодруулахад, ихэнх нь сренхийдөө гэртээ өнгөрүүлдэг гэж хариулжээ. Энэ нь ашигт малтмалын төрөл, хүйсийн хувьд бага зэрэг ялгаатай байна. Тухайлбал, алт олборлодог эрэгтэй хүүхдүүдийн ихэнх (64.9 хувь) нь чөлөөт цагаа гэртээ, 12.9 хувь нь гудамжинд, 7.9 хувь нь тус бүр алт олборлож буй газартаа, 5.2 хувь нь найз нөхөдтэйгөө, үлдсэн нь хамаатныхдаа, чөлөөт цагаа өнгөрүүлдэг бөгөөд 2


хувь нь чөлөөт цаг огт гардаггүй гэсэн байна. Харин албан бусаар алт олборлож буй охидын хувьд ихэвчлэн (92.3 хувь) гэртээ чөлөө цагаа өнгөрүүлдэгээс гадна найз нөхөдтэйгөө, хамаатныдаа, үзвэр, үйлчилгээний газарт, уурхай дээр чөлөөт цагаа өнгөрүүлдэг байна.

Албан бусаар жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн хувьд гэртээ (82.4 хувь), үзвэр, үйлчилгээний газарт (4.4 хувь), найз нөхөдтэйгөө (6.2 хувь), хамаатныдаа (4.7 хувь), гудамжинд (2.3 хувь) тус тус чөлөөт цагаа өнгөрүүлдэг байхад охид гэртээ (94.9 хувь) болон найз нөхөдтэйгөө (5.1 хувь) чөлөөт цагаа өнгөрүүлдэг ажээ.

Хүүхдүүд чөлөөт цагаараа хамгийн түгээмэл хийдэг зүйлүүдийг эрэмбэлэхэд, *íýää¿áýúðò*: тоглодог *õî, ðääõääðò*: гэрийнхээ ажилд тусалдаг, *ãòðääõõääðò*: зурагт үздэг гэсэн хариултууд зонхилж байлаа. Энэ үзүүлэлт нь хүйс болон ашигт малтмалын төрлийн хувьд онцын ялгаагүй байна.

Алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жинг цаашид сургуульд сурах, ажил хийх боломжийг сонгосон байдлыг Зураг 4.9-д харууллаа.

Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг цаашид сурах боломжийг сонгоно гэсэн хүүхдүүдийн хувь эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй болон өнчин хүүхдүүдтэй харьцуулахад алт олборлож буй хүүхдүүдийн хувьд 16.7 пунктээр, жонш олборлож буй хүүхдүүдийн дунд 31.2 пунктээр өндөр байна. Хүйсийн хувьд жоншны уурхайд ажиллаж буй эмэгтэй хүүхдүүд 100 хувь сурах боломжийг сонгоно гэсэн бол алтны уурхайд ажиллаж байгаа эмэгтэй хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 89.1 хувьтай байсан ба эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад тус тус 12.6, 20.4 пунктээр өндөр байлаа. Мөн цаашид ажиллах боломжийг эрэгтэй хүүхдүүд илүүтэйгээр сонгож байгаа нь зураг 4.11-ээс харагдаж байна.



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс алт/жонш олборлох ажилдаа дур сонирхолтой эсэхийг нь тодруулж үзэхэд, 46 хувь нь дуртай гэсэн хариултыг өгчээ. Энэ нь ашигт малтмалын төрлийн хувьд онцын ялгаагүй, харин хүйсийн хувьд хөвгүүд охидуудаас харьцангуй илүү дур сонирхолтой байгаа нь ажиглагдлаа.

Хүснэгт 4.23-т алт/жонш олборлож буй ажилдаа дуртай хүүхдүүдийн хувийн жинг шалтгаан, ашигт малтмалын төрөл ба хүйсээр харууллаа.

Алт олборлодог хүүхдүүдийн хувьд, ажилдаа дуртай байдаг хамгийн гол шалтгаан нь гэрийнхэндээ тус дэм болдог явдал байв (хөвгүүдийн 45.6 хувь, охидуудын 60.4 хувь). Энэ үзүүлэлтийг хүйсийн хувьд авч үзэхэд бага зэргийн ялгаатай байдал ажиглагдаж байлаа. Алт олборлож буй эрэгтэй хүүхдүүд гэрийнхэндээ тус дэм болохоос гадна өөрийн гэсэн мөнгөтэй болох (охидынхоос 11 пунктээр өндөр), найз нөхөдтэйгөө цагийг зугаатай өнгөрөөх (охидынхоос 10.8 пунктээр өндөр) сонирхол, шалтгаан илүү давамгайлж байхад охидуудад гэрийнхэндээ тус дэм болох, өөрийн гэсэн мөнгөтэй болохоос гадна суралцахтай холбоотой мөнгөө олж авдаг (хөвгүүдийнхээс 7.8 пунктээр өндөр буюу 8.8 хувь) гэсэн шалтгаан багагүй байр суурийг эзэлж байв. Эндээс охидууд өрхийн орлого хүрэлцдэггүйн улмаас өрхдөө хувь нэмэр оруулах, өөрийн гэсэн мөнгөтэй болох сонирхолтой байдгаас гадна суралцах

хүсэл эрмэлзлэл өндөр байгаа нь ажиглагдлаа. Харин хөвгүүд цагийг илүү зугаатай, хөгжилтэй өнгөрүүлэх сонирхолтой байна.

*ᠪᠢᠰᠠᠳ* 4.23. Албан бусаар алт/жонш олборлож буй ажилдаа дуртай хүүхдүүдийн хувийн жин, ажилдаа дуртай шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл ба хүйсээр

Шалтгаан	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Гэрийнхэндээ тус дэм болдог	45.6	60.4	47.6	47.2	34.1	45.3
Суралцахтай холбоотой мөнгөө олж авдаг	1.0	8.8	2.1	0.0	0.0	0.0
Хоол хүнс авах мөнгөтэй болдог	2.2	1.1	2.0	4.8	0.0	4.1
Өөрийн гэсэн мөнгөтэй болдог	36.9	25.9	35.5	35.3	65.9	39.9
Найз нартайгаа ажиллахад зугаатай байдаг	11.8	0.9	10.3	12.7	0.0	10.8
Бусад*	2.5	2.9	2.5	0.0	0.0	0.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдүүдийн тоо</b>	<b>2931</b>	<b>452</b>	<b>3383</b>	<b>252</b>	<b>44</b>	<b>296</b>

Note: \*- “Бусад” гэсэн ангилалд өөрийн хийсэн ажлын үр дүнг харахад сайхан байдаг, байгалийн сайхан орчинд ажилладаг гэсэн хариултауд багтсан.

Жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд ажилдаа дур сонирхолтой байх нь ганц, хоёрхон шалтгаан дээр төвлөрч байлаа. Тухайлбал, жонш олборлож буй эрэгтэй хүүхдүүдийн хувьд гэрийнхэндээ тус дэм болдог (47.2 хувь), өөрийн гэсэн мөнгөтэй болдог (35.3 хувь), найз нартайгаа ажиллахад зугаатай (12.7 хувь) гэсэн шалтгаанууд зонхилж байв. Харин охидууд өөрийн гэсэн мөнгөтэй болдог (65.9 хувь), мөн гэрийнхэндээ тус дэм болдог (34.1 хувь) учраас ажилдаа дуртай гэж хариулжээ.

Хүснэгт 4.24-д алт/жонш олборлож буй ажилдаа дургүй хүүхдүүдийн хувийн жинг шалтгаан, ашигт малтмалын төрөл ба хүйсээр харуулав.

Алтны уурхайд албан бусаар алт олборлодог хүүхдүүдийн хувьд уг ажлыг хийхэд маш их ядардаг, ажилдаа огт сонирхолгүй, сургуульд явж чаддаггүй гэсэн шалтгаанууд ажилдаа дургүй байхад голлох нөлөө үзүүлж байна. Хүйсийн хувьд охидууд хөвгүүдийг бодвол ажилдаа сонирхолгүй, сургуульд явж чаддаггүйн улмаас ажиллах дургүй байв.

Албан бусаар алт олборлож байгаа хүүхдүүдийн ихэнх нь буюу 85.7 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 78.9 хувь нь хийж буй ажлаа өөрийнхөө эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэдэгтэй санал нэг байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байлаа. Энэ үзүүлэлт нь нас, хүйсийн хувьд онцын ялгаагүй байв.

**ᠪᠦᠨᠢᠨᠠᠨᠠᠨ 4.24. Албан бусаар алт/жонш олборлож буй ажилдаа дургүй хүүхдүүдийн хувийн жин, шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрөл ба хүйсээр**

Шалтгаан	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бие өвддөг/өвчин тусдаг	3.6	3.2	3.5	4.1	0.0	3.3
Сургуульд явж чаддаггүй	12.7	19.6	14.2	7.9	40.5	14.1
Энэ төрлийн ажилд сонирхолгүй	16.5	25.3	18.5	25.9	0.0	21.0
Маш их ядардаг	47.1	46.4	46.9	58.2	59.5	58.5
Бага орлоготой	5.1	1.6	4.3	0.0	0.0	0.0
Ажлын нөхцөл хүнд, муу	8.6	3.9	7.6	0.0	0.0	0.0
Бусад	6.4	0.0	5.0	3.9	0.0	3.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдүүдийн тоо</b>	<b>3062</b>	<b>864</b>	<b>3926</b>	<b>316</b>	<b>74</b>	<b>390</b>

Хөдөлмөрийн хуулиар хүүхдүүд ажил эрхэлж болох доод насыг хэрхэн тогтоосон талаарх хүүхдүүдийн мэдлэгийн түвшинг хүснэгт 4.25-д харууллаа.

**ᠪᠦᠨᠢᠨᠠᠨᠠᠨ 4.25. Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүдийн хувийн жин, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйс ба хөдөлмөр эрхэлж болох хуулийн насны талаарх мэдлэгээр**

Хөдөлмөр эрхэлж болох хуулийн насны талаарх мэдлэгээр	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<b>Хуулиар тогтоосон хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар (16 нас)</b>						
Мэддэг	10.8	17.0	12.0	21.1	12.8	19.7
Мэднэ гэж буруу хариулсан	20.6	32.2	22.7	34.3	30.8	33.7
Мэдэхгүй	68.6	50.8	65.3	44.6	56.4	46.6
<b>Уурхайд хөдөлмөр эрхэлж болох насны доод хязгаар (18 нас)</b>						
Мэддэг	9.5	11.3	9.8	24.3	0.0	20.1
Мэднэ гэж буруу хариулсан	10.2	10.3	10.2	15.1	21.2	16.2
Мэдэхгүй	80.3	78.4	80.0	60.6	78.8	63.8
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тооцоолсон хүүхдүүдийн тоо</b>	<b>5993</b>	<b>1316</b>	<b>7309</b>	<b>569</b>	<b>118</b>	<b>687</b>

Судалгааны үр дүнгээс хүүхдүүдийн ихэнх хувь нь хөдөлмөр эрхэлж болох насны доод хязгаарын талаарх хуулийн мэдлэг дутмаг болох нь харагдлаа. Алт олборлож буй хүүхдүүдийн хувьд охидууд хөвгүүдээс харьцангуй илүү мэдлэгтэй, харин жонш олборлож буй хөвгүүд охидоос илүү мэдлэгтэй байв.

Хуулиар тогтоосон хөдөлмөр эрхлэх насны болон уурхайд хөдөлмөр эрхэлж болох насны доод хязгаарыг мэднэ гэж хариулсан хүүхдүүдэд мэдлэгийг олгож буй гол эх сурвалжууд нь, *í yāā jū yūdō*: багш, сурган хүмүүжүүлэгч *ōī*, *᠔āōāāādō*: эцэг, эх, *āō᠔āāōāāādō*: радио, телевиз болж байв. Түүнчлэн хүүхдүүд ах, эгчээсээ, найз нөхөд, хамт ажиллаж буй хүмүүс болон холбогдох ном, сонингоос дээрх мэдээллийг авчээ.

Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд хийж буй ажлаа бусдад санал болгохыг хүсэхгүй байгаагаас гадна өөрсдөө уг ажлаа үргэлжлүүлэн хийх сонирхол бага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Уг ажлаа цаашид үргэлжлүүлэн хийх сонирхолтой алт олборлодог хүүхдүүдийн талаас илүү (40.6 хувь) хувь нь хэр удаан хугацаанд хийх талаар ер бодож байгаагүй бол 18 хувь нь нэг жил, 25.3 хувь нь 1-3 жил, 16.1 хувь нь 3-аас дээш жил хийнэ гэжээ. Энэ үзүүлэлтийг хүйсийн хувьд авч үзвэл, охидууд хөвгүүдийг бодвол цаашид ажиллах хугацаагаа тодорхойлсон байдал ажиглагдаж байлаа. Жонш олборлож буй хүүхдүүдийн хувьд алт олборлож буй хүүхдүүдтэй харьцуулахад сонирхол татахуйц ялгаатай байдал ажиглагдсангүй.

Албан бусаар алт/жонш олборлох ажлаа үргэлжлүүлэн хийх сонирхолгүй байгаа хүүхдүүдээс цаашид юу хийхээр төлөвлөж байгааг нь тодруулахад, алт олборлож буй хүүхдүүдийн 71.2 хувь нь суурь боловсрол эзэмших, 16.9 хувь нь ямар нэг мэргэжил эзэмших, бусад нь мал маллах, цалинтай ажил эрхлэх, эсвэл бизнес хийхээр төлөвлөж байна гэжээ. Хүйсийн хувьд, охидууд хөвгүүдийг бодвол суурь боловсрол эзэмших (хөвгүүдээс бараг 17.7 пунктээр өндөр буюу 85.1 хувь) сонирхол өндөр байхад хөвгүүдэд ямар нэг мэргэжлийн сургууль, курст суралцах сонирхол (охидынхоос 5.5 пунктээр өндөр буюу 18.1 хувь) их байлаа.

Жоншны уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн хувьд ихэнх нь буюу 86.7 хувь нь суурь боловсрол эзэмших, 1.6 хувь нь мэргэжил эзэмших, 9 хувь нь цалинтай ажил эрхлэх төлөвлөгөөтэй байв.

Албан бусаар алт/жонш олборлож буй хүүхдүүд том болоод мэргэжилтэн, эсвэл үйлчилгээний ажилтан болох хүсэлтэй байгаа нь бусад мэргэжлийн ангиллуудаас хамгийн өндөр хувьтай байв.

Алт олборлож буй хүүхдүүдийн 16.1 хувь нь, харин жонш олборлож буй хүүхдүүдийн 19.8 хувь нь орон нутгийн засаг захиргааны байгууллагаас ямар нэгэн тусламж дэмжлэг авсан байна. Эдгээр тусламж, дэмжлэгүүдэд хичээлийн хэрэгсэл өгөх (52.2 хувь), хоол, хүнсний зүйл өгөх (14.1 хувь), боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах (13.4 хувь) зэрэг тусламжууд багтаж байв.

Төрийн бус байгууллагаас үзүүлсэн тусламж, дэмжлэгт хамрагдсан хүүхдүүдийн хувийн жин алт олборлодог хүүхдүүдийн хувьд 16.1 хувь, жонш олборлодог хүүхдүүдийн 19.8 хувийг эзэлж байв. Төрийн бус байгууллагаас үзүүлсэн тусламж дэмжлэгүүдэд, *í yāā j ā y ū d ò*: Хоол хүнсний зүйл өгөх, *ō ī , d ā ō ā ā d ò*: боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах, *ā ō d ā ā ā ō ā ā d ò*: хичээлийн хэрэгсэл өгөх орж байна

Алт олборлож буй хүүхдүүдийн 9.4 хувь, жонш олборлож буй хүүхдүүдийн 12.3 хувь нь ийм төрлийн судалгаанд урьд өмнө нь 1 ба түүнээс олон удаа хамрагдаж байжээ.

## **БҮЛЭГ 5. АЛБАН БУСААР АЛТ, ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ/ЭХ**

---

Энэхүү бүлэгт албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхдүүдийн эцэг, эхээс өрхийнх амьжиргаа, ахуй нөхцөл, хүүхдүүдийнх нь хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хандлага ямар байгааг тодруулахыг гол зорилгоо болгов.

### **5.1 Өрхийн шинж байдал**

Судалгаанд Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад албан бусаар алт (122), жонш (32) олборлож байгаа хүүхдүүдийн нийтдээ 154 эцэг, эх хамрагдсан.

Судалгаанд хариулагчдын өрхийн ам бүлийн дундаж тоо албан бусаар алт олборлож буй хүүхэдтэй өрхүүдийн хувьд 5.2, харин жонш олборлож буй хүүхэдтэй өрхүүдийн хувьд 5.7 байна. Харин хүйсийн харьцааг (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) авч үзэхэд алт олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийнх 110.9, жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийнх 127.2 буюу алт олборлож буй хүүхэдтэй өрхүүдийнхээс 16.3 пунктээр өндөр байна (Хүснэгт 5.1). Эндээс харахад алт, жонш олборлож байгаа хүүхэдтэй судалгаанд хамрагдсан өрхүүдийн ам бүлийн дундаж тоо, хүйсийн харьцаа улсын хэмжээнийхээс нэлээд дээгүүр, өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан газруудад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байна. Үүнийг шилжих хөдөлгөөний улмаас эдгээр газруудад эрэгтэйчүүд ажил эрхлэхээр түлхүү ирдэгтэй холбон тайлбарлаж болох юм.

Хүн амын нас, хүйсний бүтцийг шинжилдэг нэг гол арга бол насны голчийг тодорхойлох явдал юм. Насны голч алт олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийн хувьд эрэгтэй 23.78, эмэгтэй 25.28 байхад жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийн хувьд эрэгтэй 22.22, эмэгтэй 22.70 байна.

Судалгаагаар эдгээр өрхөд амьдарч байгаа 7 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн боловсролын түвшинг авч үзэхэд өрхийн гишүүдийн бараг тал орчим хувийг (алт 46.0 хувь, жонш 41.7 хувь) боловсролгүй ба бага боловсролтой хүмүүс эзэлж байв. Энд бас нэг анхаарал хандуулбал зохих асуудал бол боловсролгүй, уншиж, бичиж чаддаггүй хүмүүсийн эзлэх хувийн жин (алт 7.7 хувь, жонш 4.8 хувь) багагүй, ялангуяа ашигт малтмалын аль ч олборлолтын хэлбэрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 2 дахин илүү уншиж, бичиж чадахгүй байгаа явдал юм. Энэхүү судалгааны үр дүн бусад судалгаануудын нэгэн адил бүрэн дундаас дээш боловсролыг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бага эзэмшиж байгааг дахин нотлон харууллаа.

6 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд ашигт малтмалын аль ч төрөлд дийлэнх хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодруулбал алт жонш олборлож байгаа хүмүүс эзэлж байна. Гэхдээ хүйсээр нэлээд ялгаатай байна. Тухайлбал, алт олборлож буй хүүхэдтэй өрхийн гишүүдийн алт олборлодог гэж хариулсан эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 14.6 пунктээр өндөр байхад харин жонш олборлодог хүмүүсийн хувьд эсрэгээр эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 4.6 пунктээр өндөр байна. Мөн алт олборлож буй хүүхэдтэй өрхийн гишүүдийн суралздаг гэж хариулсан эрэгтэй хүүхдүүдийн эзлэх хувийн жин эмэгтэй

хүүхдүүдийнхээ болон жонш олборлож байгаа хүүхдүүдийнхээ нэлээд бага байна. Эндээс алт олборлож байгаа газруудад эрэгтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт бусад газрынхаас илүү хангалтгүй байна гэж хэлж болохоор байна.

*᠐ᠵᠢᠶ᠋ᠠᠳ 5.1* Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхийн гишүүдийн хувийн жиц, сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Сонгосон үзүүлэлтүүд	Олборлож буй ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Насны бүлэг</b>						
0-14 насны хүн ам	30.4	30.7	30.5	33.0	39.5	35.9
15-59 насны хүн ам	68.7	68.6	68.7	66.0	60.5	63.6
60 ба түүнээс дээш насны хүн ам	0.9	0.7	0.8	1.0	0.0	0.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Нийт хүн амын тоо</b>	<b>336</b>	<b>303</b>	<b>639</b>	<b>103</b>	<b>81</b>	<b>184</b>
<i>᠕ᠢᠶ᠋ᠦᠨ ᠶ᠋ᠠᠨ</i>	<i>23.78</i>	<i>25.28</i>	<i>24.49</i>	<i>22.22</i>	<i>22.70</i>	<i>22.43</i>
<b>Боловсролын түвшин</b>						
Боловсролгүй/уншиж, бичиж чаддаггүй	9.5	5.7	7.7	6.2	2.9	4.8
Боловсролгүй/уншиж, бичдэг	10.1	7.1	8.7	13.4	10.3	12.1
Бага	32.5	26.3	29.6	27.8	20.6	24.8
Бүрэн бус дунд	27.4	28.1	27.8	35.1	30.9	33.3
Бүрэн дунд	17.7	24.9	21.1	12.4	26.5	18.2
Бүрэн дундаас дээш	2.8	7.8	5.2	5.2	8.8	6.7
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>7 ба түүнээс дээш настай хүн амын тоо</b>	<b>317</b>	<b>281</b>	<b>598</b>	<b>97</b>	<b>68</b>	<b>165</b>
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>						
Ямар нэгэн байгууллагат						
Ажилладаг	3.1	5.6	4.3	4.0	2.9	3.6
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг/ажил олгогч	56.6	40.3	48.9	40.4	46.3	42.9
Ажил эрхлээгүй байгаа	40.3	54.1	46.8	55.6	50.8	53.5
<i>Бүгдээс албан бусаар алт/жонш олборлодог</i>	<i>46.9</i>	<i>32.3</i>	<i>40.0</i>	<i>37.4</i>	<i>42.0</i>	<i>39.3</i>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>6 ба түүнээс дээш настай хүн амын тоо</b>	<b>322</b>	<b>288</b>	<b>610</b>	<b>99</b>	<b>69</b>	<b>169</b>

Судалгаанд хамрагдсан хариулагчдын шинж байдлыг авч үзэхэд алт олборлож буй хүүхэдтэй хариулагчдын 32.0 хувь нь аавууд, 68.0 хувь нь ээжүүд, харин жонш олборлож байгаа хүүхэдтэй хариулагчдын 31.2 хувь нь аавууд, 68.8 хувь нь ээжүүд байлаа (Хүснэгт 5.2). Тэдний дундаж нас алт олборлож байгаа хүүхэдтэй аавынх 42.38, ээжийнх 39.95, жонш олборлож байгаа хүүхэдтэй аавынх 43.30, ээжийнх 38.50 байв.

Алт олборлож байгаа хүүхэдтэй хариулагчдын өрхийн ам бүлийн тооны хамгийн өндөр хувийг 2-4 ам бүлтэй өрхүүд (39.3 хувь) эзлэж байхад жонш олборлодог хүүхэдтэй хариулагчдын хувьд 5-6 ам бүлтэй өрхүүд (46.9 хувь) хамгийн өндөр хувийг эзлэж байна.



*Өзгичлэл 5.2* Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Сонгосон үзүүлэлтүүд	Олборлож буй ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Нас</b>						
36 хүртэл	10.3	25.3	20.5	10.0	36.4	28.1
36-40	28.2	28.9	28.7	20.0	22.7	21.9
41-45	33.3	22.9	26.2	20.0	27.3	25.0
46 ба дээш	28.2	22.9	24.6	50.0	13.6	25.0
<i>Дундаж нас</i>	<b>42.38</b>	<b>39.95</b>	<b>40.73</b>	<b>43.30</b>	<b>38.50</b>	<b>40.00</b>
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>						
2-4	38.5	39.8	39.3	20.0	27.3	25.0
5-6	28.2	41.0	36.9	50.0	45.5	46.9
7 ба түүнээс дээш	33.3	19.3	23.8	30.0	27.3	28.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>39</b>	<b>83</b>	<b>122</b>	<b>10</b>	<b>22</b>	<b>32</b>

Судалгаанд хамрагдсан өрхөд ашигт малтмал олборлодог хүүхдүүдийн тоог олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр хүснэгт 5.3-т харуулав.

*Өзгичлэл 5.3* Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн албан бусаар ашигт малтмал олборлодог хүүхдийн тоо, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Нэг өрхөд ашигт малтмал олборлодог хүүхдийн тоо								Дүн
	Алт				Жонш				
	1	2	3	Хариу- лагчдын тоо	1	2	3	Хариу- лагчдын тоо	
<b>Эцэг/эхийн гэрлэлтийн байдал</b>									
Гэрлэсэн/хамт амьдардаг	92.9	5.1	2.0	98	89.7	10.3	0.0	29	<b>100.0</b>
Бусад	83.3	12.5	4.2	24	100.0	0.0	0.0	3	<b>100.0</b>
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>									
2-4	93.7	6.3	0.0	48	100.0	0.0	0.0	8	<b>100.0</b>
5-6	86.7	11.1	2.2	45	93.3	6.7	0.0	15	<b>100.0</b>
7 ба түүнээс дээш	93.1	0.0	6.9	29	77.8	22.2	0.0	9	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	<b>91.0</b>	<b>6.6</b>	<b>2.5</b>	<b>122</b>	<b>90.6</b>	<b>9.4</b>	<b>0.0</b>	<b>32</b>	<b>100.0</b>

Алт олборлодог хүүхэдтэй хариулагчдын 80.3 хувь нь гэрлэсэн/хамтран амьдрагчтай, харин жонш олборлодог хүүхэдтэй хариулагчдын хувьд энэ үзүүлэлт 90.6 хувьтай байна. Гэрлэлтийн байдал хэдэн хүүхдээ ашигт малтмал олборлуулж байгаатай хэр зэрэг хамааралтай байдгийг авч үзэхэд алт олборлуулж байгаа эцэг/эхчүүдийн хувьд гэр бүлгүй байх тусам олон хүүхдээ алт олборлуулж байгаа хандлага ажиглагдаж байна. Харин жоншны хувьд гэр бүлгүй хариулагчдын тоо маш бага байгаа тул тайлбар өгөх боломжгүй юм.

Хүснэгтээс харахад ер нь өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам ашигт малтмал олборлож буй хүүхдүүдийн тоо нэмэгдэж байна гэж хэлж болохоор байна.

## 5.2 Өрхийн ахуйн нөхцөл

Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн өрхийн ахуйн нөхцлийн үзүүлэлтүүдийг авч үзье. Нийт хариулагчдын дийлэнх нь гэрт (алт 68.9 хувь, жонш 75.0 хувь) амьдарч байгаа боловч сууцны зориулалтын бус газарт амьдарч байгаа өрхүүд ч бас багагүй байна (алт 1.6 хувь жонш 3.1 хувь). Судалгааны явцад ялангуяа, чингэлэг, майхан, овоохойд амьдарч алт олборлодог өрхүүд цөөн биш байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

*Огноо 5.4* Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд	Олборлож буй ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Сууцны төрөл</b>		
Гэр	68.9	75.0
Сууцны тусдаа байшин	16.4	15.6
Нийтийн сууцны байшин доторх сууц	13.1	6.3
Бусад	1.6	3.1
<b>Сууцны эзэмшил</b>		
Өөрийн эзэмшлийн	91.0	81.3
Өөрийн эзэмшлийн бус:		
Түрээслэн сууж байгаа	5.7	3.1
Ажил олгогчийн сууцанд төлбөргүй сууж байгаа	0.0	3.1
Хамаатан/Найз/Танилын сууцанд төлбөргүй сууж байгаа	3.3	9.4
Албаны сууцанд төлбөргүй	0.0	3.1
<b>Сууцаа бусадтай хамтран эзэмшиж буй эсэх</b>		
Тийм	12.3	15.6
Үгүй	87.7	84.4
<b>Сууцаа үнэлсэн байдал</b>		
Муу	12.3	21.9
Дунд зэрэг	60.7	46.9
Сайн	27.0	31.3
<b>Ундны усны эх үүсвэр</b>		
Төвлөрсөн усан хангамж	9.8	9.4
Хамгаалалттай худаг	43.4	50.0
Хамгаалалтгүй худаг	18.9	37.5
Булаг, шанд, рашаан	18.9	3.1
Гол	9.0	0.0
<b>Хоолоо хийхдээ ашигладаг эрчим хүчний эх үүсвэр</b>		
Цахилгаан	9.0	18.8
Мод	59.8	25.0
Нүүрс	4.1	9.4
Аргал	27.0	46.9
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>122</b>	<b>32</b>

Хариулагчдын дийлэнх нь амьдарч буй сууцаа дунд зэрэг гэж үнэлсэн боловч, ялангуяа жонш олборлодог таван өрх тутмын нэг нь өөрийнхөө сууцыг муу гэж үнэлжээ.

Ашигт малтмал олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийн тал орчим хувь нь ундныхаа усыг баталгаатай худагнаас авч хэрэглэдэг ажээ. Гэхдээ энд анхаарал татсан нэг асуудал алт олборлож байгаа газруудын өрхүүдийн баталгаагүй ундны хэрэглээний асуудал юм. Хүснэгтээс харахад алт олборлож байгаа өрхүүдийн 27.9 хувь ил задгай ус ундандаа хэрэглэдэг гэж хариулжээ.

Хоол хийдээ ашигладаг эрчим хүчний хувьд алт, жонш олборлодог өрхүүдийн эрчим хүчний эх үүсвэр нэлээд ялгаатай байна. Алт олборлодог өрхүүдийн дийлэнх буюу 59.8 хувь нь хоол хийхдээ мод, ашигладаг бол жонш олбордог өрхүүдийн 46.9 хувь нь аргал ашигладаг гэж хариулсан байна. Мөн жонш олборлодог дөрвөн өрхийн нэг нь цахилгаан эрчим хүч хэрэглэдэг гэжээ. Эндээс харахад ашигт малтмалын газар зүйн байршил, дэд бүтцийн хөгжил ашигладаг эрчим хүчний эх үүсвэртэй нэлээд уялдаатай байдаг нь харагдаж байна.

Алт олборлож байгаа хүүхэдтэй өрхийн 29.5 хувь, жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхийн дөнгөж 15.6 хувь нь л хувьдаа малтай юм байна. Өрхөд байгаа малын төрлөөр авч үзэхэд голчлон хонь, ямаатай, харин адуу, үхэр дунджаар нэг өрхөд цөөн тоотой байна (Хүснэгт 5.5).

*ᠪᠢᠶᠢᠨᠠᠨᠢ* 5.5 Судалгаанд хамрагдсан малтай өрхийн малын дундаж тоо, малын болон олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Малын төрөл	Өрхийн дундаж малын тоо	
	Алт	Жонш
Хонь	23.14	15.00
Ямаа	38.97	14.80
Үхэр	4.92	0.00
Адуу	3.58	0.60
Тэмээ	0.64	0.00
<b>Малтай өрхийн тоо</b>	<b>36</b>	<b>5</b>

Хүснэгтээс харахад нэг өрхөд ногдох малын тоо маш бага байгаа нь харагдаж байна. Эндээс ихэвчлэн малаа барсан, эсвэл цөөн тооны малтай өрхүүд л алт/жонш олборлож, амьжиргаагаа залгуулдаг гэж дүгнэж болохоор байна.

### 5.3 Шилжих хөдөлгөөн


Сүүлийн жилүүдэд дотоод шилжих хөдөлгөөний нэг гол урсгал бол албан бусаар ашигт малтмал олборлох боломжтой газар руу түр болон бүрмөсөн шилжиж байгаа өрх, хувь хүмүүсийн урсгал билээ. Харамсалтай нь энэ удаагийн судалгаа нэлээд хүйтэрсэн хойно явагдсан учраас богино хугацаагаар бусад аймаг, хотоос ирж алт олборлодог хүмүүсийг сайн хамруулж чадсангүй. Нутгийн хүмүүс зуны улиралд хүмүүс хамгийн их цуглардаг, мөн хүүхдүүд зуныхаа амралтаар их ирж ажилладаг тухай ярьж байсан.

Судалгаанд хамрагдсан алт олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдийн хариултаас харахад эдгээр өрхүүдийн 27.9 хувийг шилжигч өрх эзлэж байна. Шилжигч өрхүүдийн 41.2 хувь нь түр оршин суугаа, үлдсэн 58.8 хувь нь тухайн орон нутагт 5 хүрэхгүй жил амьдарч байгаа өрхүүд байлаа. Харин жонш олборлож буй хүүхэдтэй, судалгаанд хамрагдсан нийт 35 өрхийн гурав нь түр оршин суугаа, хоёр нь 5 хүрэхгүй жил тухайн газраа оршин суугаа шилжигчид байв.

Алт олборлож байгаа шилжин ирсэн өрхүүдийг бүсээр ангилж үзэхэд Баруун бүс, Хангайн бүс болон Төвийн бүс тус бүр 8.8 хувь, Зүүн бүс 2.9 хувь, нийслэл 11.8 хувь, тухайн аймгийн бусад сумаас шилжин ирэгсэд 58.8 хувийг тус тус

эзлэж байна. Жонш олборлож байгаа шилжигч өрхүүдийн тухайд гэвэл 2 өрх Төвийн бүсээс, 2 өрх Зүүн бүсээс, 1 өрх нийслэлээс ирж ажиллаж байна.

Алт олборлож буй өрхүүдийн шилжин ирсэн гол шалтгаан нь давхардсан тоогоор алтны уурхайд ажиллах (41.2 хувь), ашиг орлогоо нэмэгдүүлэх (27.9 хувь) гэсэн шалтгаан байгаа бол жонш олборлодог өрхийн хувьд амьжиргаагаа сайжруулах, жоншны уурхайд ажиллах (тус бүр 33.3 хувь) гэсэн хариултууд зонхилж байна (Зураг 5.1).



Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдээс цаашид тэдний өрх шилжих хөдөлгөөнд оролцох эсэх, өөрөөр хэлбэл тухайн хариулагчдын амьдарч буй өрх ирээдүйд шилжих хөдөлгөөнд оролцох хүсэлтэй байгаа эсэхийг тодруулахад алт олборлож байгаа хүүхэдтэй эцэг/эхчүүдийн 22.1 хувь, жонш олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдийн 6.3 хувь нь (2 хүн) цаашид манай өрх өөр аймаг/сум руу шилжинэ гэж хариулсан.

Алт олборлож байгаа хүүхэдтэй, ирээдүйд шилжих хүсэлтэй байгаа эцэг/эхчүүдийн хувийн жинг шалтгаанаар Зураг 5.2-т харуулав.

Алт олборлож байгаа, ирээдүйд шилжих хүсэлтэй эцэг/эхчүүдийн 44.4 хувь нь хүүхдийнхээ ирээдүйг бодож, 40.7 хувь нь амьжиргаагаа дээшлүүлэхээр хот руу нүүнэ гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзлэж байна. Тэдний нүүхээр төлөвлөж байгаа хугацааг сонирхвол, дөрвөн эцэг/эх тутмын нэг нь 1-3 сарын дараа, 29.6 хувь нь 4-12 сарын дараа, 18.5 хувь нь 1 жилээс дээш хугацааны дараа, үлдсэн хэсэг нь хэзээ нүүхээ төлөвлөөгүй байна.

Жич: жонш олборлодог хүүхэдтэй хоёр хариулагчдын нэг нь ажил олохоор, нөгөө нь хүүхдийнхээ ирээдүйг бодож, хот руу нүүнэ гэжээ.


Харин шилжихийг хүсэхгүй байгаа хариулагчдын дийлэнх нь нутаг усандаа дасан зохицсон (алт 48.4 хувь, жонш хоёр хүний нэг нь), уурхайгаа бараадах (алт 28.4 хувь, жонш хоёр хүний нэг нь) гэсэн шалтгаануудыг нэрлэж байлаа.




#### 5.4 Өрхийн орлого ба амьжиргаа

Алт/жонш олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдээс тухайн өрхийн сарын дундаж орлогын хэмжээг асуухад алт олборлож байгаа өрхийн хувьд сарын дундаж орлого дунджаар 114906 төгрөг байхад жонш олборлож байгаа өрхийн хувьд 126500 төгрөг байлаа.

Өрхийн сарын дундаж орлогыг интервалт түвшний үзүүлэлтээр ангилан үзвэл, судалгаанд амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрх алт олборлож буй өрхийн хувьд 12 (9.8 хувь), жонш (15.6 хувь) олборлож буй өрхийн хувьд 5 байна. Энд нэг анхаарал татсан үзүүлэлт бол 150000 төгрөгөөс дээш орлоготой өрхийн эзлэх хувийн жингээр жонш олборлодог өрхийнх алт олборлодог өрхүүдээс 17.0 пунктээр өндөр байгаа явдал юм (Зураг 5.3).



Өрхийн сарын дундаж орлогын бүтцийг олборлодог ашигт малтмалын төрлөөр дундачлаж тооцож Зураг 5.4-т харуулав.



Дээрх тооцооноос өрхийн сарын дундаж орлогын бүтцийг дунджаар ер нь өрхүүд юуны орлогоос бүрдүүлж байна вэ гэдгийг харж болно. Эндээс судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын дундаж орлогын 70 орчим хувийг алт/жонш олборлолтоос олсон орлого бүрдүүлдэг юм байна.

Энэхүү орлого тухайн өрхүүдийн амьжиргаанд хэр хүрэлцээтэй байдаг талаар авч үзье (Хүснэгт 5.6).

Алт олборлодог эцэг/эхчүүдийн талаас илүү хувь нь өрхийн сарын дундаж орлого амьжиргаанд нь хүрэлцдэггүй, 7.4 хувь нь хангалттай хүрэлцдэг гэж хариулжээ. Харин жонш олборлодог эцэг/эхчүүдийн хувьд өрхийн сарын дундаж орлого хангалттай хүрэлцдэг гэсэн хариулт байгаагүй ба дөрвөн хүн тутмын гурав нь амьжиргаанд хүрэлцдэггүй, нэг нь дунд зэрэг хүрэлцдэг гэсэн хариултыг өгчээ.

Мөн өрхийн ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр сарын дундаж орлого өрхөд хүрэлцдэггүй гэсэн хариултын хувь нэмэгдэж байгаа ба тухайн өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр хангалттай гэсэн хариултын хувь нэмэгдэх хандлагатай байна.

Судалгаанд оролцсон эцэг/эхийн ажил эрхлэлтийн байдал өрхийн сарын дундаж орлого хүрэлцээтэй эсэхтэй хамааралтай байна уу гэдгийг судалж үзэхэд, хувьдаа бизнес эрхэлдэг, малчин хариулагчдын өрхийн сарын дундаж орлого амьжиргаанд хангалттай хүрэлцдэг гэж хариулсан хувь бусдаас өндөр байсныг тэмдэглэх нь зүйтэй.

*ᠪᠦᠵᠡᠨᠢ ᠶ᠋ᠢᠳᠤ 5.6* Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн орлого нь амьжиргаанд хүрэлцдэг эсэх, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Өрхийн орлого амьжиргаанд нь хангалттай хүрэлцдэг эсэх								Бүгд
	Алт				Жонш				
	Хангалт-Тай	Дунд зэрэг	Хангалт-гүй	Хариу-лагчдын тоо	Хангалт-тай	Дунд зэрэг	Хангалт-гүй	Хариу-лагчдын Тоо	
<b>Хариулагчийн шилжилтийн байдал</b>									
Шилжигч	8.8	38.2	52.9	34	0.0	20.0	80.0	5	100.0
Шилжигч бус	6.8	37.5	55.7	88	0.0	25.9	74.1	27	100.0
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>									
2-4	10.4	43.8	45.8	48	0.0	25.0	75.0	8	100.0
5-6	6.7	33.3	60.0	45	0.0	33.3	66.7	15	100.0
7 ба түүнээс дээш	3.4	34.5	62.1	29	0.0	11.1	88.9	9	100.0
<b>Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)</b>									
40000, түүнээс бага	8.3	33.3	58.3	12	0.0	0.0	100.0	5	100.0
40001-60000	0.0	26.7	73.3	15	0.0	20.0	80.0	5	100.0
60001-90000	3.2	25.8	71.0	31	0.0	50.0	50.0	2	100.0
90001-120000	0.0	45.0	55.0	20	0.0	33.3	66.7	6	100.0
120001-150000	15.8	47.4	36.8	19	0.0	0.0	100.0	2	100.0
150001 ба дээш	16.0	48.0	36.0	25	0.0	33.3	66.7	12	100.0
<b>Бүгд</b>	<b>7.4</b>	<b>37.7</b>	<b>54.9</b>	<b>122</b>	<b>0.0</b>	<b>25.0</b>	<b>75.0</b>	<b>32</b>	<b>100.0</b>

Зураг 5.5-д өрхийн сарын орлогын дийлэнхийг бүрдүүлэгчийн эзлэх хувийн жинг ашигт малтмалын төрлөөр харуулав.



Олборлож байгаа ашигт малтмалын аль ч төрөлд ялгаагүй өрхийн сарын дундаж орлогын дийлэнхийг өрхийн тэргүүлэгч (алт 57.4 хувь, жонш 62.5 хувь) бүрдүүлдэг гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байна.

Энд анхаарал татсан нэг зүйл бол алт олборлож буй өрхүүдийн хувьд өрхийн орлогын дийлэнхийг хүүхэд бүрдүүлдэг гэж хариулсан эцэг/эхийн эзлэх хувь багагүй (13.1 хувь) байгаа явдал юм. Харин жонш олборлодог өрхийн хувьд ийм хариулт байсангүй.

Судалгаанд оруулсан бас нэг сонирхолтой асуудал бол алт/жонш олборлож байгаа өрхүүдийн ам бүл өдөр болгон хангалттай хооллож чадаж байна уу гэдэг талаар судлах явдал юм. Хэдийгээр хоолны чанар, илчлэгийн талаар нарийвчлан асуулга оруулаагүй боловч хоол гэдэгт бид зөвхөн халуун хоол гэдэг ойлголтын хүрээнд авахаар гарын авлагатаа тусгасан юм.

*Оᠵᠢᠶ᠋ᠠᠳ 5.7 Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн гишүүд нь хангалттай хооллож чаддаг эсэх, ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Өрхийн гишүүд нь өдөр бүр хангалттай хооллож чаддаг эсэх								Бүгд
	Алт				Жонш				
	Байнга	Зарим-даа	Ховор/үгүй	Хариулагчдын тоо	Байнга	Зарим-даа	Ховор/үгүй	Хариулагчдын тоо	
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>									
2-4	53.8	33.3	8.3	48	62.5	37.5	0.0	8	<b>100.0</b>
5-6	44.4	48.9	6.7	45	26.7	66.7	6.7	15	<b>100.0</b>
7 ба түүнээс дээш	27.6	62.1	10.3	29	33.3	55.6	11.1	9	<b>100.0</b>
<b>Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)</b>									
40000, түүнээс бага	33.3	50.0	16.7	12	20.0	80.0	0.0	5	<b>100.0</b>
40001-60000	26.7	53.3	20.0	15	0.0	100.0	0.0	5	<b>100.0</b>
60001-90000	32.3	58.1	9.7	31	100.0	0.0	0.0	2	<b>100.0</b>
90001-120000	55.0	45.0	0.0	20	33.3	33.3	33.3	6	<b>100.0</b>
120001-150000	52.6	36.8	10.5	19	50.0	50.0	0.0	2	<b>100.0</b>
150001 ба дээш	68.0	32.0	0.0	25	50.0	50.0	0.0	12	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	<b>45.9</b>	<b>45.9</b>	<b>8.2</b>	<b>122</b>	<b>37.5</b>	<b>56.3</b>	<b>6.3</b>	<b>32</b>	<b>100.0</b>

Алт олборлож буй хүүхэдтэй өрхийн эцэг/эхчүүдийн хариулснаар эдгээр өрхүүдийн 45.9 хувь нь өдөр болгон байнга хооллодог байхад ховор, хооллодоггүй (8.2 хувь) гэж хариулагчдын эзлэх хувийн жин ч багагүй байна.


Жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхийн хувьд өдөр болгон байнга хооллодог гэж хариулсан хариултын хувь алт олборлодог өрхийнхөөс 8.4 пунктээр доогуур, харин ховор, хооллодоггүй гэсэн хариулт 1.9 пунктээр бага байна.

Хүснэгтээс харахад өрхийн сарын дундаж орлогын хүрэлцээтэй эсэх талаарх хариулттай ижил ам бүлийн тоо нэмэгдэх тутам өдөр болгон байнга хооллодог гэсэн хариултын хувь буурч, харин өрхийн сарын дундаж орлогын хэмжээ нэмэгдэх тутам өдөр болгон байнга хооллодог гэсэн хариултын хувь нэмэглэж байна. Харин эсрэгээр ховор, хооллодоггүй гэсэн хариултын хувь ам бүлийн тоо нэмэгдэх тусам өсч, өрхийн сарын дундаж орлогын хэмжээ буурах тутам нэмэгдэж байна. Энэ хандлага олборлож буй ашигт малтмалын төрлөөр ялгаагүй ижил байна.

Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдээс сургуулийн өмнөх насны хүүхэдтэй юу гэж асуухад алт олборлож байгаа хүүхэдтэй хариулагчдын 28.7 хувь, жонш олборлож байгаа хүүхэдтэй эцэг/эхчүүдийн 40.6 хувь нь “Тийм” бага насны



хүүхэдтэй гэсэн хариултыг өгсөн. Алт олборлодог, бага насны хүүхэдтэй өрхүүдийн тэн хагасынх нь эцэг, эх хоёулаа алтны уурхай дээр ажилладаг юм байна (Зураг 5.6 а).



Энд сонирхол татсан нэг зүйл бол бага насны хүүхэдтэй эцэг, эх хоёулаа алт олборлодоггүй гэж хариулсан хувь нэлээд өндөр (25.7 хувь) байхад жоншин дээр энэ хариулт байсангүй. Түүнээс гадна бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүүхдээ ажилдаа дагуулж явдаг (30.8 хувь), мөн ах/эгч нь хардаг (28.2 хувь) гэсэн хариулт нэлээд өндөр хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан алт/жонш олборлож байгаа хүүхэдтэй өрхүүдийн гэр бүлийнхэн өвдсөн үедээ ихэвчлэн эмнэлэгт (алт 76.2 хувь, жонш 87.5 хувь) ханддаг ажээ.

Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжгүй гэж хариулагчдын эзлэх хувь алт олборлогчдын хувьд 4.9 хувь, жонш олборлогчдын хувьд 3.1 хувьтай байна. Алт/жонш олборлож буй өрхүүд нийгмийн үйлчилгээнээс хүртэх боломж хязгаарлагдмал байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тодруулбал, алт олборлогчдын 39.3 хувь нь жижиг зээлийн үйлчилгээ, 47.5 хувь нь боловсролын хөтөлбөр, 41.0 хувь нь ажлын байрны төсөл, хөтөлбөр, 45.1 хувь нь газар тариалан, мал аж ахуйн төсөл, хөтөлбөрөөс хүртэх боломжтой байгаа бол жонш олборлогчдын 50.0 хувь нь жижиг зээлийн үйлчилгээ, 43.8 хувь нь боловсролын хөтөлбөр, 31.3 хувь нь ажлын байрны төсөл, хөтөлбөр, 25.0 хувь нь газар тариалан, мал аж ахуйн төсөл, хөтөлбөрөөс хүртэх боломжтой гэж хариулжээ.

**Өгөгдөл 5.1**

“*Öîãðàíððîé àì ìæèðääà*” ò<sup>°</sup>ñ<sup>°</sup>ë ì àíàé ñòì àíä 2 æèè ääðóé òóääòääíä òýðÿæèæ áàéääà àà áàéáòéèääà, òóáü òçì ççñò 300 ì ÿíääàñ 1 ñàÿ òçðòéÿò ò<sup>°</sup>ãð<sup>°</sup>äèí æèæèä çÿÿèèä ìèáíæ áàéíà. Ýíÿ ò<sup>°</sup>ñèèéí òçðÿÿíä 300 ì ÿíääí ò<sup>°</sup>ãð<sup>°</sup>äèí çÿÿè äääàà ì àèæñàí òçì ÷ áàéíà. Ì<sup>°</sup> í áóðàè, òàèòí ù óäð àæèèòóòéæ, àì ìäðäèà àççèççèñÿí<sup>°</sup>ðð, òçì ççñ òÿä òÿä áàéääà.

(*Ì . ÿí ÿäòÿé, 40 íáñðàé, <sup>a</sup> ì í<sup>°</sup>áíäü, Öîãð-Ì áíî*),


## 5.5 Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх эцэг/эхийн бодол

Эцэг/эхчүүдээс алт/жоншны уурхайд ажиллаж байгаа хүүхдүүд тань та нартай хамт амьдардаг уу гэж асуухад хариулагчдын дийлэнх нь “Тийм” (алт 95.1 хувь, жонш 100.0 хувь) гэсэн хариултыг өгсөн. Хүүхэд нь алт олборлож байгаа, эцэг, эхтэйгээ гэртээ амьдардаггүй 6 хүүхдийн 1 нь ажил олгогчийндоо, үлдсэн 5 нь хамаатан, найз нөхдийндөө амьдардаг ажээ.

Эдгээр хүүхдүүдийн 2 нь өдөр болгон гэртээ очдог бол бусад нь 2.3 хоногт, хагас сард, сард нэг удаа гэртээ очдог юм байна.

Энд анхаарал татсан нэг асуудал бол эцэг, эхчүүдийн 66.2 хувь нь хүүхдүүдийнхээ алт/жонш олборлож байгааг хүлээн зөвшөөрдөг гэж хариулсан байна.


Ямар шалтгааны улмаас алт жонш олборлох ажил хийхийг хүлээн зөвшөөрөх болов оо гэдгийг ашигт малтмалын төрлөөр Зураг 5.7-д харуулав.



Алт/жонш олборлох ажил хийхийг хүлээн зөвшөөрч байгаа гол шалтгаан нь давхардсан тоогоор өрхийн амьжиргаанд тус болдог учраас (алт 98.8 хувь, жонш 100.0 хувь), хүүхэд бие даан амьдарч сурна, ажлын дөртэй болно (алт 38.3 хувь, жонш 9.5 хувь), хүүхэд боловсролынхоо зардлыг олдог (алт 25.9 хувь, жонш 9.5 хувь) гэсэн хариултууд байлаа. Түүнээс гадна алт олборлодог хүүхдээ ажиллахыг хүлээн зөвшөөрдөг шалтгаанд хүүхэд тэндээ хоолоо олж иддэг гэсэн хариулт нэлээд өндөр хувьтай (21.0 хувь) байсан. Харамсалтай нь алт, жоншны аль алин дээр ажлын нөхцөл тийм ч муу биш гэж хариулсан хувь багагүй байна.

Харин хүүхдээ алт/жонш олборлохыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа эцэг/эхчүүдийн шалтгааныг тодруулахад: хүүхэд сургуульд явах ёстой (алт 51.2 хувь, жонш 45.5 хувь), хүүхэд эрүүл мэндээр хохирдог (алт 58.5 хувь, жонш

54.5 хувь), ажлын нөхцөл хүнд (алт 63.4 хувь, жонш 63.6 хувь) гэсэн шалтгаанууд ашигт малтмалын аль ч төрөлд зонхилж байна. Хүүхэд нь алт олборлодог эцэг/эхчүүдийн хүүхэд хүчирхийлэлд өртдөг учраас алт олборлохыг хүлээн зөвшөөрдөггүй гэсэн хариулт 12.2 хувийг эзлэж байна (Зураг 5.8).



Хүснэгт 5.8-д Эцэг/эхчүүдийн хүүхдийнхээ ажлын нөхцөлийг үнэлж байгаа байдлыг олборлож буй ашигт малтмалын төрлөөр харуулав.

Эцэг/эхчүүдийн дийлэнх нь алт/жонш олборлож байгаа хүүхдүүдэд маань өдрийн ажлынхаа үеэр түр амрах, алжаалаа тайлах цаг гардаггүй (алт 93.4 хувь, жонш 96.9 хувь) гэж хариулсан бол алжаалаа тайлах, амрах цаг байдаг эсэхийг мэддэггүй (алт 3.3) эцэг/эхчүүд ч мөн байна. Харин ажлын үеэр цангаагаа тайлах, хооллох боломж ихэнх хүүхдүүдэд байдаг гэж эцэг/эхүүд боддог юм байна.


Алт/ жонш олборлох ажлын нөхцөлийг таван эцэг/эх тутмын дөрөв нь хүнд, хортой гэж үздэг бол ажлын нөхцөл нь хөнгөн гэж үнэлдэг эцэг/эхчүүд ч бас байна. Ялангуяа энэ хариултын хувь жонш олборлодог хүүхэдтэй эцэг/эхчүүдийн хувьд алт олбордог хүүхэдтэй эцэг/эхчүүдийнхээс 2 дахин өндөр байв.

Түүнчлэн хоногт хүүхдүүд маань 9 ба түүнээс дээш цаг ажилладаг (алт 29.5 хувь, жонш 31.2 хувь), маш их ядардаг (алт 69.7 хувь, жонш 75.0 хувь), гэсэн хариултын хувь бусдаас өндөр байна. Сэтгэл эмзэглүүлсэн нэг зүйл бол хүүхдийнхээ хөдөлмөрийн нөхцөлийг мэддэггүй, анзаардаггүй, ажлын нөхцөл нь боломжийн гэж боддог эцэг/эхүүд бага ч гэсэн байдаг нь тун харамсалтай.

**ᠪᠦᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ 5.8 ᠡᠴᠡᠭ/ᠡᠬᠡᠴᠦᠳᠦᠢᠨ ᠬᠤᠪᠢᠨ ᠵᠢᠨ, ᠬᠦᠬᠦᠳᠢᠨᠬᠡᠭᠡ ᠠᠵᠢᠯᠢᠨ ᠣᠷᠴᠢᠨ, ᠨᠥᠬᠡᠴᠢᠯᠢᠭ ᠦᠨᠡᠯᠵᠡ ᠪᠦᠶᠡᠳᠠᠯ, ᠣᠯᠪᠣᠷᠯᠣᠵᠡ ᠪᠦᠶᠡ ᠠᠰᠢᠭᠲᠡ ᠮᠠᠯᠲᠮᠠᠯᠢᠨ ᠲᠣᠷᠯᠣᠣᠷ**

Хүүхдийн ажлын орчин, нөхцлийн талаарх эцэг/эхийн үнэлгээ	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Өдрийн ажлын үеэр түр амрах, алжаалаа тайлах боломж гардаг эсэх</b>		
Байдаггүй	93.4	96.9
Байхгүй	3.3	3.1
Мэдэхгүй	3.3	0.0
<b>Өдрийн ажлын үеэр цангаагаа тайлах боломж байдаг эсэх</b>		
Байдаг	94.3	96.9
Байдаггүй	4.1	0.0
Мэдэхгүй	1.6	3.1
<b>Өдрийн ажлын үеэр хооллох боломж байдаг эсэх</b>		
Байдаг	92.6	100.0
Байдаггүй	4.9	0.0
Мэдэхгүй	2.5	0.0
<b>Хүүхдийн ажлын нөхцөл</b>		
Хүнд/хортой	80.3	81.3
Хүндэвтэр	17.2	12.5
Хөнгөн	2.5	6.3
<b>Хоногийн ажлын цаг</b>		
1-4 цаг	17.2	21.9
5-6 цаг	17.2	25.0
7-8 цаг	21.3	21.9
9, түүнээс дээш	29.5	31.2
Мэдэхгүй	14.9	0.0
<b>Долоо хоногт хэдэн өдөр ажилладаг</b>		
1-3 хоног	19.7	28.1
4-5 хоног	21.3	18.8
6-7 хоног	49.2	53.1
Мэдэхгүй	9.8	0.0
<b>Ажил хийхэд хүүхэд ядардаг эсэх</b>		
Их ядардаг	69.7	75.0
Дунд зэрэг	20.5	12.5
Нэг их ядардаггүй	4.1	9.4
Мэдэхгүй/Анзаардаггүй	5.7	3.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>122</b>	<b>32</b>

Одоо алт/жонш олборлож байгаа хүүхдүүдийн маань ажлын нөхцөл хүнд гэж хариулсан эцэг/эхчүүдийн яагаад хүнд гэж бодож байгаа шалтгааныг тодруулъя.



Эцэг/эхчүүдийн үзэж байгаагаар алт олборлох ажлыг хүүхэд эрхлэхэд хүнд гэж үзэж байгаа хамгийн гол гурван шалтгаанд давхардсан тоогоор *íýää¿áýýðò*, тоосжилт ихтэй (78.2 хувь), *õĭ, ðáóääàðò*, аюултай эрсдэлтэй (68.1 хувь), *ãòðääáòääàðò*, хүнд ачаа үүрдэг (64.7 хувь) гэсэн шалтгаанууд орж байхад харин жонш олборлодог хүүхдүүдийн хувьд *íýää¿áýýðò*, тоосжилт ихтэй, хүнд ачаа үүрдэг (тус бүр 63.3 хувь), *õĭ, ðáóääàðò*, хортой нөхцөлд ажилладаг (50.0 хувь), *ãòðääáòääàðò*, аюултай эрсдэлтэй (43.3 хувь) гэсэн шалтгаанууд орж байна.

Судалгаанд хамрагдагсан эцэг/эхчүүдээс тэдний мэдлэгийг сорих зорилгоор “Та 18 насанд хүрээгүй хүүхэд уурхайд ажиллахыг хуулиар хориглосон гэдгийг мэдэх үү” гэж асуухад хүүхэд нь алт олборлож байгаа эцэг/эхчүүдийн 77.9 хувь, хүүхэд нь жонш олборлож байгаа эцэг/эхчүүдийн 87.5 хувь нь “Мэднэ” гэж хариулсан.

Ер нь эцэг /эхчүүд хүүхдийнхээ хөдөлмөрийн хөлсийг хэр зэрэг үнэлж чадаж байгаа талаар судалгаанд асуулга оруулсан юм (Хүснэгт 5.9).

*᠋ᠣᠵᠢᠨᠢᠶ᠋ᠠᠳᠤ 5.9* Эцэг/эхчүүдийн хувийн жин, хүүхдийнхээ ажлын хөлсийг үнэлж байгаа байдал, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхдийнхээ ажлын хөлсийг үнэлж буй байдал						Бүгд
	Алт			Жонш			
	Бага	Дунд	Өндөр	Бага	Дунд	Өндөр	
<b>Хариулагчийн хүйс</b>							
Эрэгтэй	30.8	51.3	17.9	20.0	60.0	20.0	<b>100.0</b>
Эмэгтэй	18.1	53.0	28.9	27.3	59.1	13.6	<b>100.0</b>
<b>Хариулагчийн нас</b>							
36 хүртэл	8.0	56.0	36.0	44.4	44.4	11.2	<b>100.0</b>
36-40	22.9	57.1	20.0	0.0	85.7	14.3	<b>100.0</b>
41-45	31.3	37.5	31.3	25.0	50.0	25.0	<b>100.0</b>
46 ба түүнээс дээш	23.3	60.0	16.7	25.0	62.5	12.5	<b>100.0</b>
<b>Хариулагчийн боловсрол</b>							
Боловсролгүй	20.0	60.0	20.0	0.0	0.0	0.0	<b>100.0</b>
Бага	25.0	41.7	33.3	50.0	50.0	0.0	<b>100.0</b>
Бүрэн бус дунд	24.5	53.1	22.4	6.3	75.0	18.8	<b>100.0</b>
Бүрэн дунд	14.3	52.4	33.3	36.4	45.5	18.2	<b>100.0</b>
Бүрэн дундаас дээш	35.7	57.1	7.1	66.7	33.3	0.0	<b>100.0</b>
<b>Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)</b>							
40000, түүнээс бага	25.0	58.3	16.7	20.0	80.0	0.0	<b>100.0</b>
40001-60000	40.0	40.0	20.0	0.0	80.0	20.0	<b>100.0</b>
60001-90000	35.5	41.9	22.6	0.0	50.0	50.0	<b>100.0</b>
90001-120000	5.0	75.0	20.0	50.0	50.0	0.0	<b>100.0</b>
120001-150000	21.1	47.4	31.6	0.0	50.0	50.0	<b>100.0</b>
150001 ба дээш	8.0	56.0	36.0	33.3	50.0	16.7	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	22.1	52.5	25.4	25.0	59.4	15.6	<b>100.0</b>

Хүснэгтээс харахад эцэг/эхчүүдийн талаас илүү хувь нь хүүхдүүдийнхээ алт/жонш олборлолтоос олсон ажлын хөлсийг өрхийн амьдралд дунд зэрэг хувь нэмэр болдог гэж үздэг юм байна. Энд нэг анхаарал татсан зүйл бол алт, жоншны аль алинд бүрэн дундаас дээш боловсролын түвшинтэй эцэг/эхийн хүүхдийнхээ ажлын хөлсийг бага хувь нэмэр оруулдаг гэж хариулсан хувь бусад хариултаас өндөр байгаа явдал юм. Мөн алт олборлодог хүүхэдтэй аавуудын хүүхдийнхээ ажлын хөлсийг өрхөд бага хувь нэмэр оруулдаг гэсэн хариултын хувь ээжүүдийн өгсөн хариултын хувиас 1.7 дахин бага байгаа нь нэлээд сонирхол татлаа.

Ажил хийснээр хүүхдүүдийнх нь эрүүл мэндэд тулгарч болох эрсдэлийн талаарх эцэг/эхчүүдийн үнэлгээг Хүснэгт 5.10-г харуулав.

Алт/жонш олборлох ажил хүүхдийн эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй гэж нийт хариулагчдын гуравны хоёроос илүү хувь нь хариуллаа. Энэ хариултын хувь боловсролын түвшин дээшлэх тутам алт жоншны аль алинд нэмэгдэж байна. Эрсдэлгүй гэж хариулсан эцэг/эхийн хувь ч тодорхой хэмжээтэй байгаа юм. Ялангуяа, алт олборлодог хүүхэдтэй 36-40 насны залуу, боловсрол багатай эцэг/эхчүүд бусдаас түлхүү хариулжээ. Жонш олборлож буй хүүхэдтэй эцэг/эхчүүдийн хувьд тоо нь бага байсан учраас дугнэх боломж муутай байна.

**Өзгөтэй 5.10 Эцэг/эхчүүдийн хувийн жин, ажил хийснээр хүүхдийн эрүүл мэндэд тулгарч болох эрсдэлийг үнэлсэн байдал, олборлож буй ашигт малтмалын төрөл, сонгосон үзүүлэлтүүдээр**

Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхдийн эрүүл мэндэд тохиолдож болох эрсдэлийн талаарх үнэлгээ								Бүгд
	Алт				Жонш				
	Эрсдэлгүй	Бага	Дунд	Өндөр	Эрсдэлгүй	Бага	Дунд	Өндөр	
<b>Хариулагчийн хүйс</b>									
Эрэгтэй	5.1	5.1	25.6	64.1	10.0	0.0	20.0	70.0	<b>100.0</b>
Эмэгтэй	4.8	3.6	26.5	65.1	0.0	4.5	18.2	77.3	<b>100.0</b>
<b>Хариулагчийн нас</b>									
36 хүртэл	0.0	8.0	24.0	68.0	0.0	0.0	11.1	88.9	<b>100.0</b>
36-40	11.4	2.9	20.0	65.7	0.0	0.0	28.6	71.4	<b>100.0</b>
41-45	0.0	3.1	37.5	59.4	12.5	12.5	25.0	50.0	<b>100.0</b>
46, түүнээс дээш	6.7	3.3	23.3	66.7	0.0	0.0	12.5	87.5	<b>100.0</b>
<b>Хариулагчийн боловсрол</b>									
Боловсролгүй	0.0	0.0	60.0	40.0	0.0	0.0	0.0	0.0	<b>100.0</b>
Бага	16.7	0.0	25.0	58.3	50.0	0.0	0.0	50.0	<b>100.0</b>
Бүрэн бус дунд	0.0	6.1	28.6	65.3	0.0	6.3	18.8	75.0	<b>100.0</b>
Бүрэн дунд	9.5	2.4	23.8	64.3	0.0	0.0	27.3	72.7	<b>100.0</b>
Бүрэн дундаас дээш	0.0	7.1	14.3	78.6	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	<b>4.9</b>	<b>4.1</b>	<b>26.2</b>	<b>64.8</b>	<b>3.1</b>	<b>3.1</b>	<b>18.8</b>	<b>75.0</b>	<b>100.0</b>

Хүүхдээ хүнд, хүчир, эрсдэл ихтэй хөдөлмөр хийхийг ямарч эцэг хүсдэггүй нь ойлгомжтой. Гэхдээ амьжиргааны түвшний доогуур байдал ихэнх хүүхдүүдийн алт/жонш олборлох гол шалтгаан болж байгаа нь судалгааны дүнгээс тод харагдаж байна. Иймээс эцэг/эхчүүд маань амьдралын ямар нөхцөл бололцоо бүрдвэл хүүхдүүдээ энэ хүнд хүчир ажлаас холдуулж чадах вэ гэсэн асуулт бидний өмнө тулгараад байна. Энэ талаар эцэг/эхчүүд юу бодож байдаг талаар ашигт малтмалын төрөл бүр дээр тус тусад нь авч үзье.

**Өгөгдөл 5.2**

Ад 1үү өлжөөлжээ нилээдэй 2 аеэеэ ай даеодаааа өөлж аеэе өеэяа айний. Ое-үүе дааеаеө өө ааеааа + юйя юо-лжээ йи ад 1үйи ааеэеаад өлжөөйү нодоооөйя нодооо нийеддөйе, өлнүйеөйе айеэюу. Айюуү чадеи юйя юо-лжээ өлжөөйү эцөйи наддаад өе-үүе дааеөөөай аа- үаааа. Ай уадаоуи юдоүүд адаааэе ааеааа айеааа юйя юо-лжээеэй өлжөөлжээ + өө өө өө. Ад 1үү ааеэеааа ааеөаа өлжөөйү аеэе өеөдөйя юйя юо аюуя цүдүүд 1 өө өө, цүйи өө элүүн өлжөөйү элжүүө аадаи ө өө ааеааа.  
(А.А, 45 1аандэе, йи үаөйе аеааи аон нодооөөуи адаа элэ-Аүйи дийий, Аүйи-1 айи)

**Өгөгдөл 5.3**

Йиä өлжөөлжээ 1едүй өйүй аеэүүн ө өө ааеэеаааа айний Ода 1үү аеий өеайдөйө ааеуя өий +оө өө өеэяа ааеаи. 1 айи айе юйя юо-лжээ өлжөөйү дааеөөөөө 1үдүүд аааооөө ааеөөөөөөаа ааеааа айеэюу. 1үйи аеий өеайдөйө ааеэ өлжөө өлжөө өө даааааа п1. Өлжөөлжээ үа ө өий +оө өө өө ааеэеаааа. Оадаи нөөөөөө 1үү 1едийн өлжөөлжээ өөднээ элүү айний өий +оөөэе ааеэ өеэяа айний ааея.  
(О.х, 41 1аандэе, үдүүдөйе, аеааи аоннаад аеий өеайдөйя-, Аой аайаа, Аүеүүдөаи аае)

Хүүхэд нь алт олборлож байгаа эцэг/эхчүүд дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд хүүхдүүд ажил эрхлэхээ болино гэж үзэж байна. Үүнд:

- Гэр бүл хангалттай орлоготой байх ( 80.3 хувь)
- Хүүхдийн боловсролд хангалттай мөнгөтэй болох ( 43.4 хувь)
- Боломжийн мал/газартай болох ( 34.4 хувь)
- Эрүүл мэндэд мөнгө хангалттай болох (16.4 хувь)
- Сургууль нь гэр ажилтай ойрхон болох ( 9.0 хувь)
- Сургуулийн чанар сайн болох ( 8.2 хувь)
- Өөрийн сонирхлоор ( 23.8 хувь)

Харин хүүхэд нь жонш олборлож байгаа эцэг эхчүүдийн хувьд:

- Гэр бүл хангалттай орлоготой байх ( 81.3 хувь)
- Хүүхдийн боловсролд хангалттай мөнгөтэй болох ( 25.0 хувь)
- Боломжийн мал/газартай болох ( 15.6 хувь)
- Эрүүл мэндэд мөнгө хангалттай болох (12.5 хувь)
- Сургуулийн чанар сайн болох ( 9.4 хувь)
- Өөрийн сонирхлоор ( 12.5 хувь) жонш олборлох ажил эрхлэхээ болино гэж үзэж байна.

Эцэг/эхийн хариулснаар алт олборлож байгаа хүүхдүүдийн 59.0 хувь нь албан сургалтанд, 2.5 хувь нь албан бус сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд үлдсэн 38.5 хувь нь сургуульд суралцдаггүй юм байна. Жонш олборлодог хүүхдүүдийн хувьд гэвэл 71.9 хувь нь албан сургалтанд, 6.2 хувь нь албан бус сургалтанд хамрагддаг бол 21.9 хувь нь сургуульд сурахгүй байна. Эндээс харахад хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин алт олборлож байгаа газруудад жонш олборлож байгаа газруудад харьцангуй өндөр байгаа нь харагдаж байна.

Бас нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд нийт эцэг/эхчүүдийн 92.9 хувь нь хэрвээ хүүхдүүд ажил хийхээ болиод сургуульдаа үргэлжлэн суралцана эсвэл сургуульд орно гэвэл ажил хийхийг нь зогсооно гэж хариулсан. Үүний дараа хүүхдүүдээ ямар боловсролтой болоосой гэж хүсэж байна вэ гэж асуухад судалгаанд хамрагдагчдын 91.5 хувь нь бүрэн дундаас дээш боловсрол эзэмшүүлмээр байна гэж хариуллаа. Харин боловсрол шаардлагагүй гэж хариулсан 2 хүнээс тэгвэл ямар дамжаанд суулгахыг хүсч байгааг асуухад хоёулаа жолооны курст оруулмаар байна гэв.



## **БҮЛЭГ 6. АЛБАН БУСААР АЛТ/ЖОНШ ОЛБОРЛОЖ БАЙГАА ХҮҮХДҮҮДЭД АЖИЛ ОЛГОГЧИД**

---

Энэхүү бүлэгт судалгаанд хамрагдсан ажил олгогчдын шинж байдал, хүүхдийн хөдөлмөрт хандаж буй байдал болон хүүхдийн хөдөлмөрийг үнэлж буй байдлын талаар авч үзэх болно. Судалгаагаар, "ажил олгогч" гэдгийг бид албан бусаар ат/жонш олборлох салбарт хөдөлмөрийн гэрээтэй болон гэрээгүйгээр 18 насанд хүрээгүй хүүхдийг шууд удирдлаган доороо ажиллуулж байгаа, эсвэл 18 нас хүрээгүй хүүхдийн ажилд нь удирдан, зохион байгуулах үүрэгтэйгээр оролцдог, ажилтай холбоотой аливаа шийдвэр гаргахад нь голлох үүрэг гүйцэтгэдэг 18 ба түүнээс дээш насны хүн байна гэж тодорхойлсон.

### **6.1. Ажил олгогчдын шинж байдал**

Судалгаанд хүүхдэд ажил олгогч нийт 44 хүн хамрагдсан ба тэдний 34 нь албан бусаар алт олборлогч, 10 нь жонш олборлогч хүмүүс байв. Албан бусаар алт/жонш олборлогч хүүхдүүд ихэвчлэн ажил олгогчгүйгээр бие даан, эсвэл гэр бүлийнхэнтэйгээ ажиллаж байгаа хандлага түгээмэл байснаас ийнхүү судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо цөөн байлаа.

Аймгаар нь харвал алт олборлох ажилд хүүхдийг ажиллуулж байгаа ажил олгогчдын тоо Төв аймагт 17, Өвөрхангай аймагт 7, Дундговь аймагт 6, Баянхонгор 3, Өмнөговь аймагт 1 байв. Харин жонш олборлогчдын хувьд энэ тоо Дундговь аймагт 6, Дорноговь аймагт 4 байлаа.

Хүүхдүүдэд ажил олгогч эдгээр хүмүүсийн ажиллаж буй газрын эзэмшлийг авч үзвэл, алт олборлогчдын 55.8 хувь (19 хүн) нь ашиглагдаад дууссан талбай, 32.4 хувь (14 хүн) нь хэн нэгний эзэмшлийн биш, лицензгүй газарт, харин 11.8 хувь буюу 4 хүн нь компаний мэдлийн талбай дээр ажиллагсад байв. Жонш олборлогчдын 80 хувь буюу 8 хүн нь компаний мэдлийн талбайд, харин 20 хувь (2 хүн) нь лицензгүй газарт ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдыг шинж байдлаар нь Хүснэгт 6.1-д харуулав. Алт олборлож буй ажил олгогчдын дундаж нас 34.9 байгаа ба 50 хувь нь 35.5-аас доош, үлдсэн нь 35.5-аас дээш насны хүмүүс байна. Харин жонш олборлогчдын 50 хувь 33.5-аас доош, үлдсэн нь түүнээс дээш настай байсан ба дунджаар 35.3 орчим насны хүмүүс байлаа. Эдгээрээс дүгнэвэл ажил олгогчид харьцангуй залуу насны хүмүүс байна.

Хүйсийн хувьд алт олборлож буй ажил олгогчдын 76.5 хувь (26 хүн), жонш олборлогчдын 80 хувь (8 хүн) нь эрэгтэй, үлдсэн нь эмэгтэй хүмүүс байв. Харин яс үндсээр нь авч үзвэл бүгд халх ястан хүмүүс байна.

Ажил олгогчдыг алт/жонш олборлох ажил хийж буй хугацаагаар нь харвал алт олборлогчдын 58.8 хувь нь 2 жил буюу түүнээс бага хугацаанд, 41.2 хувь нь 3 буюу түүнээс дээш жилийн хугацаанд энэ төрлийн ажлыг хийж байгаа хүмүүс байв. Өөрөөр хэлбэл, илүү олон жил тухайн ажлыг хийж байгаа туршлагатай хүмүүсийн дунд хүүхдийг ажиллуулах явдал арай бага байна. Харин жонш олборлогчдын хувьд ажилласан жилээрээ ялгаатай хандлага ажиглагдахгүй (50 хувь нь 2 жил хүртэлх, нөгөө тал хувь нь 2-оос олон жил ажиллагсад) байна. Ажилласан дундаж жил нь алт олборлогчдын хувьд 2.8 жил, жонш олборлогчдын хувьд 3.5 жил байна.




Алт олборлож буй 1 ажил олгогч дунджаар 3.2 эрэгтэй, 1.6 эмэгтэй, нийт 4.8 хүнтэй хамт ажилладаг байхад жонш олборлогч 11.1 хүнтэй (үүний 7.1 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй) хамтран ажилладаг гэжээ. Эндээс жонш олборлогчид уг ажлыг гүйцэтгэхдээ харьцангуй олуулаа ажилладаг нь харагдаж байна. Түүнчлэн алт, жонш олборлох ажлуудад хоёуланд нь эрэгтэй хүйсийн хүмүүс эмэгтэйдээс илүү оролцон ажилладаг байна.

Ажил олгогчтой хамт ажиллагсдын дунд хөлсгүйгээр ажилладаг гэр бүлийн гишүүдийн тоо хэд байгааг авч үзвэл, алт олборлогч 1 ажил олгогч дунджаар 2.3, харин жонш олборлож буй ажил олгогч дунджаар 1.6 хүнийг гэр бүлийн гишүүдээсээ ажиллуулж байна. Эдгээр гэр бүлийн гишүүдээс 0.7 (алт олборлогч) ба 0.3 (жонш олборлогч) нь тус тус 5-17 насны хүүхдүүд байна.

Алт олборлож буй ажил олгогчдын 70.6 хувь нь зөвхөн 15-17 насны, 17.6 хувь нь зөвхөн 5-14 насны хүүхдүүдийг ажиллуулдаг гэжээ. Гэтэл жонш олборлогчдын дунд дээрх насны хүүхдүүдийн аль алиныг зэрэг ажиллуулдаг хувь харьцангуй өндөр буюу 60 хувь (6 хүн) байна.

Алт олборлож буй нэг ажил олгогч дунджаар 5-14 насны 0.4 хүүхэд, 15-17 насны 1 хүүхэд ажиллуулж байна. Харин жонш олборлож буй нэг ажил олгогч дунджаар 5-14 насны 1.6 хүүхэд, 15-17 насны 2 хүүхэд ажиллуулдаг гэжээ. Эдгээрээс, албан бусаар жонш олборлогчдын дунд олон тооны хүүхэд ажиллуулах хандлага алт олборлогчдынхоос арай илүү ба алт, жонш олборлогчдын аль аль нь ахимаг буюу 15-17 насны хүүхдүүдийг түлхүү ажиллуулдаг нь харагдаж байна.

Ажил олгогчид хүүхдийг ажилд авахдаа хэнээр дамжуулан олж авсаныг сонирхвол (Зураг 6.1), “хүүхэд өөрөө” ирж санал болгосон гэсэн хариулт (44.1 хувь) алт олборлогчдын хувьд бусдаас давамгайлж байна. Үүний дараа хүүхдийн эцэг/эх (26.5 хувь) болон өөрийн хамаатан саднаараа (26.5 хувь) дамжуулан анх хүүхдийг ажилд авсан ажил олгогчдын хувь орж байна. Жонш олборлогчдын хувьд ч хүүхдийн эцэг/эх, эсвэл хамаатан саднаараа дамжуулан хүүхдийг ажиллуулах болсон хандлага бусдаас өндөр байна.



Оyг аyгaйёё: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-аас илүү

Эдгээрээс дүгнэвэл, хүүхэд анх ийм ажилд татагдан орж байгаа нь нэг талаас өөрийн санал, хүсэлтэд үндэслэсэн боловч нөгөө талаас үүнд томчууд, эцэг/эх, ойр дотны хүмүүсийн оролцоо мөн багагүй байна гэж болохоор байна.

## 6.2 Хүүхдийн ажил эрхлэлт, ажлын нөхцөл дэх ажил олгогчийн хандлага

### 6.2.1 Хүүхдийн ажил эрхлэлтийг тодорхойлж буй байдал

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын дунд эрэгтэй хүйсийн хүүхдийг ажиллуулах хандлага илүү түгээмэл байсан ба давхардсан тоогоор эмэгтэй хүүхэд ажиллуулж буй ажил олгогч 13 байв. Үүний 8 нь эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн аль алиныг, харин 5 нь зөвхөн эмэгтэй хүүхэд ажиллуулдаг хүмүүс байсан.

Ажил олгогчид алт/жонш олборлохдоо хүүхдүүдээр чухам ямар төрлийн ажил хийлгэдэг талаарх мэдээллийг ажиллуулж буй хүүхдийн хүйсээр ялган Хүснэгт 6.2-г харуулав.

*Өгүүлэл 6.2.* Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувь, хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Хүүхдээр хийлгэдэг ажлын төрлүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Эрэгтэй хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл</b>		
Нүх малтах/Шороо ухах	96.6 (28)	60.0 (6)
Ус/шороо зөөх	93.1 (27)	90.0 (9)
Шороо шигших	72.4 (21)	30.0 (3)
Чулуу/хүдэр зөөх	20.7 (6)	60.0 (6)
Хүдэр/чулуу/жонш бутлах	6.9 (2)	60.0 (6)
Алт угаах	89.7 (26)	-
Жонш кублэх	-	30.0 (3)
Компрессор/помп/дамнуургат татлага ажиллуулах	13.8 (4)	-
Шлюцдэх	34.5 (10)	-
<b>Эрэгтэй хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын тоо</b>	<b>29</b>	<b>10</b>
<b>Эмэгтэй хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл</b>		
Нүх малтах/Шороо ухах	50.0 (6)	(1)
Ус/шороо зөөх	83.3 (10)	(1)
Шороо шигших	50.0 (6)	-
Чулуу/хүдэр зөөх	16.7 (2)	-
Алт угаах	75.0 (9)	-
Шлюцдэх	8.3 (1)	-
<b>Эмэгтэй хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын тоо</b>	<b>12</b>	<b>1</b>

*Өгүүлэл 6.2.* Зарим ажил олгогч эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийг зэрэг ажиллуулдаг тул ажил олгогчдын нийт тоо 44-өөс их.

Алт олборлож буй ажил олгогчдын хувьд хүүхдүүдээр хийлгэдэг ажлуудыг хамгийн өндөр хувь эзэлж байгаагаар нь дараалуулбал, эрэгтэй хүүхдүүдийн хувьд нүх малтах/шороо ухах, ус/шороо зөөх, алт угаах, шороо шигших зэрэг ажлууд орж байна (72.4-96.6 хувь). Харин эмэгтэй хүүхдүүдийн хувьд ус/шороо зөөх, алт угаах, шороо шигших, нүх малтах/шороо ухах (50-83.3 хувь) зэрэг ажлуудад түлхүү оролцдог гэжээ. Ерөнхийдөө хийлгэж буй ажлын төрөл нь эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувьд адил байгаа ч түүнд оролцсон хувь нь бага зэрэг ялгаатай, өөрөөр хэлбэл илүүтэйгээр эрэгтэй хүүхдүүдээр тухайн ажлыг хийлгэдэг байна. Жонш олборлодог ажил олгогчид эрэгтэй хүүхдүүдээр бүхий л

төрлийн ажлыг түгээмэл хийлгэдэг ба ус/шороо зөөх ажилд хамгийн их оролцуулдаг (90 хувь) гэжээ.

Ажил олгогчид алт/жонш олборлох үедээ дээрх үндсэн ажлуудаас гадна бусад нэмэлт ажлуудыг хүүхдүүдээр хийлгэдэг эсэхийг бид судалгаагаараа асуусан ба үүний үр дүнг хүүхдийн нас, хүйсээр Хүснэгт 6.3-т харуулав.


Ажил олгогчдын дунд бага насны буюу 5-14 насны хүүхдүүдээр хоол хийх/бэлтгэх, хувцас угаах, гэр цэвэрлэх, ус/түлээнд явуулах, зараалд гүйлгэх зэрэг үнэлгээгүй, давхар ажил хийлгэх хандлага 15-17 насны хүүхдүүдтэй харьцуулахад арай бага байгаа боловч ийм ажлуудыг эмэгтэй хүүхдүүдээр илүүтэй хийлгэдэг байна. Тухайлбал, 15-17 насны эрэгтэй хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын 40.6-43.8 хувь нь энэ насны, эрэгтэй хүүхдүүдээр хувцас угаах, хоол хийлгэх ажил давхар хийлгэдэг гэсэн байхад тухайн насны эмэгтэй хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын 75 хувь нь тус тус эмэгтэй хүүхдүүдээр эдгээр ажлыг хийлгэдэг гэжээ.

*᠋ᠣᠯᠢᠭᠠᠨᠳᠦ ᠖.3. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувь, хүүхдээр хийлгэдэг нэмэлт ажлын төрөл, ажиллуулж буй хүүхдийн хүйс, насаар*


Хүүхдээр хийлгэдэг нэмэлт ажлын төрлүүд	Ажиллуулж буй хүүхдийн хүйс		
	эрэгтэй	эмэгтэй	Бүгд
<b>5-14 насны хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл</b>			
Хоол хийх/бэлтгэх	42.9 (6)	62.5 (5)	<b>47.1 (8)</b>
Хувцас угаах	28.6 (4)	75.0 (6)	<b>52.9 (9)</b>
Гэр цэвэрлэх	35.7 (5)	75.0 (6)	<b>52.9 (9)</b>
Ус/түлээ зөөх	71.4 (10)	75.0 (6)	<b>76.5 (13)</b>
Зараалд гүйх	-	12.5 (1)	<b>5.9 (1)</b>
<b>5-14 насны хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын тоо</b>	<b>14</b>	<b>8</b>	<b>17</b>
<b>15-17 насны хүүхдээр хийлгэдэг ажлын төрөл</b>			
Хоол хийх/бэлтгэх	43.8 (14)	75.0 (6)	<b>54.1 (20)</b>
Хувцас угаах	40.6 (13)	75.0 (6)	<b>51.4 (19)</b>
Гэр цэвэрлэх	46.9 (15)	75.0 (6)	<b>59.5 (22)</b>
Ус/түлээ зөөх	81.3 (26)	62.5 (5)	<b>81.1 (30)</b>
Зараалд гүйх	3.1 (1)	-	<b>2.7 (1)</b>
<b>15-17 насны хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын тоо</b>	<b>32</b>	<b>8</b>	<b>37</b>

*᠋ᠣᠯᠢ ᠠᠭᠠᠭᠠᠭᠦ:* Зарим ажил олгогч 5-14 ба 15-17 насны, мөн эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийг зэрэг ажиллуулдаг тул ажил олгогчдын нийт тоо 44-өөс их.

Судалгаагаар, алт олборлож буй ажил олгогчид нийтдээ 5-14 насны 12 хүүхэд, 15-17 насны 17 хүүхдийг; харин жонш олборлож буй хүмүүс нийтдээ 5-14 насны 6 хүүхэд, 15-17 насны 8 хүүхдийг тус тус алт/жонш олборлож байгаатай уялдан ажлын ур чадвар эзэмшсэн гэж үзэж байна. Ийнхүү ажлын ур чадвар эзэмшсэн хүүхдийг нас, хүйсээр нь харвал, 1 ажил олгогчид ногдох ажлын ур чадвар эзэмшсэн хүүхдийн дундаж тоо нь эрэгтэй болон 15-аас дээш насны хүүхдүүдийн дунд өндөр байгааг Зураг 6.2-оос харж болно.



Ажил олгогчид хүүхдүүдийг ямар улиралд ажиллуулж байгааг авч үзвэл (Зураг 6.3), алт, жонш олборлогчдын аль аль нь зуны улиралд хамгийн их ажиллуулдаг байна. Гэвч тэдний дунд өвлийн улиралд хүүхэд ажиллуулдаг гэсэн ажил олгогчид ч байсан (алт олборлогчдын 32.3 хувь- 11 хүн, жонш олборлогчдын 1 хүн) нь анхаарал татаж байна.



*Өүг агуулах:* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-аас илүү

Судалгаанд хамрагдсан ажил олгогчид хүүхдүүдийн ажлын цаг, өдрийн хувиарлалтын талаар ямар мэдээлэл өгснийг Хүснэгт 6.4-өөс харна уу. Ажлын үеэр алт олборлож буй ажил олгогчид хүүхдүүдийг дунджаар 7 хоногийн бүх өдөр ажиллуулдаг бол жонш олборлогчид 6.4 өдөр нь ажиллуулдаг гэжээ.

Алт олборлогчдын 50 хувь нь хүүхдүүдийг өдөрт дунджаар 10 хүртэлх цаг, харин үлдсэн 50 хувь нь 10-аас илүү цаг ажилладаг гэж мэдээлж байна. Жонш олборлогчдын хувьд энэхүү ажлын цагийн медиан утга нь 7.5 цаг байлаа. Хүүхдүүдийг өдөрт ажиллуулдаг дундаж цаг нь алт олборлогчдын хувьд (9 цаг) жонш олборлогчдынхоос 1.8 цагаар илүү байна. Ажил олгогчдын мэдээлсэн эдгээр бүх үр дүнгүүд нь “Насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно”, мөн “Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байна” гэсэн Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудыг зөрчсөн үйлдэл байв.

Судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын дунд нэгээс олон тооны хүүхдийг зэрэг ажиллуулдаг ажил олгогчид 21 буюу 47.7 хувийг эзэлж байсан. Энэхүү нэгээс олон хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын 52.4 хувь нь хүүхдүүдийн өдөрт ажилладаг цаг хоорондоо ялгаатай байдаг гэсэн байлаа.

Өдрийн ажлын дундуур хүүхдүүдэд түр завсарлах цаг гаргаж өгдөг эсэхийг сонирхвол, алт олборлож буй ажил олгогчдын 14.7 хувь буюу 5 хүн ийм цаг гаргаж өгдөггүй гэжээ. Харин жонш олборлож буй ажил олгогчдын дунд ийм тохиолдол байхгүй байв. Ажлын дундуур түр завсарлах цаг гаргаж өгөхгүй байгаа тохиолдол нь мөн л Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулин дахь “Ажилтанд амарч, хооллоход нь зориулан завсарлага олгоно” гэсэн заалтыг зөрчиж буй үйлдэл гэж болохоор байна. Хүүхдүүдэд гаргаж өгдөг түр завсарлагын үргэлжлэх хугацааг харвал алт олборлогчид дунджаар 50.1 минут, жонш олборлогчид дунджаар 91 минутын завсарлага гаргаж өгдөг гэжээ. Ерөнхийдөө алт олборлож буй хүүхдүүдэд завсарлагын цаг харьцангуй бага ногдож байгааг тэд жонш олборлож буй хүүхдүүдийг бодвол харьцангуй цөөхүүлээ ажилладгаас 1 хүнд ногдох ажлын ачаалал их байдагтай холбон тайлбарлаж болох юм.

*Өзгйд үгд 6.4 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, ажиллуулж буй хүүхдийн ажлын цаг/өдрийг тодорхойлсон байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр*

Ажлын цаг/өдрийг тодорхойлсон байдал	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Долоо хоногт ажиллуулдаг өдрийн тоо</b>		
4-6 өдөр	23.5 (8)	30.0 (3)
7 өдөр	76.5 (26)	70.0 (7)
<i>Äîëî ðîíîäò äæëëöööëäää äóíääæ öäðëí ðîí</i>	7	6.4
<b>Өдөрт ажиллуулдаг цаг</b>		
6, түүнээс цөөн цаг	17.6 (6)	40.0 (4)
7-8 цаг	23.5 (8)	30.0 (3)
9-10 цаг	38.2 (13)	30.0 (3)
11, түүнээс илүү цаг	20.7 (7)	-
<i>ä ä°ðò äæëëöööëäää äóíääæ öää</i>	9	7.2
<i>Ì ääëäí</i>	10	7.5
<b>Өдрийн ажлын дундуур өгдөг завсарлагын цаг</b>		
5-30 минут	35.3 (12)	20.0 (2)
31-80 минут	35.3 (12)	30.0 (3)
81, түүнээс дээш минут	14.7 (5)	50.0 (5)
Завсарлах цаг гаргадаггүй	14.7 (5)	-
<i>Çââñäðëääüí çäýéæëýö äóíääæ ööääöää</i>	50.1 ì èíöò	91 ì èíöò
<i>Ì ääëäí</i>	35 ì èíöò	100 ì èíöò
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо</b>	<b>34</b>	<b>10</b>

## 6.2.2 Хүүхдийн хөдөлмөрийг үнэлж буй байдал

Ажил олгогчид хүүхдийн ажлын хөлсийг хэрхэн төлдөг хэлбэрийг ажил олгогчийн шинж байдлаар Хүснэгт 6.5-аас харж болно.

Нийт ажил олгогчдын 27.3 хувь нь хүүхэд ажиллуулсныхаа төлөө огт төлбөр төлдөггүй гэсэн байгаа ба 36.4 хувь нь зөвхөн мөнгөн хэлбэрээр, 9.1 хувь нь зөвхөн мөнгөн бус хэлбэрээр, үлдсэн 27.3 хувь нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэрийн аль алианаар нь хүүхдэд төлбөр өгдөг гэжээ. Үүнийг ажил олгогчдын олборлож буй ашигт малтмалын төрлөөр авч үзвэл, жонш олборлогчдын дунд хүүхдэд огт төлбөр төлдөггүй болон зөвхөн мөнгөн бус эд зүйлээр төлбөр өгдөг хүн байхгүй байна. Харин алт олборлогчдын дунд огт төлбөр өгдөггүй ажил олгогчид 35.3 хувийг эзэлж байгаа нь ямар нэг хэлбэрээр төлбөр өгдөг хүмүүсээс өндөр хувьтай байна. Хүүхдэд шууд мөнгөн хэлбэрээр төлбөр өгдөг ажил олгогчид жонш олборлогчдын дунд (60 хувь) алт олборлогчдынхоос 2 дахин өндөр байна.

Ажиллуулж буй хүүхдийн тоогоор авч үзвэл, 1-ээс олон хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын дунд ямар нэг хэлбэрээр хүүхдэд хөлс төлдөг хувь нь 1 хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдоос өндөр байна. Энэ нь 1 хүүхэд ажиллуулж буй ажил олгогчид голдуу гэр бүлийн болон ойрын хамаатны хүүхдээ ажиллуулж буйг батлах үзүүлэлт байж болох юм.

Ажил олгогч хэдэн насны хүүхэд ажиллуулж байгаагаар нь авч үзвэл, 5-14 насны хүүхэд ажиллуулдаг ажил олгогчдын дунд зөвхөн мөнгөн хэлбэрээр хөлс төлж буй ажил олгогчид байхгүй байна. Эсрэгээр мөнгөн бусаар хөлс өгдөг ажил олгогчид 5-14 насны хүүхэд ажиллуулагсдын дунд хамгийн өндөр (28.6 хувь) байна.

Өгүүлэл 6.5. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхдэд ажлын хөлс төлдөг хэлбэр, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхдүүдэд хөлс төлдөг хэлбэр				Бүгд	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо
	Мөнгөн ба мөнгөн бусаар	Зөвхөн мөнгөн хэлбэрээр	Мөнгөн бусаар	Огт төлдөггүй		
<b>Ашигт малтмалын төрөл</b>						
Алт	23.5 (8)	29.4 (10)	11.8 (4)	35.3 (12)	100.0	34
Жонш	40.0 (4)	60.0 (6)	-	-	100.0	10
<b>Ажиллуулж буй хүүхдийн тоо</b>						
1	21.7 (5)	26.1 (6)	8.7 (2)	43.5 (10)	100.0	23
2, түүнээс олон	33.4 (7)	47.6 (10)	9.5 (2)	9.5 (2)	100.0	21
<b>Хэдэн насны хүүхэд ажиллуулж буй эсэх</b>						
5-14 насны	57.1 (4)	-	28.6 (2)	14.3 (1)	100.0	7
15-17 насны	18.5 (5)	40.7 (11)	3.7 (1)	37.0 (10)	100.0	27
Дээрх бүх насны	30.0 (3)	50.0 (5)	10.0 (1)	10.0 (1)	100.0	10
<b>Ажил олгогчийн нас</b>						
35-аас доош	19.0 (4)	47.6 (10)	9.5 (2)	23.8 (5)	100.0	21
35, түүнээс дээш	34.8 (8)	26.1 (6)	8.7 (2)	30.4 (7)	100.0	23
<b>Ажил олгогчийн хүйс</b>						
Эрэгтэй	32.4 (11)	38.2 (13)	5.9 (2)	23.5 (8)	100.0	34
Эмэгтэй	10.0 (1)	30.0 (3)	20.0 (2)	40.0 (4)	100.0	10
<b>Нийт</b>	<b>27.3 (12)</b>	<b>36.4 (16)</b>	<b>9.1 (4)</b>	<b>27.3 (12)</b>	<b>100.0</b>	<b>44</b>



35-аас доош насны ажил олгогчдын дунд огт төлбөр төлдөггүй хувь (23.8 хувь) 35 ба түүнээс дээш насныхнаас бага байгаа ба мөнгөн хэлбэрээр хөлс төлдөг хувь (47.6 хувь) нь 1.8 дахин илүү байна. Ажил олгогчдын хүйсээр харвал, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр хөлс төлдөг хувь эрэгтэй ажил олгогчдын дунд эмэгтэйтэйгээс өндөр байв. Ерөнхийдөө залуу насны, эрэгтэй ажил олгогчдын дунд хүүхдийг хөлсгүй ажиллуулах хэлбэр арай бага байна.

Мөнгөн хэлбэрээр хөлс төлдөг ажил олгогчдоос хүүхдэд сард дунджаар ямар хэмжээний хөлс төлдгийг асуухад алт олборлож буй 5-14 насны эрэгтэй хүүхдэд 20.500 төгрөг, 5-14 насны эмэгтэй хүүхдэд 19.000 төгрөг, 15-17 насны эрэгтэй хүүхдэд 75.923 төгрөг, 15-17 насны эмэгтэй хүүхдэд 14.250 төгрөгийн хөлсийг тус тус өгдөг гэжээ.

Жонш олборлож буй ажил олгогчид 5-14 насны эрэгтэй хүүхдэд сард дунджаар 36.337 төгрөг, 5-14 насны эмэгтэй хүүхдэд 10.000 төгрөг, 15-17 насны эрэгтэй хүүхдэд 78.125 төгрөг, 15-17 насны эмэгтэй хүүхдэд 10.000 төгрөг төлдөг байна. Эдгээрээс харахад албан бусаар алт/жонш олборлох ажил хийж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлсийг ажил олгогчид харьцангуй ялгаатайгаар үнэлж байгаа ба эрэгтэй хүүхдийн хөдөлмөрийг эмэгтэй хүүхдийнхээс өндрөөр үнэлж байна.

Алт олборлогчдын хувьд хүүхдэд төлдөг хамгийн бага хөлсний хэмжээ 3.000 төгрөг, хамгийн өндөр хөлсний хэмжээ 300,000 төгрөг байхад жонш олборлогчдын хувьд хамгийн бага нь 10.000 төгрөг, хамгийн өндөр нь 200.000 төгрөг байна.

Мөнгөн бус хэлбэрээр хүүхдэд ажлын хөлс төлж буй байдлыг авч үзвэл, давхардсан тоогоор алт олборлогчдын 94 хувь нь хоол, хүнс өгдөг, 35.3 хувь нь хувцас авч өгдөг, 17.6 хувь нь хичээлийн хэрэгсэл авч өгдөг гэжээ. Харин жонш олборлогчдын 40 хувь (4 хүн) хоол хүнс, 30 хувь (3 хүн) хувцас, 10 хувь (1 хүн) нь хичээлийн хэрэгсэл авч өгдөг гэж тус тус хариулсан байна.

### ***6.2.3 Хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл ба нийгмийн хамгааллын асуудалд хандаж буй байдал***

Судалгаанд хамрагдсан ажил олгогчид хүүхдийг ажиллуулахдаа хөдөлмөрийн ямар нөхцөл тавьж, нийгмийн зарим асуудалд хэрхэн ханддаг талаарх асуултуудыг бид судалгаандаа оруулсан ба холбогдох үр дүнг Хүснэгт 6.6-д харуулав.

Алт олборлож буй нийт ажил олгогчдын 85.3 хувь нь хүүхэд ажиллуулахдаа хөдөлмөрийн ямар нэг гэрээ/хэлцэл хийгээгүй байгаа ба үлдсэн хувь нь зөвхөн амаар хэлцэл хийжээ. Харин жонш олборлогчдын дунд огт гэрээ/хэлцэл хийгээгүй хувь (40 хувь буюу 4 хүн) арай бага байгаа боловч гэрээ/хэлцэл хийгдсэн гэдгийг хуулийн хүрээнд баталж чадахуйцаар буюу бичгээр гэрээ хийсэн тохиолдол ганцхан байна. Түүнчлэн энэхүү хандлага нь ажил олгогчийн насаар ч бараг ялгаагүй байна. Эндээс, тухайн хүүхэд ажил олгогчийн хооронд аливаа маргаан, бэрхшээлтэй асуудал гарсан тохиолдолд, тухайлбал хүүхдийн эрх зөрчигдөхөд хууль хяналтын байгууллагад хандах боломж хязгаарлагдмал тул хүүхэд эрсдэлтэй нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг юм.

*ᠪᠦᠵᠡᠨᠢᠶ᠋ᠢ* 6.6 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн талаарх хандлага, насны бүлэг, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн талаарх ажил олгогчийн хандлага	Алт олборлогч			Жонш олборлогч		
	Насны бүлэг		Нийт	Насны бүлэг		Нийт
	35-аас доош насны	35, түүнээс дээш насны		35-аас доош насны	35, түүнээс дээш насны	
<b>Ажиллуулж буй хүүхэдтэй хийсэн гэрээ/хэлцэл</b>						
Ямар ч гэрээ байхгүй	87.5 (14)	83.3 (15)	<b>85.3 (29)</b>	40.0 (2)	40.0 (2)	<b>40.0 (4)</b>
Бичгээр гэрээ/хэлцэл	-	-	-	-	20.0 (1)	<b>10.0 (1)</b>
Амаар гэрээ/хэлцэл	12.5 (2)	16.7 (3)	<b>14.7 (5)</b>	60.0 (3)	40.0 (2)	<b>50.0 (5)</b>
<b>Ажлын хувцас/хэрэглэлээр хангадаг эсэх</b>						
Тийм	31.3 (5)	55.6 (10)	<b>44.1 (15)</b>	40.0 (2)	60.0 (3)	<b>50.0 (5)</b>
Үгүй	68.8 (11)	38.9 (7)	<b>52.9 (18)</b>	40.0 (2)	40.0 (2)	<b>40.0 (4)</b>
Шаардлагагүй	-	5.6 (1)	<b>2.9 (1)</b>	20.0 (1)	-	<b>10.0 (1)</b>
<b>Ажиллуулж буй хүүхдэд сургуульд явах боломж гаргаж өгдөг эсэх</b>						
Тийм	31.3 (5)	72.2 (13)	<b>52.9 (18)</b>	100.0 (5)	80.0 (4)	<b>90.0 (9)</b>
Үгүй	31.3 (5)	5.6 (1)	<b>17.6 (6)</b>	-	-	-
Хүүхэд сургуульд сурдаггүй	37.4 (6)	22.2 (4)	<b>29.4 (10)</b>	-	20.0 (1)	<b>10.0 (1)</b>
<b>Ажиллуулж буй хүүхэд өвдөхөд ямар нэг туслалцаа үзүүлдэг эсэх</b>						
Тийм	93.7 (15)	88.8 (16)	<b>91.2 (31)</b>	100.0 (5)	60.0 (3)	<b>80.0 (8)</b>
Үгүй	-	5.6 (1)	<b>2.9 (1)</b>	-	-	-
Хүүхэд өвдөж байгаагүй	6.3 (1)	5.6 (1)	<b>5.9 (2)</b>	-	40.0 (2)	<b>20.0 (2)</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо</b>	<b>16</b>	<b>18</b>	<b>34</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>10</b>


Ажиллуулж байгаа хүүхдийг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангадаг эсэхийг авч үзвэл, алт болон жонш олборлож буй ажил олгогчдоос тус бүр 1 хүн ингэх шаардлагагүй гэж үздэгээ илэрхийлжээ. Түүнчлэн алт олборлогчдын 52.9 хувь, жонш олборлогчдын 40 хувь нь тус тус ажиллуулж байгаа хүүхдүүдээ ажлын хувцас, хэрэгслээр хангадаггүй гэсэн байна. Харин хариулагчдын насаар авч үзвэл 35 буюу түүнээс дээш насны ажил олгогчдын дунд хүүхдүүдийг ажлын хувцас, хэрэгслээр хангадаг хувь 35-аас доош насныхнаас арай илүү байна.

Хүүхдүүдийг хувцас, хэрэгслэр хангадаг ажил олгогчдын хувьд олгож буй хувцас, хэрэгслийн төрлийг харвал, гадуур хувцас (80 хувь), гутал (75 хувь), амны хаалт/маск (55 хувь), малгай (50 хувь), бээлий (20 хувь) зэргээр хязгаарлагдаж байна.

Албан бусаар алт жонш олборлож буй хүүхдүүдэд сургуульдаа явах боломж гаргаж өгдөг эсэхийг харвал, жонш олборлогчдын 90 хувь (9 хүн) нь ийм боломж гаргаж өгдөг гэжээ. Харин алт олборлож буй ажил олгогчдын 52.9 хувь нь л ийм боломж өгдөг, 17.6 хувь нь боломж гаргаж өгдөггүй, бусад нь хүүхэд сургуульд сурдаггүй тул ийм боломж гаргаж өгөх шаардлагагүй гэсэн байна.

Ажиллуулж буй хүүхэд өвдөхөд ямар нэг туслалцаа үзүүлдэг эсэхийг авч үзвэл алт олборлож буй ажил олгогчдын 91.2 хувь, жонш олборлогчдын 80 хувь (8 хүн) нь тус тус тодорхой тусламж үзүүлдэг гэжээ. Хүүхдүүд өвдөхөд тэдний үзүүлдэг

тусламжийн хэлбэрийг харвал дийлэнх нь эм өгөх, эмчид үзүүлэх зэрэг тусламжууд үзүүлдэгээ дурьдсан байна. Эдгээрээс гадна зарим ажил олгогчид амралт гаргаж өгөх, хоол, цайгаар тордох зэрэг бусад хэлбэрийн тусламжуудыг мөн өвдсөн хүүхдүүдэд үзүүлдэг байна (Зураг 6.4).



### 6.3 Хүүхдийн хөдөлмөрийн талаарх ажил олгогчийн үзэл бодол ба мэдлэг

Хүүхдээр алт/жонш олборлох ажил хийлгэхэд тэдэнд ажлын нөхцлийн талаас, мөн эрүүл мэндийн талаас ямар төрлийн бэрхшээл гарч болох эсэх талаар ажил олгогчийн үзэл бодлыг Хүснэгт 6.7-д харуулав.

Хүснэгтээс харахад, алт олборлож буй ажил олгогчдын 17.6 хувь (6 хүн), жонш олборлож буй ажил олгогчдын 50 хувь нь (5 хүн) тус тус ийм төрлийн ажил хийхэд ажлын нөхцлийн талаас хүүхдүүдэд бэрхшээл гардаггүй гэж үзэж байна. Харин хүүхдүүдэд нийтлэг тохиолдож болох бэрхшээлүүдэд хүнд ачаа өргөдөг, тоос шороо ихтэй орчинд ажилладаг, цаг агаарын таагүй нөхцөлд ажилладаг зэргийг хэлж болно гэж ажил олгогчид үзсэн байна.

Алт/жонш олборлох ажил хийх нь эрүүл мэндэд ямар ч хор хохирол үзүүлэхгүй гэж алт олборлож буй ажил олгогчдын 8.8 хувь (3 хүн), жонш олборлогчдын 10 хувь (1 хүн) нь тус тус үзжээ. Ийнхүү ихэнх ажил олгогчид энэ төрлийн ажил нь хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлтэй гэж үзэж байгаа ба нурууны өвчин, амьсгалын замын өвчин, бөөр, шээсний замын өвчин, гэмтэх/зүсэгдэх зэрэг эрсдэлүүд хамгийн их тохиолдож болно гэж үзэж байгаа аж.

**Өгүүлэл 6.7 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувь, хүүхдийн ажлын нөхцлийн бэрхшээл болон ажил эрхлэлтэй холбоотойгоор тулгарч болох эрүүл мэндийн эрсдэлийн талаарх үзэл бодол, олборлож буй ашигт малтмалын төрлөөр**



Ажил олгогчийн үзэл бодол	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Хүүхдэд тохиолддог ажлын нөхцлийн бэрхшээл</b>		
Бэрхшээл гардаггүй	17.6 (6)	50.0 (5)
Мэдэхгүй	5.9 (2)	-
Гэрэл, гэгээ муутай	20.6 (7)	-
Тоос, шороо ихтэй	61.8 (21)	30.0 (3)
Цаг агаарын таагүй нөхцөлд ажилладаг (Хурц нартай, халуун, бүгчим гэх мэт)	55.9 (19)	40.0 (4)
Дуу чимээ их	23.5 (8)	-
Хүнд ачаа өргөдөг	70.6 (24)	40.0 (4)
Хууль, хяналтын байгууллагын хүчирхийлэлд өртдөг	2.9 (1)	-
Газар доор/нүхэнд ажилладаг	-	20.0 (2)
<b>Алт/жонш олборлосноор эрүүл мэндэд учирч болох эрсдэл</b>		
Хор хохирол учруулахгүй	8.8 (3)	10.0 (1)
Мэдэхгүй	5.9 (2)	20.0 (2)
Нуруу өвдөх	70.6 (24)	50.0 (5)
Амьсгалын замын өвчтэй болох	50.0 (17)	30.0 (3)
Дүлийрэх	5.9 (2)	-
Түлэгдэх	2.9 (1)	-
Зүсэгдэх	17.6 (6)	20.0 (2)
Гэмтэл бэртэл авах	5.9 (2)	-
Бөөр/шээсний замын өвчтэй болох	11.8 (4)	10.0 (1)
Харшилтай болох	2.9 (1)	10.0 (1)
<b>Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо</b>	<b>34</b>	<b>10</b>

*Өгүүлэл 6.7:* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-аас илүү

Ажил олгогчид насанд хүрээгүй хүүхдийг энэ ажилд ажиллуулахын давуу ба сул талыг хэрхэн үнэлж байгааг Зураг 6.5 ба Зураг 6.6-д харуулав.

Алт олборлож буй ажил олгогчдын 41.2 хувь, жонш олборлож буй ажил олгогчдын 80 хувь нь тус тус ийм төрлийн ажилд хүүхэд ажиллуулахад сул тал байхгүй гэж үзэж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт байна. Гэвч бусад ажил олгогчдын нэрлэсэн сул талыг үзвэл, гэмтэж, бэртэх гээд байдаг, үгэнд ордоггүй/хулгай хийдэг зэрэг хувь хүнтэй холбоотой зүйлүүдийг илүүтэй нэрлэсэн байна. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын мэдлэг, туршлага муу; хүүхэд ажиллуулахыг хууль хяналтын байгууллага зөвшөөрдөггүй зэрэг шалтгаануудыг ч дурьдсанаас харвал насанд хүрсэн зарим ажил олгогчид хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль дүрмийг мэддэг атлаа дагаж мөрдөхгүй байгааг баталж байна.

Алт/жонш олборлох ажилд хүүхэд оролцуулахын давуу талыг ажил олгогчид хэрхэн үнэлж байгааг авч үзвэл алт олборлогчдын 41.2 хувь, жонш олборлогчдын 40 хувь нь тус тус давуу тал байхгүй гэжээ. Харин хүүхэд ажиллуулахын гол давуу тал нь ажил олгогчдын хувьд хүүхэд чих зөөлөн, үгээр байдаг; түүнчлэн хямд зардлаар ажиллуулах боломжтой байдаг явдал ажээ.



Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг багасгахад нэг чухал үүрэг гүйцэтгэж болох зүйл бол хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулиар зөвшөөрөгдсөн насны талаар насанд хүрэгчид, ажил олгогчид зөв мэдлэгтэй байх, түүнийгээ сахиж мөрддөг байх явдал юм. Иймээс ч бид судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулиар зөвшөөрөгдсөн насны талаарх мэдлэгийг үнэлэх зорилгоор “Таны бодлоор хүүхэд ажил хийж эхлэх хуулиар зөвшөөрөгдсөн нас хэд вэ?” гэсэн асуултыг оруулсан болно.

МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулиар 16 насанд хүрсэн хүүхэд хөдөлмөрийн гэрээ байгуулах буюу хөдөлмөр эрхэлж болно гэж заасан байдаг. Иймд бид ажил олгогчдын энэ талаарх мэдлэгийг үнэлэхдээ уг насыг 16 гэж хариулсан тохиолдолд зөв, бусад тохиолдолд буруу гэж үзлээ.

Судалгаагаар, нийт ажил олгогчдын 1/3 нь л хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулиар зөвшөөрөгдсөн доод насыг зөв буюу 16 гэж тодорхойлжээ (Хүснэгт 6.8). Энэхүү зөв мэдлэгтэй ажил олгогчдын хувь алт олборлогчдын дунд (32.4 хувь) жонш олборлогчдынхоос 7.6 пунктээр, 35-аас доош насныхны дунд (28.6 хувь) 35 ба түүнээс дээш насныхнаас 10.5 пунктээр, эмэгтэйчүүдийн дунд (30 хувь) эрэгтэйчүүдийнхээс 5.3 пунктээр, 2-оос цөөн жил ажиллаж буй хүмүүсийн дунд (32 хувь) 3 ба түүнээс олон жил ажиллагсдынхаас 4.8 пунктээр тус тус доогуур байна.

*ᠪᠢᠨᠠᠨᠢᠨᠠᠨᠢ* 6.8. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувийн жин, хүүхэд ажил хийж эхлэх хуулиар зөвшөөрөгдсөн насны талаарх мэдлэг, сонгосон үзүүлэлтүүдээр

Ажил олгогчийн сонгосон үзүүлэлтүүд	Хүүхэд ажил хийж эхлэх хуулиар зөвшөөрөгдсөн насны талаарх мэдлэг		Бүгд	Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тоо
	Зөв	Буруу		
<b>Ажиллаж буй уурхайн төрөл</b>				
Алт	32.4 (11)	67.6 (23)	<b>100.0</b>	<b>34</b>
Жонш	40.0 (4)	60.0 (6)	<b>100.0</b>	<b>10</b>
<b>Насны бүлэг</b>				
35-аас доош	28.6 (6)	71.4 (15)	<b>100.0</b>	<b>21</b>
35, түүнээс дээш	39.1 (9)	60.9 (14)	<b>100.0</b>	<b>23</b>
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	35.3 (12)	64.7 (22)	<b>100.0</b>	<b>34</b>
Эмэгтэй	30.0 (3)	70.0 (7)	<b>100.0</b>	<b>10</b>
<b>Алт/жонш олборлож буй хугацаа</b>				
2, түүнээс цөөн жил	32.0 (8)	68.0 (17)	<b>100.0</b>	<b>25</b>
3, түүнээс олон жил	36.8 (7)	63.2 (12)	<b>100.0</b>	<b>19</b>
<b>Нийт</b>	<b>34.1 (15)</b>	<b>65.9 (29)</b>	<b>100.0</b>	<b>44</b>

Дээрхээс гадна, Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон МУ-ын Засгийн газраас баталсан насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад алт/жонш олборлох ажлын талаар заалт орсон байдаг. Иймд судалгаагаараа мөн “18 нас хүрээгүй хүүхэд уурхайд ажиллахыг хуулиар хориглосон гэдгийг та мэдэх үү?” гэсэн асуултыг ажил олгогчдоос дурьдаж асуун мэдээлэл цуглуулсан юм. Үүний үр дүнг харвал нийт ажил олгогчдын 68.2 хувь нь 18 нас хүрээгүй хүүхэд уурхайд ажиллахыг хуулиар хориглосон гэдгийг мэднэ гэж хариулжээ.

## БҮЛЭГ 7. АЛБАН БУСААР АЛТ, ЖОНШ ОЛБОРЛОЖ БУЙ НАСАНД ХҮРЭГЧДИЙН БАЙДАЛ

Энэхүү бүлгээр албан бусаар алт, жонш олборлож буй насанд хүрэгчдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн шинж байдал, орчин ахуйн болон хөдөлмөрийн нөхцөл байдал, ажлын зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, энэ салбарт ажиллаж буй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх томчуудын үзэл бодлыг дэлгэрэнгүй харуулах болно.

### 7.1 Насанд хүрэгчдийн шинж байдал

Албан бусаар алт жонш олборлож буй нийт 37906 насанд хүрсэн хүн ам байгаагийн 89.6 хувь нь буюу 33960 хүн алтны уурхайд, үлдсэн 10.4 хувь нь буюу 3946 хүн жоншны уурхайд ажиллаж байна. Хүснэгт 7.1-д эдгээр хүн амыг хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн зарим шинж байдлаар дэлгэрэнгүй харууллаа.


*Өзгөтгөл 7.1 Насанд хүрэгчдийн хувийн жин, шинж байдлын сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Нас</b>		
25 хүртэл	28.5	8.3
25-29	18.9	32.1
30-34	21.6	12.1
35-39	9.4	15.4
40-44	8.7	15.2
45 ба дээш	12.9	16.9
<i>Аби ааæ</i>	<i>31.3</i>	<i>35.0</i>
<b>Хүйс</b>		
Эрэгтэй	68.3	55.0
Эмэгтэй	31.7	45.0
<b>Гэрлэлтийн байдал</b>		
Огт гэрлээгүй	34.4	24.7
Гэрлэсэн/хамтран амьдардаг	61.5	64.0
Тусгаарласан/Салсан/Бэлэвсэн	4.1	11.3
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>		
1-2	20.2	23.8
3-4	34.0	51.1
5 ба түүнээс олон	45.8	25.1
<i>Өрхөд амьдарч буй хүний дундаж тоо</i>	<i>4.7</i>	<i>4.2</i>
<i>Үүнээс, гэр бүлийн гишүүдийн дундаж тоо</i>	<i>3.3</i>	<i>2.5</i>
<b>Боловсролын түвшин</b>		
Боловсролгүй/Бага	16.5	14.4
Бүрэн бус дунд	36.2	48.5
Бүрэн дунд	38.8	33.1
Бүрэн дундаас дээш	8.5	4.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

Албан бусаар алт олборлогчдын дундаж нас 31.3, жонш олборлогчдынх 35.0 байна. Хүйсийн хувьд, алт албан бусаар олборлож буй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин олон байгаа бөгөөд жонш олборлож буй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10 пунктээр мөн л илүү байв.

Албан бусаар ажиллаж буй насанд хүрэгчдийн гэрлэлтийн байдлыг уурхайн төрлөөр авч үзэхэд алт олборлогчдын 34.4 хувь, жонш олборлогчдын 24.7 хувь нь огт гэрлээгүй залуучууд байгаа бөгөөд гэрлэсэн болон хамтран амьдарч хүмүүс 60 гаруй хувийг нь эзэлж байна.

Албан бусаар алт олборлогчид дунджаар 4.7 хүнтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд өрхөд амьдарч буй хүмүүсийн тоо жонш олборлогчдынхоос 0.5 пунктээр илүү байна. Түүнчлэн албан бусаар алт олборлогчдын гэр бүлийн гишүүдийн дундаж тоо 3.3 байгаа нь жонш олборлогчдын гэр бүлийн гишүүдийн дундаж (0.8) тооноос мөн л илүү байв. Өрхөд хамт амьдарч буй хүмүүсийн хамаарлыг авч үзэхэд албан бусаар алт, жонш олборлогчид голдуу халуун ам бүлээрээ амьдардаг болох нь Зураг 7.1-ээс харагдаж байна.



Өүг аүгэүе: Олон сонголттой хариулт тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцүү биш.

Албан бусаар алт, жонш олборлогчдын боловсролын түвшинг авч үзвэл, тэдгээрийн дийлэнх нь бүрэн бус дунд эсвэл бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Харин бага болон огт боловсролгүй насанд хүрэгчдийн эзлэх хувийн жин алтны уурхайд 16.5, жоншны уурхайд 14.4 байв. Боловсролын түвшин доогуур байх нь хувь хүний чадвар сул дорой байх үндсэн нөхцөл бөгөөд тодорхой эзэмшсэн мэргэжилгүй ажиллах хүчний нөөц албан бус секторт өндөр байгаагийн нэг илрэл болдог.

## 7.2 Албан бусаар алт, жонш олборлолт ба шилжих хөдөлгөөн

Албан бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь манай улсын дотоод шилжих хөдөлгөөнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа билээ. Энэхүү судалгаанд шилжигчийг тодорхойлохдоо цаг хугацааны тогтмол зай буюу таван жил гэсэн шалгуурыг авч, тухайн газарт 5 жилээс доош хугацаанд



амьдарч байгаа хариулагчдыг шилжин ирэгчид, харин 5 ба түүнээс дээш жил амьдарч буй хариулагчдыг шилжигч бус гэж тодорхойлсон болно.

Насанд хүрэгчдийн 18.2 хувь нь ашигт малтмал олборлож буй сумандаа 5 жилээс доош хугацаанд, 56.9 хувь нь 5 ба түүнээс дээш жил ажиллаж, амьдарч байна. Харин үлдсэн 24.9 хувь нь түр оршин сууж байгаа ажээ.

Албан бусаар алт олборлож буй шилжин ирэгчдийн бараг тал (48.7) хувь нь өөрийн аймгийн гэхдээ өөр сумдаас, харин дөрөвний нэг (25.4) хувь нь Улаанбаатар хотоос ирсэн байна. Харин жоншны уурхай дээр ажиллаж буй шилжин ирэгчид бүгд (Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр, Өмнөговь) өөр аймаг, хотоос шилжин ирцгээжээ. Эндээс, өөр аймаг, хотоос жонш олборлогчид орон нутагт илүү их ирж ажилладаг болох нь харагдаж байна. Харин алтны уурхайд тухайн аймгийн хүн ам түлхүү ажиллаж байна. Харамсалтай нь шилжин ирэгчдийн тал (алт олборлогчдын 53.6 хувь, жонш олборлогчдын 45.8 хувь) л нь ажиллаж, амьдарч буй сумандаа бүртгүүлжээ. Амьдарч буй орон нутгийнхаа засаг захиргааны үндсэн нэгжид бүртгүүлэх нь иргэний үүрэг бөгөөд иргэд бүртгэлд хамрагдаагүйгээс төрийн болон нийгмийн үйлчилгээ, мэдээлэл авах бүхий л боломжоо хязгаарлаж байгаа хэрэг юм.

Албан бусаар алт/жонш олборлогчид гэр бүлийн шилжилт хийж байна уу эсвэл ганцаарчилсан шилжилт хийж байна уу гэдгээс хамаараад тухайн газарт нийгмийн олон тулгамдсан асуудлууд илэрч байдаг.

*Өдгөө* 7.2 Шилжин ирэгчдийн хувь, шилжилтийн шинж байдал, шалтгаан, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Шилжилтийн шинж байдал</b>		
Ганцаарчилсан	10.7	27.0
Нөхөр/эхнэр	60.1	73.0
Хүүхдүүдтэйгээ	62.5	18.8
Эцэг, эх/хамаатан	31.3	0.0
Найз нөхөд, хамаатан бус	20.8	18.8
<b>Шилжин ирэлтийн шалтгаан</b>		
Алт/жонш олборлох, ажил хийх	89.0	81.2
Хамаатан саднаа бараадах	17.9	18.8
Зах зээлд ойртох	12.5	0.0
Байгаль цаг уурын таагүй нөхцөл байдал	3.1	0.0
<b>Нийт шилжин ирэгчдийн тоо</b>	<b>6490</b>	<b>415</b>

*Өдгөө* 7.2-д Олон сонголттой хариулт тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцүү биш.

Хүснэгт 7.2-д шилжин ирэгчдийн шинж байдал, шалтгааныг нарийвчлан харууллаа. Шилжин ирэгчдийн шинж байдлыг авч үзвэл, гэр бүлийн шилжилт зонхилж байна. Албан бусаар алт олборлохоор шилжин ирэгчид голдуу өөрсдийн гэр бүлээрээ тодруулбал, эхнэр/нөхөр болон хүүхдүүдтэйгээ хамт шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Харин жонш олборлогчдын хувьд хосууд хамтдаа шилжих хөдөлгөөнд илүүтэй оролцсон байлаа.

Шилжигчид ажил хийх, алт жонш олборлох шалтгаанаар шилжих хөдөлгөөнд илүүтэй оролцжээ. Өөрөөр хэлбэл, ажлын байрны хомсдолын улмаас алт, жонш олборлож амьжиргаагаа залгуулах нь шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаан болж байна. Цаашилбал, мэргэжил, боловсрол багатай хүмүүсийн хувьд орлого олох боломж албан бус секторт харьцангуй өндөр байгаагаас ашигт малтмалын салбарт албан бусаар хөдөлмөр эрхлэх сонирхлыг илүү татаж байна гэж дүгнэж болох юм.

Албан бусаар алт олборлож буй насанд хүрэгчдийн тал нь тухайн суманд 2-оос дээш жил ажиллаж байгаа хүмүүс ажээ. Алт олборлогчид тухайн суманд дунджаар 33.2 сар буюу 2 жил 9 сар орчим албан бусаар алт олборлох ажил хийж байгаа нь жонш олборлогчидтой харьцуулахад 13.7 сар буюу сараар урт байна (Хүснэгт 7.3).

*ᠪᠢᠨᠢᠨᠠᠨ* 7.3 Насанд хүрэгчдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Алт/жонш олборлож буй хугацаа</b>						
1-3 сар	14.2	14.2	14.2	46.5	8.9	29.6
4-6 сар	2.9	12.0	5.8	0.0	26.0	11.7
7-12 сар	11.7	28.1	16.9	17.8	12.7	15.5
1-2 жил	13.6	11.7	13.0	7.1	8.9	7.9
2+ жил	57.6	34.0	50.1	28.6	43.5	35.3
<i>ᠠᠳᠢᠶ᠋ᠠᠭᠡᠯᠠᠳ</i>	<i>36.4</i>	<i>29.4</i>	<i>34.1</i>	<i>23.8</i>	<i>29.7</i>	<i>26.4</i>
<b>Тухайн суманд алт/жонш олборлож буй хугацаа</b>						
1-3 сар	16.7	31.5	21.4	50.9	8.9	32.0
4-6 сар	5.9	9.1	6.9	2.3	32.3	15.8
7-11 сар	13.8	2.9	10.4	17.8	21.6	19.5
1-2 жил	5.4	14.0	8.1	7.1	13.2	9.9
2+ жил	58.2	42.5	53.2	21.9	23.9	22.8
<i>ᠠᠳᠢᠶ᠋ᠠᠭᠡᠯᠠᠳ</i>	<i>35.8</i>	<i>27.4</i>	<i>33.2</i>	<i>20.8</i>	<i>17.9</i>	<i>19.5</i>
<b>Өмнө нь өөр газарт алт олборлож байсан эсэх</b>						
Тийм	33.9	20.8	29.7	31.7	13.2	23.4
Үгүй	66.1	79.2	70.3	68.3	86.8	76.6
<b>Өөр газар уруу шилжих төлөвлөгөөтэй байгаа эсэх</b>						
Тийм	29.2	33.2	30.5	48.3	38.4	43.8
Үгүй	70.8	66.8	69.5	51.7	61.6	56.2
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>23202</b>	<b>10758</b>	<b>33960</b>	<b>2171</b>	<b>1775</b>	<b>3946</b>

Албан бусаар алт олборлогчдын 29.7 хувь, жонш олборлогчдын 23.4 хувь нь өмнө нь алт/жонш олборлох ажил хийж байжээ. Хүйсийн хувьд, албан бусаар энэ салбарт ажиллаж, тодорхой дадал хуримтлуулсан эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс харгалзан 13.1 ба 18.5 пунктээр өндөр байна.

### *Ирээдүйн шилжилт*

Албан бусаар алт олборлогчдын 30.5 хувь, жонш олборлогчдын 43.8 хувь нь одоогийн алт олборлож буй газраасаа өөр газар уруу шилжихийг хүсч байгаа

ажээ. Шилжихийг хүсч буй жонш олборлож буй эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Эндээс албан бусаар жонш олборлож буй эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд илүү оролцдог болох нь харагдаж байна.

Шилжихээр төлөвлөж буй хугацаа алт болон жонш албан бусаар олборлогчдын хувьд нэлээд ялгаатай байгааг Хүснэгт 7.4-ийн үр дүн харуулж байна. Тодруулбал, алт албан бусаар олборлогчдын 43.9 хувь нь хэзээ шилжих төлөвлөгөөтэй байгаагаа тодорхойлж чадахгүй байхад жонш албан бусаар олборлогчдын тал хувь нь (49.7 хувь) 1-3 сар ажиллаад шилжих төлөвлөгөөтэй байгаа ажээ. Энэ нь алтны уурхайд албан бусаар ажиллагчдын хувьд алтны гарц муудсан үед гарц ихтэй газар руу шилжих хөдөлгөөн илүү нэмэгддэг, харин жоншны уурхайд ажиллагчдын хувьд хүйтний улиралд ажил багасдагтай холбоотой байж болох юм. Хүйсээр авч үзэхэд, ирээдүйн шилжилт жонш олборлогчдын хувьд нэлээд ялгаатай байна.

**Өдгөө 7.4** Одоогийн ажиллаж байгаа газраас шилжихийг хүсэгчдийн хувийн жин, шилжихээр төлөвлөж буй хугацаа, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр

	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Шилжихээр төлөвлөж буй хугацаа</b>						
1-3 сарын дараа	36.7	34.7	36.0	81.9	0.0	49.7
4-өөс дээш сарын дараа	20.4	19.6	20.1	7.4	60.4	28.3
Хугацаа тодорхой бус	42.9	45.7	43.9	10.7	39.6	22.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>6769</b>	<b>3574</b>	<b>10343</b>	<b>1049</b>	<b>681</b>	<b>1730</b>

Алт олборлогчдын хувьд шилжихээр төлөвлөж буй гол шалтгаануудад уурхай, алтаа бараадах (52.4 хувь), амьжиргаагаа сайжруулах (25.8 хувь), гэр бүл, төрөл саднаа бараадах (19.4 хувь) зэрэг шалтгаанууд өндөр хувьтай байхад жонш олборлогчдын хувьд амьжиргаагаа сайжруулах (34.7 хувь), төрөл саднаа бараадах (13.9 хувь), жоншоо бараадах (13.0 хувь) зэрэг шалтгаанууд мөн л өндөр хувийг эзэлж байна (Зураг 7.2).



Харин цаашид шилжих төлөвлөгөөгүй байгаа шилжин ирэгчдийн хувьд уурхайгаа бараадах, нутаг усандаа дасан зохицсон зэрэг нь шилжихгүй байх гол шалтгаан болж байна (Зураг 7.3). Түүнчлэн, жонш албан бусаар олборлогчдын хувьд ажил, орлого найдвартай учраас шилжихгүй тэндээ ажиллана гэсэн хариултын хувь алт албан бусаар олборлогчдынхоос харьцангуй өндөр байна.

### 7.3 Албан бусаар алт/жонш олборлож буй насанд хүрэгчдийн амьдарч буй орчин

Албан бусаар алт/жонш олборлогчдын өрхийн зарим шинж байдлыг Хүснэгт 7.5-д олборлож буй ашигт малтмалын төрлөөр харууллаа.

*᠋ᠣᠯᠢ ᠶ᠋ᠠᠳᠤ 7.5 Насанд хүрэгчдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, олборлож буй ашигт малтмалын төрлөөр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Өрхийн байршил</b>		
Уурхайн орчимд	39.9	49.5
Тухайн сумын төвд	43.1	25.5
Өөр аймаг/хот/суманд	17.0	25.0
<b>Өрх уурхайгаас алслагдсан зай</b>		
2 хүртэлх км	6.4	56.1
2-10 км	17.8	13.0
11-20 км	23.3	0.0
21 ба түүнээс дээш км	52.5	30.9
<i>ᠠᠳᠢ ᠠᠳᠠᠭ*</i>	<i>47.1</i>	<i>11.8</i>
<i>ᠨᠣᠠᠢ ᠠᠳᠳᠣ ᠪᠠᠴᠠᠭᠡᠳᠣ*</i>	<i>75.8</i>	<i>17.0</i>
<b>Хариулагчийн одоо амьдарч буй газар</b>		
Уурхайн орчимд	49.0	75.8
Тухайн сумын төвд	38.9	17.8
Өөр аймаг/хот/суманд	12.1	6.4
<b>Ажил дээрх үндэс үснэс эх үүсвэр</b>		
Хамгаалалттай худаг**	12.3	10.7
Хамгаалалтгүй худаг	16.3	84.1
Булаг/горхи/гол/тогтоол ус	71.4	5.2
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

*᠋ᠣᠯᠢ ᠶ᠋ᠠᠳᠤᠶ᠋ᠦ:* \*Дундаж, стандарт хазайлтыг тооцохдоо өрх болон ашигт малтмал олборлож буй газрын хоорондын зайн талаар мэдээлэл өгөөгүй хүмүүсийг хасч тооцсон.

\*\* нэгдсэн сүлжээнээс усаа авдаг хариулагчид энэ ангилалд багтсан болно.


Албан бусаар алт олборлогчдын өрхийн дийлэнх нь уурхайн орчимд (39.9 хувь) болон уурхай байдаг сумын төвд (43.1 хувь) байрлаж байна. Харин жонш албан бусаар олборлогчдын өрхийн тал нь уурхайн орчимд (49.5 хувь) амьдардаг ажээ. Өрхөөс уурхай хүртэл алслагдсан дундаж зай алт олборлогчдын хувьд 47.1 км, харин жонш олборлогчдын хувьд 11.8 км байна. Албан бусаар алт олборлогчдын 49.0 хувь, жонш олборлогчдын 75.8 хувь нь уурхайн орчимд буюу алт/жонш олборлож буй газартаа амьдарч байна.

### Ундны цэвэр усны хангамж

Албан бусаар алт олборлогчдын ердөө 12.3 хувь, жонш олборлогчдын 10.8 хувь нь хамгаалалттай ундны усыг ажлын байран дээрээ хэрэглэдэг гэжээ. Ундны цэвэр усны хангамж албан бусаар алт олборлогчдын дунд илүү хүндрэлтэй, илүү асуудалтай байна. Тодруулбал, ил задгай усыг хүнсэндээ хэрэглэж буй байдал алт олборлогчдын хувьд хамгийн өндөр хувийн (71.4 хувь) жинг эзэлж байхад жонш олборлогчдын хувьд хамгаалалтгүй худгаас ундны усаа авч ашиглах явдал нийтлэг (84.1 хувь) байна.

### Уурхайн орчны ахуйн үйлчилгээ

Албан бусаар алт олборлож буй уурхайн орчимд ямар нэгэн үйлчилгээнүүд байдаг гэж алт олборлогчдын 85 хувь нь хариулсан байхад жонш албан бусаар олборлогчдын 36.2 хувь нь ийм хариултыг өгчээ (Зураг 7.4).



Хүснэгт 7.6-д уурхайн орчимд үзүүлдэг үйлчилгээний төрлийг давхардсан тоогоор дэлгэрүүлэн харууллаа. Албан бусаар жонш олборлогчдыг бодвол алт олборлогчид гэр дэлгүүр (78.5 хувь), тээврийн үйлчилгээ (62.4 хувь), хувийн жижиг үйлчилгээ (39.6 хувь)-г хүртэх боломж өндөр байна. Тэр ч байтугай зарим газар эмнэлгийн үйлчилгээг авч байна. Энэ нь хүн ам бөөгнөрч байгаа алтны уурхайн орчимд хувь хүний амиа аргацаасан жижиг бизнес эрхлэлт зэрэгцэн дэлгэрч байгаагийн илрэл юм. Харин уурхайн орчимд жонш олборлогчдын 25.6 хувь нь хувийн үйлчилгээ, 22.5 хувь нь гэр дэлгүүр ажилладаг гэж хариулжээ.

**᠋ᠣᠵᠢᠶ᠋ᠠᠳᠤ 7.6 Насанд хүрэгчдийн хувь, уурхайн орчимд байдаг үйлчилгээ, олборлож буй ашигт малтмалын төрлөөр**

Үйлчилгээний төрөл	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
Гэр дэлгүүрүүд	78.5	22.5
Хувийн үйлчилгээнүүд*	39.6	25.6
Тээврийн үйлчилгээ	62.4	0.0
Шатахуун нийлүүлэх үйлчилгээ	30.0	0.0
Эмнэлгийн үйлчилгээ	2.5	0.0
Засвар/багаж хэрэгсэл түрээслэх үйлчилгээ	14.2	0.0
Үйлчилгээ байхгүй	15.0	63.8
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

*᠋ᠣᠵᠢ ᠠᠶ᠋ᠠᠭᠦᠢ:* Олон сонголттой хариулт тул хувийн жингийн нийлбэр 100-тай тэнцүү биш.

\* Үсчин, хоол, цайны газар, гар дээрх худалдаа гэх мэт

#### 7.4 Ажлын зохион байгуулалт


Насанд хүрэгчид албан бусаар алт олборлох ажил эрхлээд дунджаар 34.1 сар буюу 2 жил 10 сар, жонш олборлох ажил эрхлээд дунджаар 26.4 сар буюу 2 жил 2 сар гаруй болж байна (Хүснэгт 7.3-ыг харна уу). Албан бусаар алт/жонш олборлохын хажуугаар өөр ажил эрхэлдэг гэж алтны уурхайд ажиллагчдын 27.8 хувь (эрэгтэйчүүдийн 28.1 хувь, эмэгтэйчүүдийн 27.1 хувь), жоншны уурхайд ажиллагчдын 16.0 хувь (эрэгтэйчүүдийн 16.7 хувь, эмэгтэйчүүдийн 15.1 хувь) нь тус тус хариулжээ. Эндээс албан бусаар жонш олборлогчидтой харьцуулахад алт олборлогчид, мөн эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд давхар ажил илүү эрхэлдэг болох нь харагдаж байна.

**᠋ᠣᠵᠢᠶ᠋ᠠᠳᠤ 7.7 Насанд хүрэгчдийн хувийн жин, давхар ажил эрхлэлт, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр**

Эдийн засгийн бусад үйл ажиллагаа	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Төрийн өмчийн байгууллага	11.2	9.7	10.7	43.5	0.0	25.0
Хувийн өмчийн байгууллага	27.6	13.8	23.3	0.0	41.8	17.8
Малчин	19.2	4.7	14.8	42.7	29.1	36.9
Хувиараа ажил, наймаа хийдэг	42.0	71.8	51.2	13.8	29.1	20.3
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>6512</b>	<b>2913</b>	<b>9425</b>	<b>363</b>	<b>268</b>	<b>631</b>

Албан бусаар алт/жонш олборлохын хажуугаар давхар ажил хийдэг насанд хүрэгчдийн талаас илүү хувь нь хувиараа ажил, наймаа эрхлэгчид болон малчид байна (Хүснэгт 7.7). Бэлэн мөнгөний хомсдол (ялангуяа малчдын хувьд), цалингийн доогуур түвшин нь хэд хэдэн төрлийн ажил давхар хийж, орлогоо нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Тухайлбал, албан бусаар алт олборлож буй газарт насанд хүрсэн бараг 10 хүн тутмын нэгийг нь өрх гэр дэлгүүр (26.1 хувь) ажиллуулах, үсчин, хоолны газар (68.2 хувь) гэх мэт хувийн жижиг үйлчилгээ үзүүлэх бизнес эрхэлж байгаа ажээ. Жоншны уурхай дээр албан бусаар ажиллаж буй 50 хүн буюу 1.3 хувь (хувийн жижиг бизнес эрхэлж байгаа) нь ийм хариултыг өгсөн байна.

Зураг 7.5-д албан бусаар алт/жоншны уурхайд ажиллахад гол хамтран ажилладаг хүмүүсийн тоог харуулав.



Албан бусаас алт/жонш олборлогчдын ажлын зохион байгуулалт ямар байгааг сонирхож үзвэл, алт олборлогчид 3-аас олуулаа ажиллах нь илүү байхад жонш олборлогчид нэгээс хоёулаа (65.4 хувь) нэг баг болж ажиллах нь илүү байна (Зураг 7.5). Баг болж хамтран ажиллаж буй хүмүүс нь алт олборлогчдын хувьд голдуу найз нөхөд (50.6 хувь), гэр бүлийн гишүүд (42.2 хувь) болон хамаатан садан (26.6 хувь) нь байхад жонш олборлогчдын хувьд гэр бүлийн гишүүдээс (42.1 хувь) гадна танилууд (35.3 хувь) нь байдаг байна.

## 7.5 Ажлын нөхцөл, хөдөлмөр хамгаалал

### *Ажлын үргэлжлэх хугацаа*

Албан бусаар алт/жонш олборлох ажил хийж буй насанд хүрэгчдийн ажлын үргэлжлэх хугацааг Хүснэгт 7.8-д ашигт малтмалын төрлөөр дэлгэрэнгүй харууллаа.

Албан бусаар гар аргаар алт/жонш олборлох ажил нь ажиллах хүчний зарцуулалт ихтэй үйл ажиллагаа юм. Гадаа задгай орчинд олон цагаар ажилладаг, улирлын чанартай, цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалсан ажил ч энэ салбарт албан бусаар ажиллаж буй насанд хүрэгчдийн 39.1 хувь нь бүтэн жилийн туршид ажиллаж байна. Амралттай болон их хэмжээний мөнгөний хэрэгцээ гарсан үедээ ажилладаг алт олборлогчдын хувийн жин (22.9 хувь), жонш олборлогчдынхоос (13.4 хувь) өндөр байна. Хүйсээр авч үзвэл, жилийн турш ажилладаг алт олборлож буй эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс 1.5 дахин их байхад жонш олборлолт дээр эсрэгээр жилийн турш ажилладаг эмэгтэйчүүдийн хувийн жин эрчүүдийнхээс бараг 2 дахин их байна.

*ᠪᠦᠵᠡᠨᠢᠶᠦᠨ* 7.8 Насанд хүрэгчдийн хувийн жин, ажлын үргэлжлэх хугацаа, олборлож буй ашигт малтмалын төрөл, хүйсээр

Ажлын хугацаа	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Алт, жонш олборлох ажлыг байнга хийдэг эсэх</b>						
Бүтэн жилийн турш	43.8	28.6	39.1	24.0	43.7	32.9
Улирлын чанартай	31.2	52.9	38.0	64.1	41.1	53.7
Амралтаараа	25.0	18.5	22.9	11.9	15.2	13.4
<b>Сүүлийн долоо хоногт ажилласан өдөр</b>						
1-3	25.5	30.8	27.1	14.9	25.0	19.4
4-6	23.8	25.5	24.4	43.3	14.3	30.3
7	50.7	43.7	48.5	41.8	60.7	50.3
<i>ᠠᠳᠢᠶᠦᠨ</i>	<i>5.3</i>	<i>4.9</i>	<i>5.2</i>	<i>5.3</i>	<i>5.6</i>	<i>5.5</i>
<b>Сүүлийн долоо хоногт өдөрт ажилласан цаг</b>						
1-7	14.7	22.4	17.1	28.3	19.9	24.6
8	22.9	22.5	22.8	35.9	49.1	41.8
9 ба түүнээс дээш	62.4	55.1	60.1	35.8	31.0	33.6
<i>ᠠᠳᠢᠶᠦᠨ</i>	<i>9.9</i>	<i>9.8</i>	<i>9.9</i>	<i>8.5</i>	<i>8.5</i>	<i>8.5</i>
<i>MIN</i>	<i>1</i>	<i>1</i>	<i>1</i>	<i>5</i>	<i>5</i>	<i>5</i>
<i>MAX</i>	<i>18</i>	<i>18</i>	<i>18</i>	<i>13</i>	<i>12</i>	<i>13</i>
<b>Ажиллаж байх үед амралтын өдөр байдаг эсэх</b>						
Байдаг	48.6	41.3	46.3	80.4	56.3	69.5
Байдаггүй	51.4	58.7	53.7	19.6	43.7	30.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>23202</b>	<b>10758</b>	<b>33960</b>	<b>2171</b>	<b>1775</b>	<b>3946</b>

Судалгаанаас өмнөх долоо хоногт ажилласан ажлын өдрийн дундаж хугацаа алт болон жонш олборлогчдын хувьд нэлээд ойролцоо (харгалзан 5.2 ба 5.5 өдөр) байв. Гэхдээ хүйсийн хувьд, бага зэрэг ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, алтны уурхай дээр 7 хоног бүтэн ажилласан эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байхад, жоншны уурхайд энэ үзүүлэлт эмэгтэйчүүдийн хувьд өндөр гарчээ.

Сүүлийн долоо хоногт өдөрт ажилласан дундаж хугацааг авч үзэхэд алтны уурхайд ажиллагчид 9.9 цаг ажилласан байхад жоншны уурхайд ажиллагчдын хувьд өдрийн ажлын дундаж хугацаа 1.4 цагаар доогуур буюу 8.5 цаг байв. Судалгаанаас өмнөх долоо хоногт өдөрт 9 ба түүнээс дээш цаг ажилласан насанд хүрэгчдийн хувийн жин алт олборлогчдын дунд мөн өндөр байна. Ашигт малтмалын энэ төрөлд албан бусаар ажиллагчид хамгийн багадаа ганц цаг, хамгийн ихдээ 18 цаг өдөрт ажилласан байхад жонш олборлогчид хамгийн бага нь 5 цаг, хамгийн урт нь 13 цаг тус тус ажиллажээ. Судалгааг бид намрын сүүлийн сард авсан тул ажлын цагийн үргэлжлэх хугацаа урт байсан байж болох талтай.

Уурхайд ажиллаж байх үед амралтын өдөр гардаг гэж алт олборлогчдын тал хүрэхгүй (46.3) хувь нь хариулсан байхад жонш олборлогчдын гуравны хоёроос илүү (69.5 хувь) нь амралтын өдөр гардаг гэжээ. Аль ч уурхайн хувьд, амралтын өдөр гардаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс бага байна. Магадгүй албан бусаар алт, жонш олборлох



хөдөлмөр хуваарилалт нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд арай ялгаатай жишээ нь, эрэгтэйчүүд илүү хүнд ажлуудыг арай бага хугацаанд, эмэгтэйчүүд хөнгөн ажлуудыг харьцангуй удаан хугацаанд хийдэгтэй холбоотой байж болох юм. Нөгөөтэйгүүр эмэгтэйчүүд ажилд илүү хариуцлагатай ханддаг, гэрийн болон орлоготой ажлыг хослуулж хийдэг, эрчүүдийг бодвол илүү сэтгэлийн тэнхээтэй байдаг, амралтын өдөр гаргаж чаддаггүй зэргээр мөн тайлбарлаж болох талтай.

### **Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа**

Уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт шаардлагын талаар албан бусаар алт олборлогчдын 65.9 хувь, жонш олборлогчдын 41.3 хувь нь огт мэдэхгүй гэжээ (Хүснэгт 7.9).

**Өгий үгд 7.9 Насанд хүрэгчдийн хувийн жин, аюулгүй, ажиллагаа, эрүүл мэндийн стандарт мөрдөж буй байдал, зарим сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр**

Сонгосон үзүүлэлтүүд	Аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн стандарт							
	Алт				Жонш			
	Мэднэ, дагаж мөрддөг	Мэднэ, дагаж мөрддөггүй	Мэдэхгүй	Бүгд	Мэднэ, дагаж мөрддөг	Мэднэ, дагаж мөрддөггүй	Мэдэхгүй	Бүгд
<b>Нас</b>								
25 хүртэл	10.1	15.8	74.1	<b>100.0</b>	0.0	0.0	100.0	<b>100.0</b>
25-29	0.0	6.5	93.4	<b>100.0</b>	64.5	0.0	35.5	<b>100.0</b>
30-34	25.2	22.0	52.7	<b>100.0</b>	35.2	24.5	40.3	<b>100.0</b>
35-39	22.4	7.3	70.4	<b>100.0</b>	36.9	18.5	44.6	<b>100.0</b>
40-44	45.8	16.9	37.3	<b>100.0</b>	40.2	0.0	59.8	<b>100.0</b>
45 ба дээш	18.9	37.7	43.4	<b>100.0</b>	52.2	16.8	31.0	<b>100.0</b>
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	19.4	17.8	62.8	<b>100.0</b>	71.0	10.2	18.8	<b>100.0</b>
Эмэгтэй	11.6	15.8	72.5	<b>100.0</b>	19.8	8.2	72.0	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	<b>17.0</b>	<b>17.2</b>	<b>65.9</b>	<b>100.0</b>	<b>49.4</b>	<b>9.3</b>	<b>41.3</b>	<b>100.0</b>

Ийнхүү хөдөлмөрийн аюулгүй талаар мэдлэг бага, мэдэж байгаа ч дагаж мөрдөхгүй байгаа нь осол гэмтэлд өртөх гол шалтгаан болж байна. Ялангуяа, албан бусаар алт/жонш олборлож буй 30 хүртэл насны залуучуудын дунд энэ талаар мэдлэгийн түвшин нэлээд доогуур байна.

Аюулгүйн болон эрүүл ахуйн стандарт шаардлагыг мэдэхгүй гэж хариулсан алт болон жонш олборлож буй эмэгтэйчүүдийн хувийн жин (алт 72.5 хувь, жонш 72.0) эрэгтэйчүүдийнхээс (алт 62.8 хувь, жонш 18.8 хувь) нэлээд өндөр байна.

Эндээс хөдөлмөр хамгаалал, уул, уурхайн салбарын аюулгүй ажиллагааны талаар албан бусаар хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн дунд сургалт, сурталчилгаа илт үгүйлэгдэж байгаа нь тодорхой харагдаж байна.

Насанд хүрэгчдийн ердөө 21.4 хувь л аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдээлэл авч байжээ. Мэдээллийг өмнө нь албан ёсоор ажиллаж байсан уурхайн зүгээс болон хамаатан садан, найз нөхдөөсөө голдуу авсан байна.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хамгийн наад захын шаардлага бол ажлын хувцас хэрэгсэл, тэдгээрийн хэрэглээ юм. Албан бусаар алт/жонш олборлогчдын ажлын хувцасны хэрэглээ муу байна (Хүснэгт 4.10). Тухайлбал, алтны уурхайд ажиллахад наад зах нь амны маск чухал атал тэнд ажиллагчдын ердөө тал нь л хэрэглэдэг байх жишээтэй.

*Өгүүлэл 7.10* Насанд хүрэгчдийн хувийн жин, хамгаалах хэрэгслийн ашиглалтын байдал, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Хамгаалах хэрэгсэл	Ашигт малтмалын төрөл					
	Алт			Жонш		
	Үргэлж	Хааяа	Үгүй	Үргэлж	Хааяа	Үгүй
Усны гутал	31.5	36.9	31.6	4.8	3.8	91.4
Даавуун бээлий	80.9	12.8	6.3	89.1	7.2	3.7
Каска	8.4	5.5	86.1	14.6	12.6	72.8
Резинэн бээлий	64.3	25.2	10.5	27.3	8.8	63.9
Арьсан гутал	42.4	14.4	43.2	50.6	9.4	40.0
Маск	24.8	19.4	55.8	38.9	21.1	40.0
Чихний бөглөө	3.8	3.2	93.0	4.1	0.0	95.9
Малгайтай цамц	83.2	10.4	6.4	22.6	28.1	49.3

### Хөдөлмөрийн нөхцөл

Албан бусаар алт олборлож буй насанд хүрэгчдийн 90 гаруй хувь нь ажлын нөхцөлөө хүнд (77.0 хувь) болон хүндэвтэр (17.2 хувь) гэж үнэлсэн байхад жонш олборлогчдын 80 гаруй хувь нь хүнд (59.8 хувь) болон хүндэвтэр (22.1 хувь) гэжээ (Хүснэгт 7.11).

*Өгүүлэл 7.11* Насанд хүрэгчдийн хувийн жин, ажлын нөхцөл байдлын талаарх үнэлэмж, зарим сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Сонгосон үзүүлэлтүүд	Ажлын нөхцөлийн үнэлэмж							
	Алт				Жонш			
	Хүнд	Хүндэвтэр	Хөнгөн	Бүгд	Хүнд	Хүндэвтэр	Хөнгөн	Бүгд
<b>Нас</b>								
25 хүртэл	82.1	16.8	1.1	<b>100.0</b>	0.0	23.8	76.2	<b>100.0</b>
25-29	66.3	23.2	10.5	<b>100.0</b>	55.8	36.8	7.5	<b>100.0</b>
30-34	90.7	9.0	0.3	<b>100.0</b>	50.4	16.4	33.2	<b>100.0</b>
35-39	82.9	15.1	2.0	<b>100.0</b>	84.3	15.7	0.0	<b>100.0</b>
40-44	86.1	6.9	6.9	<b>100.0</b>	39.2	26.3	34.5	<b>100.0</b>
45 ба дээш	48.5	31.0	20.5	<b>100.0</b>	100.0	0.0	0.0	<b>100.0</b>
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	77.6	17.5	4.9	<b>100.0</b>	56.6	29.4	14.0	<b>100.0</b>
Эмэгтэй	75.8	16.4	7.9	<b>100.0</b>	63.8	13.2	23.0	<b>100.0</b>
<b>Бүгд</b>	<b>77.0</b>	<b>17.2</b>	<b>5.8</b>	<b>100.0</b>	<b>59.8</b>	<b>22.1</b>	<b>18.0</b>	<b>100.0</b>

Насны бүлгээр дээрх үнэлгээг задалж үзэхэд нэлээд ялгаатай дүр төрх ажиглагдаж байна. Хүйсийн хувьд, алт олборлож буй эмэгтэйчүүдийн 75.8 хувь нь ажлын нөхцөлөө асар хүнд гэж хариулсан байдал эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1.8 пунктээр бага байна. Харин жонш олборлогчдын хувьд ажлын нөхцөлөө хүнд үзэж байгаа эмэгтэйчүүдийн (63.8) хувь эрэгтэйчүүдийнхээс 7.2 пунктээр илүү байна.


## 7.6 Эрүүл мэндийн зарим асуудлууд

Албан бусаар алт олборлож буй насанд хүрэгчдийн 13.8 хувь, жонш олборлож буй насанд хүрэгчдийн 12.1 хувь нь ажлаа хийж байхдаа осолд орж байсан бөгөөд алтны уурхайд эрэгтэйчүүд, харин жоншны уурхайд эмэгтэйчүүд илүүтэй осолд өртсөн байна. Осолд өртөгсөд голдуу нүх, хонгил руу унасан хүмүүс байгаа бөгөөд сумын эмнэлгээс тусламжийг түлхүү авчээ.

Уурхайд ажиллаж эхэлснээс хойш эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт гарсан гэж алт олборлогчдын 41.3 хувь (эмэгтэйчүүдийн 43.9 хувь, эрэгтэйчүүдийн 40.1 хувь), жонш олборлогчдын 17.3 хувь (эмэгтэйчүүдийн 26.9 хувь, эрэгтэйчүүдийн 9.4 хувь) нь хариулжээ.


### Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт

Алт/жонш албан бусаар олборлож буй насанд хүрэгчдийн 80 гаруй хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдан, эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээлгэсэн ч тэдгээрийн дөрөвний нэг гаруй хувь нь даатгалын хураамжаа төлөөгүй байгаа ажээ. Эрүүл мэндийн даатгалд огт хамрагдаагүй ажиллагчдын хувьд эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломж бага байна. Хүйсийн хувьд, энэ салбарт албан бусаар ажиллаж буй эмэгтэйчүүдийн 25 хувь нь эрүүл мэндийн даатгалд огт хамрагдаагүй байгаа нь даатгалгүй эрэгтэйчүүдийнхээс 9.5 пунктээр илүү байна.



### Согтууруулах ундааны хэрэглээ

Хүнд хүчир ажил хийсний дараа ажлын ачааллаа тайлахын тулд согтууруулах ундааны зүйлсийн хэрэглээ албан бусаар алт/жонш олборлогчдын дунд түгээмэл байна (Зураг 7.7). Тухайлбал, архины хэрэглээ 44 хүртлэх насны хүн амын дунд нэлээд ойролцоо байгаа бөгөөд харин 45 ба түүнээс дээш насныханы хувьд уг хэрэглээ нэлээд доогуур байна.



## 7.7 Хүмүүс хоорондын зөрчилдөөн

Нэгэнт ашигт малтмалын салбарт хууль бусаар ажил эрхэлж байгаа болохоор тэнд ажиллаж буй хүмүүсийн хооронд болон хамгаалалтын албаныхны хооронд зөрчил, маргаан хэр түгээмэл тохиолдгийг тодруулан Хүснэгт 7.12–д үр дүнг харуулахыг зорьсон юм.

*Ойи үйд 7.12 Насанд хүрэгчдийн хувийн жин, хүмүүсийн хоорондох зөрчил, олборлож буй ашигт малтмалын төрлөөр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Хүмүүс ба цагдаагийн* хоорондын зөрчилдөөн</b>		
Үргэлж	18.0	2.6
Заримдаа	11.9	10.6
Хааяа	33.3	13.3
Зөрчил гардаггүй	32.3	70.7
Мэдэхгүй	4.5	2.8
<b>Хүмүүсийн хоорондын зөрчилдөөн</b>		
Үргэлж	26.7	8.0
Заримдаа	16.1	2.8
Хааяа	24.5	22.3
Зөрчил гардаггүй	30.4	66.9
Мэдэхгүй	2.3	0.0
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

*Ойи үйд:* \* - цагдаа, хамгаалалтын албаны хүмүүсийг хамтад авч үзэв.

Албан бусаар алт/жонш олборлогчид болон цагдаа, харуул хамгаалалтынхны хооронд зөрчил гардаг гэж алт олборлогчдын 63.2 хувь, жонш олборлогчдын 26.5 хувь нь тус тус хариулжээ. Эндээс алтны уурхайд зөрчил харьцангуй их гардаг нь харагдаж байна.

Албан бусаар алт олборлогчдын 27.0 хувь нь ажил хийж байхад хэн нэгэн дарамт, шахалт үзүүлдэг гэсэн байхад жонш олборлогчдын 9.3 хувь нь энэ хариултыг өгчээ. Уурхайн хамгаалалтын албаныхан болон цагдаагийн ажилтнууд, нутгийн уугуул иргэд, засаг, захиргааны зүгээс дарамт, шахалт үзүүлдэг гэсэн хариултын хувь хамгийн өндөр байна. Үзүүлж буй дарамт, шахалт нь ажиллуулахыг зөвшөөрөхгүй байх, хэл амаар доромжлох, мөнгө нэхэх, зодох зэргээр илэрдэг ажээ.

## 7.8 Орлого ба амьжиргааны түвшний өөрчлөлт

Албан бусаар алт, жонш олборлогчдын сарын дундаж орлогыг ашигт малтмалын төрлөөр Хүснэгт 7.13-д харуулав.

*᠋ᠣᠵᠢ ᠶ᠋ᠠᠳ 7.13* Насанд хүрэгчдийн хувийн жин, орлогын сонгосон үзүүлэлт, олборлож буй ашигт малтмалын төрлөөр

Орлогын сонгосон үзүүлэлтүүд	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
<b>Алт олборлолтоос сард олдог орлого (төгрөг*)</b>		
50.000 хүртэл	45.8	25.2
50.000-100.000	23.0	35.2
100.001-150.000	10.0	11.6
150.001-200.000	10.0	16.3
200.001 ба дээш	11.1	11.7
<b>Алт олборлолтоос сард олдог орлогын дундаж хэмжээ (төгрөг)</b>	<b>119026.2</b>	<b>122214.3</b>
<b>7 хоногт дунджаар олборлодог алт (грамм), жоншны (кг) хэмжээ</b>	<b>4.758</b>	<b>5287.5</b>
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

*᠋ᠣᠵᠢ ᠶ᠋ᠠᠳᠦᠭᠦ:* \* 1 ам.доллар= 1227 төгрөг


Албан бусаар алт олборлож буй насанд хүрэгчдийн 45.8 хувь нь сард дунджаар 50000 төгрөгөөс доогуур орлого олж байхад жонш олборлогчдын хувьд ийм орлоготой хүн амын хувийн жин 20.6 пунктээр доогуур байна.

Албан бусаар алт олборлогчид долоо хоногт дунджаар 4.758 грамм алт олборлож, сардаа 119026 төгрөгийн орлого олж байхад жонш олборлогчид долоо хоногт 5287.5 килограмм жонш олборлож, сардаа 122214 төгрөгийн орлоготой ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, жоншны уурхайд албан бусаар ажиллагчдын сарын дундаж орлого нь алтны уурхайд ажиллагчдаас даруй 3188 төгрөгөөр их байна.

Албан бусаар алт/жоншны уурхайд ажиллагчдын дийлэнх (алт олборлогчдын 98.2 хувь, жонш олборлогчид 100 хувь) нь олборлосон ашигт малтмалаа бэлэн мөнгөөр борлуулдаг ч олсон орлогоосоо алт олборлогчдын 30.8 хувь, жонш олборлогчдын 40.8 хувь нь ямар нэгэн татвар, хураамж төлдөг гэжээ.

Ер нь алт, жонш олборлох үйл ажиллагааг эрхлээд ахуй амьдрал, амьжиргаа нь сайжирсан гэж насанд хүрэгчдийн 35.6 хувь, өөрчлөлт гараагүй гэж 60.3 хувь нь үзсэн байна. Зураг 7.8-д алт/жонш олборлох ажил хийж эхэлснээс хойш өрхийн амьжиргаанд нь өөрчлөлт гарсан эсэхийг ашигт малтмалын төрлөөр

задалж харуулав. Аж байдал доройтсон гэж алт олборлогчдын 1.8 хувь хариулжээ.



### 7.9 Ажиллаж буй хүүхдийн талаарх насанд хүрэгчдийн үзэл бодол

Албан бусаар алт/жонш олборлож буй насанд хүрэгчидтэй хамт амьдарч байгаа хүүхдийн тоог олборлож буй ашигт малтмалын төрлөөр Зураг 7.9-д харууллаа.

Эндээс албан бусаар алт, жонш олборлогчдын 40 гаруй хувь нь 18 хүртэлх насны хүүхэдтэй хамт амьдардаг гэжээ. Уурхайд албан бусаар ажиллаж буй хүмүүстэй хамт амьдардаг хүүхдүүдээс алт эсвэл жонш олборлох ажиллагаанд оролцдог гэж насанд хүрэгчдийн 28.1 хувь (алт олборлогчдын 28.2 хувь, жонш олборлогчдын 27.4 хувь) хариулжээ.

Насанд хүрэгчдийн мэдээлж байгаагаар насанд хүрэгчидтэй хамт байдаг хүүхдийн 8.4 хувь (1379 хүүхэд) нь алт/жонш олборлох ажилд оролцохоос гадна өөр төрлийн уурхайд ажиллах (45.6 хувь), тоглоом тоглуулах (20.0 хувь), мал маллах (17 хувь), уурхайн орчимд хүнсний зүйлс, гэр дэлгүүрт бараа зарах (14.4 хувь) зэргээр давхар ажил хийдэг байна.

Яагаад хүүхдүүдийг энд ажиллуулж байна вэ гэсэн асуултанд алтны уурхай дээр 18 хүртэлх насны хүүхэдтэй хамт амьдарч байгаа насанд хүрэгчдийн 30.8 хувь нь хүүхдүүд өөрсдөө сонирхолтой байдаг, 30.6 хувь нь өөрсдөө өрхийнхөө амьжиргаанд хувь нэмэр оруулахыг хүсдэг, 19.7 хувь нь зөвхөн зуныхаа амралтаар л ажилладаг гэжээ. Харин жоншны уурхайн хувьд, зөвхөн зуныхаа амралтаар (54.6 хувь) болон эцэг эхдээ туслахыг өөрсдөө хүсдэг (45.4 хувь) учраас насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулдаг гэсэн байна.



Алт/жоншны уурхай дээр ажиллаж байгаа хүүхдүүдээ ийм төрлийн ажил хийлгэхгүй хөндийрүүлэх хэрэгтэй гэж насанд хүрэгчдийн 76.2 хувь нь үзжээ. Гэхдээ алт олборлогчдын хувьд ийм хариулт өгсөн насанд хүрэгчдийн хувийн жин (76.9 хувь) жонш олборлогчидтой харьцуулахад 9.1 пунктээр илүү байна.

Уурхайд ажиллаж буй насанд хүрээгүй дээрх хүүхдүүдийн 23.7 хувь нь сургуульд огт сурдаггүй ажээ. Сургуульд сурахгүй байгаа гол шалтгаан нь хүүхэд сургуульд сурах насанд хүрээгүй, мөн өрх мөнгөний боломжгүй байгаа явдал гэж насанд хүрэгчид хариулсан байна.


### 7.10 Албан бусаар алт/жонш олборлогчдын цаашдын хандлага

Насанд хүрэгчдийн 52.9 хувь (алт олборлогчдын 52.4 хувь, жонш олборлогчдын 57.9 хувь) нь алт/жонш олборлох ажлаа үргэлжүүлэн хийх хандлагатай байна (Хүснэгт 7.14).

**Өзгii үяò 7.14 Насанд хүрэгчдийн хувийн жин, цаашид ажлаа үргэлжлүүлэн хийх эсэх, олборлож буй ашигт малтмалын төрлөөр**

Цаашдын ажлаа үргэлжлүүлэн хийх эсэх	Ашигт малтмалын төрөл	
	Алт	Жонш
Үргэлжлүүлнэ	52.4	57.9
Үргэлжлүүлэхгүй	33.5	33.7
Мэдэхгүй	14.1	8.4
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>33960</b>	<b>3946</b>

Хэр удаан энэ салбарт албан бусаар ажиллахыг тодруулж асуухад тэдний талаас илүү нь тодорхой хугацаа төлөвлөгөөгүй байв (Зураг 7.10). Ялангуяа алтны уурхайд ажиллагчдын хувьд энэ талаар тодорхойгүй байдал илүү өндөр байлаа.



Тухайлбал, алт олборлогчдын 76.9 хувь, жонш олборлогчдын 45.2 хувь нь цаашид хэдий удаан ажиллахаа төлөвлөж чадахгүй байв.

***Албан бусаар алт, жонш олборлолтыг зохицуулах талаарх насанд хүрэгчдийн санал***

Насанд хүрэгчдийн 43.7 хувь нь албан бусаар алт, жонш олборлолтыг тусгай хуулиар, гуравны нэг нь буюу 34.3 хувь нь үндэсний хэмжээний хөтөлбөр, төслөөр зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Албан бусаар алт/жонш олборлогчдын өнөөгийн байдлыг сайжруулахын тулд төр засгаас юуны өмнө энэ салбарт ажиллах зөвшөөрөл өгөх (33.9 хувь), эрүүл мэнд, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах (23.6 хувь), хяналт, зохион байгуулалтын арга хэмжээ авах (10.5 хувь) шаардлагатай байна гэжээ.



## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

---

“Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-гаар албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн тоо, тархалт, шинж байдал, ажил эрхлэлтийн талаархи холбогдох мэдээлэл, үр дүнг тодруулан харууллаа. Мөн албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхдүүдийн эцэг/эх болон ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи хандлага, үзэл бодлыг тодорхойлохыг зорьсон билээ. Судалгаагаар дараахь ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Судалгаанд хамрагдсан албан бусаар алт/жонш олборлогчдын багагүй хувийг шилжигчид бүрдүүлж байсан ба шилжигчдийн хувьд оршин сууж байгаа сумандаа бүртгүүлэхгүй байх явдал түгээмэл байлаа. Энэ нь шилжигчдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх боломжийг хязгаарлаж байгаа тул тэднийг бүртгэлжүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
2. Алт, жонш олборлож байгаа хүүхдүүд, нэн ялангуяа шилжигч хүүхдүүдийн дунд бичиг үсгийн мэдлэггүй, сургууль завсардсан хүүхдүүдийн хувь өндөр байгаад анхаарал хандуулж, 16 хүртэлх бүх насны хүүхдүүдэд суурь боловсрол заавал эзэмшүүлэх хуулийн хэрэгжилтийг хөдөө орон нутагт эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.
3. Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн хувьд ганцаараа шилжин ирж ажиллаж буй тохиолдол цөөнгүй байна. Нөгөөтэйгүүр, хүүхдүүддээ ажил эрхлэхийг санал болгосон, улмаар ажиллахыг шахаж шаардсан эцэг/эхчүүд байсаар байгаа нь тэдний хүүхэддээ тавих анхаарал, халамжийг дээшлүүлэх, албан бусаар алт, жонш олборлох ажлын хор холбогдлыг эцэг/эхчүүдэд таниулах үйл ажиллагааг явуулах хэрэгцээ байсаар байгааг илтгэж байна.
4. Хүүхэд нь алт/жоншны уурхайд ажиллаж буй өрхүүдийн сарын дундаж орлогын дийлэнхийг алт/жонш олборлолтоос олсон орлого бүрдүүлж байгаа бөгөөд ерөнхийдөө өрхийн амьжиргааны түвшний доогуур байдал хүүхдүүдийн алт/жонш олборлох гол шалтгаан болж байна. Нөгөөтэйгүүр, албан бусаар алт, жонш олборлосноос хойш энд ажиллаж буй хүмүүсийн амьжиргааны түвшин дээшилсэн гэж үзэж буй тохиолдол багагүй байлаа. Иймээс алт/жонш олборлох явдал бол хүмүүсийн амьжиргаагаа залгуулах үндсэн үйл ажиллагаа гэдгийг харгалзан үзэж, гар аргаар алт/жонш олборлох үйл ажиллагааг таслан зогсоох бус, хууль эрх зүйн хүрээнд нэгдсэн зохион байгуулалтанд оруулах зохицуулалтын үйл ажиллагаа шаардлагатай байна.
5. Албан бус алт/жоншны олборлолтыг дан ганц төрийн бодлогоор зохицуулах боломжгүй учраас тухайн сум, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас албан бусаар алт, жонш олборлож буй хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр холбогдох зохицуулалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй.

6. Энэ салбарт албан бусаар ажиллаж буй хүүхэд, насанд хүрэгч, хүүхдээ ажиллуулж буй эцэг/эх, ажил олгогчдын дунд алт/жонш олборлох хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт шаардлагын талаарх мэдлэгийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг явуулах, үүнд төрийн болон төрийн бус байгууллагыг идэвхтэй татан оролцуулах хэрэгтэй байна.
  
